

Ц.Гантулга, Л.Алтанзаяа, Ч.Болдбаатар,  
П.Мягмар, Б.Нацагдорж, Х.Эрдэнэтулга

# МОНГОЛЫН ТҮҮХ

## XI

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн  
11 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Гурав дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2019 он

ДАА 373  
ННА 74,2  
М-692

МОНГОЛЫН ТҮҮХ XI: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 11 дүгээр ангийн сурх бичиг. (Гантулга Ц. ба бус; Ред. Хишигт Н., -УБ., 2017- 72x)

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурх бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр, эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурх бичгийн талаарх санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99978-61-41-2

## ГАРЧИГ

**Сурах бичиг ашиглах зөвлөмж .....** 4

### УДИРТГАЛ

1. Эх түүхээ эрхэмлэн судалцгаая ..... 5
2. XVII-XXI зууны эхэн үеийн Монголын түүхийн хураангуй товчоон ..... 6

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. XVII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕЙН МОНГОЛ

1. Монгол улс Манжийн эрхшээлд орсон нь ..... 7
2. Халимаг, Буриад Монголыг Орос улс эзэрхсэн нь ..... 10
3. Монгол Улс тусгаар тогтнолоо алдсан шалтгаан ..... 12
4. Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгэм, соёл ..... 13
5. Монголчуудын тусгаар тогтнолын төлөө тэмцэл, хөдөлгөөн ..... 15

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС СЭРГЭН МАНДСАН НЬ (1911-1924)

1. 1911 оны хувьсгалын ялалт, ач холбогдол ..... 19
2. Монгол Улсын сэргэн мандлын эхлэл (1911-1920 он) ..... 21
3. Монгол Улсын тусгаар тогтнолын хувь заяа ..... 23
4. 1921 оны хувьсгалын ялалт, ач холбогдол ..... 25
5. Хэмжээт цаазат хаант Монгол Улс (1921-1924 он) ..... 28
6. Монгол Улсын хөгжлийн талаарх үзэл баримтлалууд ..... 30

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. БНМАУ СОЦИАЛИЗМЫН ЗАМААР (1924-1990)

1. Монгол Улсын анхдугаар Үндсэн хууль ..... 33
2. Улс орноо хөгжүүлэх чиг хандлага, зөрөлдөөн ..... 34
3. 1932 оны зэвсэгт бослого, дүрвэх хөдөлгөөн ..... 38
4. Шинэ эргэлтийн жилүүд дэх өөрчлөлт шинэчлэл, ахиц дэвшил ..... 40
5. Улс төрийн хэлмэгдүүлэлт: үйл явц, үр дагавар ..... 42
6. Дэлхийн II дайны үеийн БНМАУ, тусгаар тогтнолын бэхжилт ..... 44
7. БНМАУ-д социализм байгуулах оролдлого ..... 48
8. БНМАУ-ын нийгэм-эдийн засагт гарсан өөрчлөлт ..... 52
9. БНМАУ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын хөгжилт ..... 54
10. БНМАУ-ын гадаад харилцаа ..... 56

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС АРДЧИЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ЗАМААР (1990 оноос хойш)

1. 1990 оны ардчилсан хувьсгал: өрнөл, ялалт, ач холбогдол ..... 59
2. Улс төрийн тогтолцоонд гарсан өөрчлөлт ..... 63
3. Нийгэм, эдийн засгийн тогтолцооны шинэчлэл ..... 65
4. Оюун санааны хүрээн дэх хувьсал өөрчлөлт ..... 68
5. Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжсөн нь ..... 69

Нэмэлт болгон ашиглах бүтээлийн жагсаалт ..... 72

## Сурах бичиг ашиглах зөвлөмж

Сурах бичиг нь бүлгийн он цагийн шулуун, сэдвийн түлхүүр асуулт, үндсэн бичвэр, түүхийн баримт, эх сурвалж, уншиж судлах явцдаа анхаарал хандуулах, бодож тунгаах асуулт, нэмэлт мэдээлэл, нэр томъёо, ухагдахууны тайлбар, суралцахуйн үйл ажиллагааны дасгал, даалгавар зэргээс бүрдэж буй.

Эдгээр бүрдэл хэсгүүдийг сурах бичигт дараах тусгай таних тэмдгээр тэмдэглэв.

Халх Монгол Манжид  
дагаар оров.  
1691 он

**Он тооллын шулуун** нь тухайн бүлгийн агуулгын он цагийн хамрах хүрээ, энэ үеийн түүхийн тойм үечлэлтэй танилцуулж, өмнөх мэдлэгээ сэргээн санахад тань тусална.



**Бодож тунгаах асуултаас** Та бүхэн тухайн сэдвийн гол түлхүүр асуудлын чиг баримжааг ойлгох, мэдэх боломжтой тул эхлээд танилцаарай.

**Үндсэн бичвэр** хэсэгт уг булэг, сэдвийн үндсэн агуулгыг судалж мэдэх, бие даан ажиллах, асуулт даалгавар гүйцэтгэхэд туслах өгөгдөл мэдээлэл багтсан бөгөөд Та бүхэн үүнийг бусад хэсгүүдтэй нягт холбон ашиглаарай.



Бичвэрийн дундуур уншиж судлах явцдаа анхаарал хандуулах, бодож тунгаах асуулт өгсөн тул түүнд мөн анхаарал хандуулаарай.



**Сурвалж-** Эх сурвалжийн буланд тухайн сэдэвт холбогдох түүхийн баримт, эх сурвалжийн хэсгээс оруулж өгсөн бөгөөд үндсэн бичвэртэй холбон, суралцахуйн үйл ажиллагааны даалгаврын дагуу эх сурвалжийг шинжлэн судалж бие даан мэдлэг бүтээх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, үнэлэх дүгнэх зэргээр ашиглах учиртай.



**Нэмэлт мэдээлэл** буланд сэдвийн агуулгыг тодотгох, баяжуулах, мэдлэгээ тэлэхэд хэрэг болох мэдээллийг шигтгэн оруулж өгсөн болно.



**Нэр томъёо, ухагдахууны тайлбар** буланд тухайн сэдвийн агуулгад холбогдох зарим шинэ, ойлгомжгүй нэр томъёо, ухагдахууныг товч тайлбарласан тул түүнийг тухай бүрт нь ашиглаарай.



**Суралцахуйн үйл ажиллагааны даалгавар** хэсэгт нэгж сэдвийн хүрээнд сурагчийн эх сурвалж, мэдээллийг шинжлэн судалж, бие даан мэдлэг бүтээх, мэдлэгээ бататгах, цэгцлэх, үнэлэх, дүгнэх зэрэг олон талын зорилготой гүйцэтгэх үйл ажиллагааны асуулт, дасгал, даалгавруудыг өгсөн тул түүнийг бүтээлчээр ашиглаж суралцаарай.

Сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилт хүсье.

## УДИРТГАЛ

### 1. Эх түүхээ эрхэмлэн судалцгаая.

Энэхүү сурах бичиг нь Та бүхний 8, 9-р ангидаа үзэж судалсан Түүхийн хичээлтэй агуулга, аргазүйн хувьд залгамж холбоотой, түүний шууд үргэлжлэл юм. Сурах бичгийн агуулгад XVII зуунаас өнөөдрийг хүртэлх Монголын түүхийг хураангуйлан оруулсан болно.

Сурах бичгээс бид улс төрийн нэгдмэл байдал, сүр хүч нь сулран доройтсоор Монгол Улс тусгаар тогтнолоо алдаж, харийн эрхшээл дор оршиж ирсэн сургамжит түүхтэй танилцана. Тэрчлэн бидний өвөг дээдэс 1911, 1921 онд эх орон, эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж, Монгол Улсаа дахин сэргээн босгосон түүхийг судална. Монгол Улс 1920-иод оноос 1990 оныг хүртэл социализмын замаар замнасан түүх, олон ололт, үлдээсэн туршлага сургамжийг мэдэж авна. 1990 оны ардчилсан хувьсгал, түүний шалтгаан, өрнөл, яалт, Монгол Улсад өрнөсөн ардчилал шинэчлэлийн түүхтэй танилцана.

Та бүхэн сурах бичигтээ тулгуурлан эх орныхоо сүүлийн 400 гаруй жилийн түүхээр аялж, түүнээс суралцаж, сургамж ухаарал авч, нэгийг бодож, хоёрыг тунгаана гэдэгт итгэлтэй байна. Учир нь Та бүхэн Монголын ирээдүй, чухамдаа Та бүхэн л эх түүхээ, эцэг өвгөдийнхөө үйл хэргийг цаашид залгамжлан үргэлжлүүлэгчид гэдгээ ямагт санагтун.

Түүхийн аль ч цаг үед монгол хүн бүр эх орон, үнэ цэнтэй бүхнээ хайрлан хамгаалж, ирээдүй хойч үедээ өвлүүлэх түүхэн хариуцлага үүрдэг. Монголын түүх ингэж л үе үеийнхний хичээл зүтгэлийн үр дүнд үл тасран үргэлжилж, өнөөг хүрч ирсэн билээ.



Бидэнд амьдарч байгаа цаг үеэ, нийгмээ зөв ойлгоход өнгөрсөн түүх тусалдаг. Учир нь, өнөөдөр бол өчигдрийн үргэлжлэл, маргаашийн угтال билээ. Өнгөрснийг бидэнд зөвхөн түүх л өгүүлж чадна. Бас ирээдүйгээ бодитой төсөөлөх боломж олгодог. Түүх бол бидний өвөг дээдсийн түүлсан амьдрал. Тэдний хуримтуулсан мэдлэг туршлагын арвин сан. Бидэнд үлдээсэн өв, сургамж. Тиймээс Монголын түүх бол бидний агуу их багш. Түүнээс бид бүхий л асуултандaa хариулт авах боломжтой. Тиймээс бид түүхээ эрхэмлэдэг, судалдаг, түүнээс суралцааг.



Түүх яагаад бидэнд багшилж, тулгамдсан асуултын хариулт өгч чаддаг вэ?  
Эх түүхээ судлахын хамгийн гол ач холбогдол юу гэж бодож байна? Яагаад?

Та бүхэн багш, наиз нөхөдтэйгөө хамтран оюун билгээ дайчилж, ухаан бодлоо уралдуулж, сэтгэн бодож, нээн бутээж, асуудлын мөн чанар, утга учрыг ухааран ойлгож, дүгнэн цэгнэж, эх түүхээ шимтэн судлахыг хичээгээрэй.

Оноож өгсөн хуудасны хэмжээнээс шалтгаалан сурах бичигт Монголын түүхийн баялаг агуулгыг тэр бүр багтаан оруулах боломж байсангүй. Тиймээс өмнөх мэдлэгтээ тулгуурлахын зэрэгцээ бие даан нэмэлт хэрэглэгдэхүүн судлан баяжуулж суралцахыг та бүхэнд зөвлөж байна.



1. Түүхийг үечлэн судлахын ач холбогдлыг тодорхойлоорой.
2. XVII-XX зууны эхэн үеийн Монгол нийгмийн дүр төрх, аж байдлыг дүрслэн бодоороой.
3. Хураангуй товчоонтой танилцан өмнөх мэдлэгээ сэргээн санаж, XX зуунд Монгол Улсын түүхэнд гарсан гол ололт амжилтуудын тухай ярилцан, жагсаалт гаргана уу.

## 2. XVII-XXI ЗУУНЫ ЭХЭН УЕЙИН МОНГОЛЫН ТУҮХИЙН ХУРААНГУЙ ТОВЧООН.

Манжийн эрхшээлийн үе (XVII-XX зууны эхэн)	Монгол Улсын сэргэн мандлын шинэ үе (XIX зууны эхнээс ХХI зууны эхэн)	Сэргэн мандлын эхэн үе (1911-1924)	БНМАУ (1924-1990)	Сошиалист байгуулалтын үеийн БНМАУ (1924-1990)	Ардчилал шинэчлэлийн үеийн Монгол Улс (1990-онос хойш)
1603-1634 - Гийден ханн суув. 1607-Хоёрт Ихил рүү нүүснөн нь хожижуу Хамзээдэв. 1636 - Өвөр Монгол Манжид дагаар оров. 1639 - Занабазарыг анхдугаар Боддоор яртжмийв. 1640 - Хашк, Ойтрайн нөйд чуулж, Их цаас батыав. 1648 - Тод бичиг зохиогдаж. 1661 - Буриадууд Оросын тургийнголд яртек эхлэв. 1670-1671 - Хөвд хот суурин тавьжээ. 1685 - Хөвд хот суурин тавьжээ. 1686 - Соёмын усаг зөхжээ. 1691 - Хашк Монгол Манжийн захиргаанд оров. 1721 - Хөх Нуурын Монголчууд Манжийн эрхшээлд оров. 1723 - Хөх Нуурын Монголчууд Манжийн эсрэг тэмцээж. 1739 - Зүүнгар улс, Манжийн хоронд чилийн хэлээцэр болов. 1755-1760 - Зүүнгар улс Манжид эзлэдэв. 1755-1758 онд Амарсанаяа, Чинчужав нарын бослогоюутаа. 1771 - Нутгаа зорьсон Халимагууд Манжид оров. 1771 - Ижид үндсэн Халимагууд Орост нэддэв. 1858 - Ордын Улсын холуунд ард түмний хөдөлгөөн гарчээ. 1880 - Улаастайд Онооптайн үйлдэснээнд цэргийн бослын дэлдэв. 1900 - Улаастайд Манжийн эсрэг монгол цэргийн бослын дэлдэв. 1905-1907 - Өвөр Монгол Тогтол Цогдалай, Дамитил нарын үйлдэснээнд бослож гарав.	1900 - Бадамдорж, Цэрэн-Очир нарыг Орос улсад зарж туслахж хүсэв. 1906 - Хөдөөндрийн нүүлжэн сурьшуухал төвийн Бэзжинд байгуулагдваа. 1907 - Хансин, Алтмас-Очир нар ирж, Халхын нөхцөлтэй зөвлөдөв. 1909 - Тусгтар тогтох "Танзэрийн цаг" болсон тухай Бодлундэн булагджээ. 1911-12-4 - Манжийн албан Сандо-г Хүрэндээс хөв. 1911-12-29 - Монгол Улс туусаар тогтолцоо тухаглав. 1912-11-3 - Орос-Монголын тэрээ батлав. 1913 - Бэзжиний тунхаж бичиг гарав. 1914 - Уланы хурал байгуулав. 1914-9-8 - 1915-6-7 - Хиагтад з улсын хэзэлцээр явадлав. 1915 - Монгол Улсын автономийг цуцав. 1920-1-2 - Автономийг цуцав. 1921-4 - Бодлыг хөн шаардэн нь тогтолцоо бүх нийтийн санал хураалтаар батлав. 1921-3-1-3 - Дээр Шивээнд хамтарсан зөвлөхөн болж, МАН-ыг байгуулж. 1921-3-13 - АГЗГ байгуулалтав. 1921-3-18 - МАЖЦ Хялагыг чөлөөв. 1921-7-11 - Айдын эрхтэй хамжээт цаасат хөхт Монгол Улсыг тунхжав. 1921-8 - 1922-1 - Эх ороноо цагаатнаас буран чөлөөв. 1921-9 - Улсын Түр цагийн хурал байгуулагдваа. 1921-11-1 - Тангарагийн гарээг батлав. 1921-11-5 - Монгол-Зөвлөлийн нарамдаадын гарээнд гарын сэргээв. 1922-1-25 - Хамжлагчын харьцааг халах тухай шийдвэр гарав. 1923 - "Нутгийн захирагчны дүрэм", "Засаг да засаг бүс Ван гүнүүдийн эрх хөмжийн дүрэм", "Эдийн засгийн үндсэн бодлогийн" гарав. 1924-5-20 - Бодл хан ханч халав.	1922-1924 - Үндсэн хуль боловсруулах комиссийн байгуулалтан ажилласв. 1924-6-7 - МАН-ас Монголд БНЗасаг толгох шийдвэр гарав. 1924-11-8-28 - Улын анхдугаар Их Хурал хурдадах. Учсан хуль батлав. 1924-12-28 - Үндсний ардчилсан чиг шугам хэрэгжүүлэхийг оролдлов. 1928-1932 - "Зүйнчилдээ" социализм хувьсгалчан байгуулагыг хүчин оролдов. 1932-1940 - Монголд "Шинэ эрэлтийн бодлого" явуулав. 1939-8 - Халиг тогт Монгол-Зөвлөлийн цергийн хамтарсан хүч ялалт байгуулав. 1940 - БНМАУ 2 дахь Үндсэн хуль батлав. 1941 - БНМАУ 3 дахь Үндсэн хуль батлав. 1942 - МУИСС байгуулагдав. 1945-8 - БНМАУ Чөлөөвийн дайнд оролцож, хөгжбонтын Үргээс биеуулав. 1945-10-20 - Монголтусын тусгаар тогтолцоо бүх нийтийн санал хураалтаар батлав. 1946 - Шинэ Узгээс хамгийн эдийн үр ач наравас уучлан туйв. 1940-1960 - Социализмын балтгайт үндсийн хангах зорилтыг хэрэгжүүлэв. 1958-1960 - Нагдалжих хөдөлгөөн өөрчилж, атар газар эзэмшив. 1960 - БНМАУ 3 дахь Үндсэн хульяа батлав. 1960-1990 - БНМАУ-д социализм бүрэн байгуулахаар оролцогдох хийв. 1961,10-27 - НҮБ-ын бүрэн эрхтийн болов. 1961 - ШУА байгуулагдваа. 1966 - МАЖЦ социализм бүрэн байгуулалт IV программаа батлав. 1977-1993 - Монгол Улсын түүх" 5 боть сурье бүтээг хувьсгалэв. 2006 - ИМУ байгуулалтаданы 800 жилийн ойг ёснон тэмдэглэв. 2008 - Иргэнд Газар ёмчилүүлэх хуль батлагдав. 1999-7-28 - Монгол Улс Энхийн сахиулах ажиллагаанд орцполхор болов. 2016-7 - Шинэ сонгууль явадлав.	1989-12-10 - Молх байгуулагдав. 1989-12-19-1990-3-эр сар - АСХ, ШДХ, МоАН, МСДН, МУДН байгуулагдваа. 1990-3-7 - 9-нд Улс төрийн ёлсчилжөн зарлав. 1990-3 - МАЖЦ нийтийг үйлдээн чигүүлэгч хүчин байхaa болив. 1990-5 - БНМАУ-ын Үндсэн хульчин намтуузын тухай хуль батлагдав. 1990-7-22-29 - Монголд анх удаа чөлөөт, ардчилсан онцгуйтуу 2-е шатаар явагдваа. 1990-08 сар - МНТ-850 жилийн ой болов. 1991 - Монгол бичигээ сэргээх, хос бичигтэн болгох шийдвэр гарав. 1992-1-13 - Шинэ Үндсэн хуль батлагдав. 1991 - Банкин тухай хуль батлав. 1993 - Өмчийн хуль түхийн хуль гаргав. 1994-6-30 - "Монгол Улсын гадад, болдогийн үзэг баримтлал", "Монгол Улсын үндсэн аюулгүй байдлын үзэг баримтлал"-ыг батлав. 1996 - Төрийн зүтгээс хамгийн чөлөөв. 1996 - Чөлөөн ханшиг чөлөөв. 1996 - Орон сууц хувьцах хуль батлав. 1997-1-эр бүдээ гарын өнчилүүлэх, зээлийнхээх хуль таргав. 2002 - Чингис ханы мондаджийн 840 жилийн ойт ёснон тамдэглэв. 2003 - "Монгол Улсын түүх" 5 боть сурье бүтээг хувьсгалэв.	1989-12-19-1990-3-эр сар - АСХ, ШДХ, МоАН, МСДН, МУДН байгуулагдваа. 1990-3-7 - 9-нд Улс төрийн ёлсчилжөн зарлав. 1990-5 - БНМАУ-ын Үндсэн хульчин намтуузын тухай хуль батлагдав. 1990-7-22-29 - Монголд анх удаа чөлөөт, ардчилсан онцгуйтуу 2-е шатаар явагдваа. 1990-08 сар - МНТ-850 жилийн ой болов. 1991 - Монгол бичигээ сэргээх, хос бичигтэн болгох шийдвэр гарав. 1992-1-13 - Шинэ Үндсэн хуль батлагдав. 1991 - Банкин тухай хуль батлав. 1993 - Өмчийн хуль түхийн хуль гаргав. 1994-6-30 - "Монгол Улсын гадад, болдогийн үзэг баримтлал", "Монгол Улсын үндсэн аюулгүй байдлын үзэг баримтлал"-ыг батлав. 1996 - Төрийн зүтгээс хамгийн чөлөөв. 1996 - Чөлөөн ханшиг чөлөөв. 1996 - Орон сууц хувьцах хуль батлав. 1997-1-эр бүдээ гарын өнчилүүлэх, зээлийнхээх хуль таргав. 2002 - Чингис ханы мондаджийн 840 жилийн ойт ёснон тамдэглэв. 2003 - "Монгол Улсын түүх" 5 боть сурье бүтээг хувьсгалэв.	


# I БҮЛЭГ. XVII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ



## 1. Монгол улс Манжийн эрхшээлд орсон нь



- Монголчууд нэгдмэл бус байсны шалтгааныг хэрхэн тайлбарлах вэ?
- Манж нар ямар арга, бодлогоор монголчуудтай харилцаж байсан бэ?
- Монголчууд Манжийн эрхшээлд орсноор ямар түүхэн өөрчлөлт гарсан бэ?



XVII зууны үед Монгол улс Ар буюу Халх Монгол, Баруун Монгол, Өвөр Монгол, хөх нуурын буюу Хошууд Монгол зэргээс бүрдэж байлаа.

**Халх Монгол** нь Түшээт хан, Сэцэн ханыг багтаасан зүүн гар, Засагт ханаар удирдуулсан баруун гарта хуваагдаж байв. Халхын баруун хойд нутагт Шолой убashi, түүний хүү Омбо-Эрдэнэ нарын захирсан **Хотгойд аймаг** хүчирхэгжин бие даасан шинжтэй оршиж байжээ. **Өвөр Монгол** нь Лигдэн хутагт хаанд шууд захирагдаж байлаа. **Баруун Монгол** буюу **Ойрад** нь Хошууд, Зүүнгар (Цорос), Дөрвөд, Хойд хэмээх дөрвөн голлох аймгийн холбоонд нэгдэж байв. XVII зууны эхээр **Торгууд**, **Дөрвөдийн** зарим хэсэг баруун хойд зүг Ижил мөрөн рүү, **Хошууд аймаг** зүүн урагш Хөх нуурын зүг нүүдэллэн оджээ. Тийнхүү монголчууд тус тусдаа бие даасан байдалтай орших болсон юм. Тэр үеийн аймаг, отог, хошуу нь хэмжээний хувьд түмнээс бага бөгөөд цэрэг, засаг захиргаа-угсаатны бүлгийн шинжийг давхар агуулж байв.

Монгол Улс нэгдмэл байдлаа алдсан нь тухайн үед хүчирхэгжсэн Манжийн эрхшээлд орох нөхцөлийг бүрдүүлсэн юм. Энэ үйл явц 1620-иод оноос хойш 130 гаруй жилийн турш үргэлжилж, Өвөр Монгол, Халх Монгол, Хөх нуурын монголчууд, Ойрад Монгол-Зүүнгар улс ээлж дараалан Манжид эзлэгджээ.

Монголын зүүн өмнө орших Зүрчид гаралтай манж, түнгүс уgsааны аймгууд XVII зуунд хүчирхэгжiv. 1616 онд Нурхач (1559-1626) улсаа "Хойт (Хожуу) Алтан улс" хэмээн нэрийдэв. Тэд хөрш нүүдэлчин Монгол, суурьшмал Хятадын төр ёсны зохион байгуулалтын зарим зүйлийг авч улс орноо эмхлэн байгуулав. Манж нар ан гэррөө, аян дайны уламжлалт цэрэг-захиргааны зохион байгуулалтыг ашиглажээ. Мөн Манжийн хаад төрийн хэрэгт монгол бичиг хэрэглэж, улмаар монгол бичигт тулгуурлан манж бичгийг зохион хэрэглэсэн юм.

**Өвөр Монгол Манжийн захиргаанд орсон нь.** Манжийн тал эхэн үедээ монголчуутдай найрсаг харилцахыг эрмэлзэж байлаа. Тэд эн түрүүнд худ ургийн холбоо тогтоож эхлэв. 1612 онд Нурхач, түүний хөвгүүд Хорчин, Жарууд аймгийн ноёдын охидыг эхнэр болгон авчээ. Мөн Монгол Улстай элч солилцож, цэрэг-улс төрийн холбоо тогтоохыг зорьж байлаа. Тэд ургийн холбоо болон элчин харилцаанд дулдуудан, Өмнөд Монголын аймгуудад нөлөөгөө тэлэх, талдаа татахыг санаархах болов. Тиймээс ихэс ноёдод нь **цол, хэргэм, бэлэг сэлт, шан харамж** хүртээж эхэлжээ.

Тэр үед Өвөр Монгол нь Цахар, Хорчин, Харчин, Түмэд, Юншээбү, Ордос, Асуд, Найман, Жаруд зэрэг олон аймаг, отогтой байв. Тэдний зарим нь Чингис хааны алтан ургийн сүүлчийн хаан **Лигдэн (1591-1634)**-ий төвлөрсөн засаглалыг эсэргүүцэж байсан юм. Лигдэн хаан салан тусгаарлах санаархлыг «**терөөс этгээд явдал**» хэмээн үзэж, хатуу тэмцэж байлаа. Үүнийг Манж нар ашиглан, Лигдэнгийн эсрэг этгээдүүдтэй хүч хавсрах бодлого явуулжээ. Энэ сацуу Манж нар 1626 онд Жарууд, Баарин аймгийг довтлон, дараа нь Хорчин аймаг, 1627 онд Найман, Аохан аймаг, 1628 онд Харчин аймаг, 1629 онд Авга, Түмэд аймгийг эрхэндээ оруулав.

**Сурвалж-1:** Ам алдсан бичгийн уг: Манж, Харчин бид хоёр улс нэгэн зээр явахын тулд, тэнээрт цагаан морь, газарт хар үхэр алж, нэг аяганд архи хийж тахин мөргөөд, төр ёсоо нэгтгэн үйлдвэй.

Лувсанданзан. «Алтан товч»-оос.

1626 онд Алтан улс Цахарт довтлоход Харчин, Түмэд, Ордос, Асуд, Юншээбү аймгийн ноёд, тайж нар хүч хавсран Лигдэн хааны цэргийг бут цохижээ. 1632 онд Абахай манж, монгол цэргийн хүчээр дахин довтлов. Хүчинд автсан Лигдэн хаан Хөх нуурын зүг зам буруулж яваад 1634 онд тэнгэрт хальжээ.

Лигдэн хутагт хаан үгүй болсноор Өвөр Монголын ноёд тус тусын аймгаа аван Манжийн харьяанд оржээ. **1636 онд Өвөр Монголын** 16 аймгийн ноёдын чуулган Мүгдэнд болж, Алтан улсын хааныг эзэн хаанаа хэмээн зөвшөөрчээ.

**Халх Монгол Манжийн эрхшээлд орсон нь.** Манж нар Халхын дотоод хэрэгт хөндрөнгөөс оролцох, биедээ татах, хүч түрэн харилцах, аажмаар эрхшээлдээ оруулахыг чармайж байлаа. Харин Халхын ноёд Манжтай элч солилцон, найртайгаар харилцах бодлого баримталж байв.

**Сурвалж-2:** "...Бичиг барихын учир: Хаан хүмүүнд хас их төр, хамагт сонсдох сайн алдар нэр хэрэгтэй тул хамгаас төр шажныг мандуулах нэрийг эрэлдье. Зургаан түмний эзэн биднийг жолоодон эс чадав. Тэр эс чадавч хан төрөлт бидэн...хас их төрийг хадгалж суунам бид. Энэ их төрийг санахул нь нааш цааш элч юугаан тасралтгүй [илгээн] мэнд асуулцаж явъя. Ийн хийж явахул эрдэнэт хүмүүний төрөл олж эрх хүчтэй хан болон төрсний гавьяа бидний тэр ажаамуу".

Халхын ноёдоос Манжийн хаанд илгээсэн бичгээс.

Тухайн үед Халхыг баруун гарын Засагт хан Субадай (?..-1650), зүүн гарын Түшээт хан Гомбодорж (1594-1655), Сэцэн хан Шолой (1577-1652) нар тэргүүлэн удирдаж байв. Тэд Манж Чин улсын өмнө зарим нэг буулт хийж, цагийн аясыг харзнасан бодлого баримталж байлаа. Дээрх хангудыг залгамжлагчдын үед Халхын дотоод хямрал даамжирчээ. Гэвч 1688 он хүртэл Халх бие даасан

байдлаа алдалгүй тусгаар оршсон юм. Нөгөөтэйгүүр, Түшээт хан Чахундорж тэргүүтэй Халхын ноёд Зүүнгарын хаан Галдан бошогтын довтолгоонд шахагдав. Үүний улмаас Түшээт хан Чахундорж, Өндөр гэгээн Занабазар нар харьят нарынхаа хамт Манжийн ивээлд ороход хүрчээ. 1689 онд Ар элстэйд болсон чуулганаар Халхын ноёд Манжид дагаар орох асуудлыг хэлэлцэв.

1691 оны 4-р сарын сүүлээр Түшээт хан Чахундорж, Өндөр гэгээн Занабазар, Сэцэн хан Өмэхэй, Засагт ханы ойр угсааны ноёд, тайж нар, мэн Өвөр Монголын 49 хошууны том ноёд Долоон нуурт чуулжээ. **1691 оны 5-р сарын** эхээр Манжийн Энх-Амгалан хаан ирж зарлиг сонсгон, тусгай ёслол үйлдсэнээр **Халх Монгол** Манжийн эрхшээлд оров.

**Хөх нуурын монголчууд Манжийн захиргаанд оров.** Ойрадын ноёд 1637 онд Хөх нуур, Төвөдийг цэрэглэн эзэлж, засаглан захирах болсон билээ. Тэнд Ойрадын зарим ноёдыг албаттай нь нүүлгэн суурьшуулжээ. 1639-1642 онд Төвөд орныг дайлан эзэлсэн Хошуудын Гүүш хан Төrbайх (1582-1655)-ыг Төвөдийн хаан ширээнд суулгаж, V Далай лам Лувсанжамцыг Төвөдийн бурханы шашны тэргүүнээр өргөмжлөв. Энэ үйл явдлаар **Хошууд улс** байгуулагдсан гэж үздэг.

Төrbайхын ахмад хүү Даян монгол цэргийг захиран Төвөдөд сууж, 6-р хүү Дорждалай баатар Хөх нуурын тайж нарыг захирах болов. 1690 оноос Гүүш хааны 10-р хүү Дашбаатар, 1714 оноос түүний хөвгүүн Лувсанданзан нар эрх барьжээ. 1698 онд Дашбаатар ноёдын хамт Манж Чин улсад дагаар орохоор шийдэж, чин вангийн хэргэм шагнуулсан ч шууд захирагдсангүй. 1717 онд Зүүнгар улсын жанжин Их Цэрэндондовын цэрэг Төвөдийн Лхасыг эзлэн авч, Хошууд угсааны хан Лхавзаныг хөнөөжжээ. Харин 1720 онд Манж Чин улс Төвөд рүү цэрэг оруулан, Ойрадын цэргийн гол хүчийг бут цохив. Тэд 1721 оноос Төвөдийг захирч байсан Хошуудын ноёдын эрх мэдлийг устгасан төдийгүй Лувсанданзанд Хөх нуурын зөвхөн баруун гарыг захируулахаар шийджээ. Тийнхүү Хөх нуурын монголчууд Манжийн захиргаанд оров.

**Зүүнгар улс Манжид эзлэгдэв.** Торгууд, Дөрвөд, Хошуудын нэг хэсэг Ижил рүү нүүсний дараа Ойрадад Цоросын ноёд гол суурь эзлэх болжээ. Цоросын тэргүүлэгч Эрдэнэбаатар хунтайжийн үед Ойрадын улс төр тогтвортжин хүчирхэгжив. Түүний хүү Галдан (1644-1697) 1676 онд Зүүнгар улсын хаан болж, улсаа улэмж бэхжүүлсэн юм. Гэвч 1688 оноос Галдан Халх руу цэрэглэн, улмаар Манж Чин улсын эсрэг тэмцэж явах хойгуур Цэвээнравдан (1665-1727) өөрийгөө Зүүнгарын хаанд өргөмжилжээ.

Цэвээнравдан, Галданцэрэн (1694-1745) хаадын үед Зүүнгар улс хүчирхэгжин, Манж Чин улстай эн зэрэгцэн оршиж байлаа. Гэвч Зүүнгар улсын дотоодын хямрал, зөрчилдөөний улмаас зарим ноёд, зайсан нар урван одох болов. 1750 онд зайсан Саарал, 1753 онд Цэрэн, Цэрэн убаш, Цэрэнмөнх, 1754 онд Амарсанаа нар албатаа аван Манжид дагаар оржээ.

1755 онд Манж Чин улс их цэргийн хүчээр Зүүнгар улсын эсрэг довтолжээ. 1755 оны 7-р сард Даваач хаан баригдаж, Зүүнгар улс мөхөв. Тийнхүү XVIII зууны дунд үеийг хүртэл тусгаар тогтолоо хамгаалж үлдсэн Зүүнгар улс Манжид эзлэгдсэн юм.

**Сурвалж-3:** "...Манжийн жанжин, цэргүүд Зүүнгар улсын хүнийг юуртэл хядан алж орон нутаг нь эзэнгүй хоосон болж, улс үргэн нь хамтаар бүрмөсөн мөхөж сөнөжжэ...Галдан бошогт ханаас эхлэн эцсийн Амарсанаа ханд хүртэл Зүүнгар улсын бүх хүнийг зуугаар бобоос дайно автсан нь гучин хувь, Дайчин улсад дагаар орж аймаг, хошуу, сум болсон нь арван таван хувь, айл зэргэлдээ улс аймагт зайллан гарч олзлогдсон нь арван таван хувь болох мэт бөгөөд нутаг газар нь тийнхүү хоосон болжээ..."      Б.Буянчулган."Дөрөөн Өөлдийн түүх" зохиолоос.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. XVII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ



1. Түүхэн зургийг (Зураг-1) ажиглаад тухайн үеийн Монгол Улсын бурдэл, газар нутгийн байршилыг тодорхойлоорой.
2. Тухайн үед Монголын ноёд язгууртнууд нэгдмэл захиргааг бус бие даахын төлөө байсан нь цаашид ямар үр дагаварт хүргэсэн бэ?
3. Сурвалж-1, 2-ыг уншиж судлаад дараах асуултад хариулна уу? Ямар байсныг тодруулаарай.
  - а. Манж нар ямар арга бодлого хэрэглэсэн бэ?
  - б. Халхын ноёдын байр суурь, үзэл бодол ямар байв.
  - в. Сурвалжийн мэдээ бидэнд ямар мэдээлэл өгч байна вэ?
4. Сурвалж-3-т тулгуурлан оюун дүгнэлт хийгээрэй.

### 2. Халимаг, Буриад Монголыг Орос улс эзэрхсэн нь




- XVII зууны үед Буриад монголчууд хэний захиргаанд байсан бэ?
- Халимаг монголчууд ягаад Оросын хаант улсын нутагт аж төрөх болсон бэ?
- Халимаг, Буриад Монгол Оросын хаант улсын захиргаанд орсон шалтгаан юу байв?

XVII зууны эхэн үед баруун Сибирийн газар нутгийн ихэнхийг эзлэн авсан Оросын хаант улс зүүн Сибирь, Байгаль нуур хавийн нутагт түрэмгийллийн бодлогоо үргэлжлүүлэв. Үүнд Халхын Түшээт хан, Сэцэн ханд захирагдаж байсан буриад монголчууд өртсөн юм. Буриадын нутагт хүч түрэн орж ирсэн оросууд алба гувчуур авах, эзлэн захирахыг эрмэлзэв. Түүгээр ч үл барам цэргийн бэхлэлт шивээ барин суурьших болсныг Халхын Түшээт хан эсэргүүцэн, 1681-1687 оны хооронд хэдэнтээ цэрэглэж байсан билээ.

**Сурвалж-1:** "...Алексей Михайлович цагаан хааны хайранд шүтэж, Нэрчугийн хязгаарт хамжиж, албат болоод, 1648 оноос эхлэн, чадалтай зоноо тоолон, нэг зуун жаран саадаг гэж толгойн хорь, хорин менгэ алба өргөх болж, амаржин суусан билээ... Тийн байтал Манжийн Энх-Амгалан хаан болон Оросын их дээд эзэн император 2-р Петр хааны үед, 1727 онд...Хиаатаас Эргүн голын эхэн, тэндээс Хун тайкийн газар хүртэл Орос Хятад (Манж) хоёрын газар хувааж, зах хилийн тэмдэг тавив".

Товын Төгөлдөр. "Хорийн болон Ага буриадын урьд цагийн түүх" зохиолоос.



1630-аад оноос Оросын хаант улсын цэрэг Байгал нуурын орчмоор буриадуудын нутагт нэвтрэн ирж эзэрхэх болжээ. Мөн дипломат аргаар өөртөө татах бодлого хэрэжкуулэв. 1648 онд Байгал нуурын зүн талд Баргужин шивээ, 1651 онд мөн нуурын баруун талд Эрхүү өвөлжээ, Үд шивээг байгуулж байр сууриа бэхжүүлжээ. Үүнийг Халхын ноёд эсэргүүцэн 1658 онд Балаганск болон Братский шивээнийн орчим байсан буриадуудыг Халх руу нүүлгэн аваачив. 1685 онд Далай сэцэн ноён, Шибтуй хатан баатар нарын цэрэг Түнхэний шивээг бүслэн байлдажээ.

1689 оны Манж-Оросын Нэрчугийн гэрээгээр Орос улс Эрхүү, Түнхэний шивээ орчмын нутгийг, хүн амын хамт харьяандaa оруулсан юм. 1727 оны Буурын гэрээгээр Оросын хаант улс ба Манж Чин улсын хилийн заагийг тогтоосноор Буриад монголчууд Оросын эзэнт улсын мэдэлд бүрэн оржээ.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. XVII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ

1607 онд Торгуудын Хо өрлөг, Дөрвөдийн Далай тайш нар харьяатаа авч баруун хойш Тоболь голын эхэнд нүүн очиж суурьшжээ. Тэд 1630-аад оны дундуур Ижил мөрний доод хэсэгт нутаглах болсон нь хожим **Халимаг** хэмээгдэв.



1. Халимагийн хант улсын нутаг байршилыг орчин үеийн газар зүйн зурагтай харьцуулаарай.
2. Нүүдлийн зам дагуу орших нутгийн онцлогийг газар зүйн мэдлэгтэй холбон тайлбарлаарай.

Ойрадууд 1607-1771 он болтол 8 удаагийн их, бага нүүдлэг хийжээ. Халимаг-Оросын цэргийн холбооны гэрээ 1657 онд байгуулагдав. 1697 онд Оросын өмнө зүгийн хилийг халимагууд хамгаалах үүрэг хүлээв. Халимагаас Зүүнгар руу буцах нүүдэл 4 удаа болсон ажээ. Жишээ нь, 1700-аад оны үед Санжав тайжийн тэргүүлсэн нүүдлээр 30 мянган хүн Зүүнгар улсад буцах ирэв.

Хо өрлөгийн шууд угсааны Аюук хан (1670-1724) I Петр хаантай гэрээ байгуулан Оросын өмнөд хилийг кавказынхан, туркуудээс хамгаалах болсноор тэд Оросын цэргийн гол холбоотон болжээ. Аюук ханы үед **Халимагийн хант улс** ихээхэн хүчирхэгжиж, хүн ам нь 250 мянгад хүрэв.

XVIII зууны үед Оросын зүгээс Халимагийн дотоод хэрэгт шууд оролцож язгууртнууд багтдаг шүүх, хаанд зөвлөх эрх бүхий хуралдай болох “**Зарга**”-ын зайнсангуудыг тэд дураар сонгох болов. Мөн гадаад улсуудтай харилцахыг хориглон, халимагуудыг христийн шашинд хүчлэн оруулж эхэлжээ. Мөн олон удаагийн дайнд халимагуудыг дайчилж байсан нь ихээхэн хүнд дарамт болж байв. Иймд Аюук ханы ач Увш хан (1742-1775) 1771 оны их нүүдлийг удирдсан юм. 1771 онд Халимагаас Зүүнгарын нутаг руу 170 мянган хүн нүүн гарч, 70-аад мянга нь л эх нутагтаа ирж, аргагүйн эрхэнд Манж Чин улсад дагаар оров. Харин Орос улс Ижил мөрний баруун эрэгт хоцорсон халимагуудын **улс** байх эрхийг хасаж, Астрахань мужид захишуулжээ.

**Сурвалж-2:** “... Торгууд Астрахань гэдэг балгасаар орж, Ижил голд нутагласнаас өдгөө широон туулай жил хүртэл зуун арван зургаан жил болсон. Зүүн гарын нутаг зөвдэрснээс өдгөө широон туулай жил хүртэл жаран хоёр жил болсон. Торгууд гэдэрээс урваж Оросын мэдлээс гарч, Алтай тэмцэнээс өдгөө широон туулай жил хүртэл дөчин найман жил болсон... Аюук хааны зарлиг: Нэдтай адил хүн бурханы шашин эөддэг. Тийм санаа надад төрөвлөл номын сахиус зүрхийг минь үтэр сугал..”

Баатар увш Түмэн.“Дөрвөн Ойрадын түүх оршив” зохиолоос.

Широон туулай жил 1819 он бол дурдсан бусад түүхэн үйл явдлуудын оныг тооцоолоорой. Далай ламаас хан цол, тамга авсан Аюук хааны үгнээс Халимаг монголчуудын шүтлэгийн талаар ямар дүгнэлт хийж болох вэ?

1. Халимаг, Буриад монголчууд Орост эзлэгдсэн үйл явдлын нийтлэг болон ялгаатай талуудыг бүдүүчээр дурсэлж илэрхийлээрэй.
2. Халимаг, Буриад монголчуудын үр хойчis одоо хэрхэн аж төрж буй талаар цахим эх сурвалж ашиглан мэдээлэл цуглувулж танилцуулаарай.
3. Зураг 2, Зыг ажиглаад Буриад, Халимаг монголчуудын нутаг орны байршилыг одоогийн газар зүйн зурагтай харьцуулж, газар нутгийн байршилыг тодорхойлоорой.

### 3. Монгол Улс тусгаар тогтнолоо алдсан шалтгаан



- Лигдэн хааны Монголыг нэгтгэн захирах бодлого яагаад амжилтад хүрсэнгүй вэ?
- Монгол Улс тусгаар тогтнолоо алдсан дотоод, гадаад шалтгаан юунд байв?
- Монголын тусгаар тогтнол алдагдсан нь ямар үр дагаварт хүргэсэн бэ?

**Гадаад нөхцөл байдал:** XVII зууны эхэн үед Монголын өмнө зүгээс Мин улс хагалан бутаргах бодлогоо хэрэгжүүлж, хойд талаас Орос улс түрэмгийлэн, зүүн урдаас хойт Алтан улсын аюул нүүрлэж байв. Тэд монголчуудын дотоод зөрчил, хямралыг ашиглан аль нэгийг нь дэмжих замаар хүчийг нь улам сарниулж байлаа.

**Дотоод нөхцөл байдал:** Тухайн үед монголчууд нүүдлийн мал аж ахуйгаа эрхлэн өргөн уудам нутагт хэд хэдэн хэсэг хуваагдан сууж байв. Нүүдэлчдийн нийгмийн харилцааны онцлогоос хамааран монголчууд улс төрийн хувьд нэгдмэл бус оршиж байлаа. Монголын их хааны сүр хүч буурч, эрх мэдлийн хуваарилалт алдагдсанаар аймаг тэргүүлсэн хан ноёд хувь хувийн ашиг сонирхлыг илүүд үзэн өвөр зуураа өрсөлдөн тэмцэлдэх болов.



Лигдэн хаан эхлээд “Тайван төреөр нэгтгэх” бодлого явуулав. Тухайлбал, найман отог бүхий Цахар түмнээ монгол уламжлалаар зүүн, төв, баруун түмэн болгон хуваав. Түүнчлэн монголчуудыг бурханы шашны үзэл суртлаар нэгтгэхийг зорьж, 1617 онд Авга хар ууланд **Цагаан хотыг** байгуулжээ. Энэ нь амжилт олгоогүй тул “Дайчин төреөр нэгтгэх” хатуу засаглалд шилжсэн нь дотоодын задралыг улам түргэтвээс. Их хааны бодлого хэрэгжээгүйн улмаас Монгол орон улс төрийн талаар дахин нэгдэх болзоогүй болжээ. Түүний нас барсны дараа Өмнөд Монголын ноёд Манжийн хааны захиргааг хүлээн зөвшөөрсөн тул Халхын хан ноёд Монголын төрийн голомтыг сахин бие даасан байдлаа хадгалахын төлөө тэмцэх болжээ.

XVII зууны эхэн үед оросууд баруун Сибирийн нутгийн ихэнхийг эзлээд Эрчис гол, Дорнод Сибирь, Байгаль нуур хавийн нутаг руу давших болжээ. Ийнхүү Оросын эзэмшил Ойрад болон Халхад тулж ирснээр тэд Монголд төдийгүй Төв Азийн улс төрийн амьдралд нөлөө бүхий хүчин болов.

1639 онд Манжид дагасан Сөнөдийн Тэнгис ван харьяатаа дагуулан 1646 онд Халхын Сэцэн хан Шолойг түшихээр иржээ. Түүнийг Халхын зүүн гарын Түшээт хан, Сэцэн хан нар өмгөөлөн, мөрдөн ирсэн Манжийн цэрэгтэй байлджээ. 1648 онд Тэнгис ван буруугаа хүлээж Манжид буууж өгөв.

XVII зууны II хагасаас Халхын дотоод задрал эрчимжив. 1686 оны чуулганд Халхын баруун, зүүн гар, Манж Чин улс, Төвөдийн Далай ламын төлөөлөгч оролцов. Уг чуулганаар дотоодын хямралыг түр намжаасан боловч 1687 оноос дахин зөрчилджээ.

Түшээт хан Халхын баруун гарти довтолон Засагт хан, Сайн ноёны угсааны Дэгдээхэй мэргэн ахай болон Зүүнгар улсын хаан Галдан бошогтын дүү Доржжавыг хөнөөв. Иймд 1688 онд Галдан Халх руу довтолжээ. Галдангийн сүр хүчнээр эмээсэн Халхын ноёд албатын хамт тухайн үед Манж Чин улсын харьят болоод байсан Өвөр Монгол руу буруулан оджээ.

Галдан 1690 оны 9-р сард **Улаанбутан** (одоогийн Өвөр Монголын Хишигтэн хошууны нутаг)-д Манжид цохигдон Халхын зүг ухарчээ. 1691 онд Халх Манжийн



Тусгаар тогтнол гэдэг нь ард түмэн өөрийн газар нутгатай бүрэн эрхээ хэрэгжүүлж буй улс төрийн бие даасан байдал юм.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. XVII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ

эрхшээлд орсон нь ноёд язгууртнууд дотоодын зөрчлөө шийдвэрлэх, Оросын хаант улсын түрэлтээс хамгаалах, Галдангийн довтолгооноос зайлсхийх хэрэгцээ шаардлагатай уялдаатай байв.

XVII зууны дундуур нүүдэлчдийн сүүлчийн их гүрэн болох Зүүнгар улсын дотор ноёдын самуун дэгдэж, дотоодын дайн дажин арваад жилийн турш үргэлжилсэн нь түүний нэгдмэл, хүчирхэг байдлыг бүрмөсөн алдагдуулжээ.



Тийнхүү монголчууд ээлж дараалан төрийн тусгаар тогтолцоо алдаж, хүн ам нь үлэмж цөөрсөн төдийгүй бие даасан төрийн бодлого явуулах боломжгүй болов.

1. 1626 онд Хорчины Ууба тайж Манжийн хаанд "Цахар, Халх Манжийг дайлаар ирсэнд их цэрэг өмгөөлөн тусалсны ачаар арайхан хэлтрэв. Энэ ачийг үрийн үрд үл мартана" хэмээсний учрыг тайлбарлаарай.
2. Долооннуурын чуулган дээр Манжийн хаан "Та цөм ах дүү бөгөөд харилцан хөнөөн булааж сэв болж дарагдаж, олон аймаг сарнин хагацахад хүргүүлжээ" хэмээсний учрыг хэлэлцэрэй.
3. Зүүнгарын хаан Галданцэрэн 1731 онд Халхын нэгэн ванд илгээсэн захидалдаа "...намайг Халх, Хөх нуурын адил хошуу суманд оруулж, нэр цол өгсүгэй хэмээх тулд тийнхүү бид цэргийг байгуулж байлдан түпалдажээ. Хэрэв хэрэг бутвээс Халх, Хөх нуурыг уг ёсоор болгосугай. Хэрэв дайн цэргийн хэрэг буй аваас бүгд хүчнээр тулж, хэрхэвч хүнд эзэрхүүлэхгүй..." хэмээсэн нь тухайн үед төрийн Зүүнгар улс ямар байр суурь баримталж байсныг илэрхийлж байна вэ?

### 4. Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгэм, соёл



- Манжийн эрхшээлийн үед монголчуудын амьдралын хэв маяг хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Тухайн үеийн Монголын нийгмийн харилцааны онцлог юу байсан бэ?
- Манжийн төрийн бодлого өөрчлөгдсөнөөр монголчуудад ямар аюул тулгарсан бэ?

Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгмийн дээд давхаргыг хошууны **хан, ван, засаг ноёд, тайж, хутагт лам нар** бүрдүүлж байв. Монголчууд нийтдээ 250 шахам хошуунд хуваагдан захирагдаж байлаа.

Тайж нар нь язгууртан гаралтай бөгөөд тэдний зарим нь хамжлагатай, чинээлгэ, зарим нь ядуурч жирийн ардаас ялгарахгүй болжээ. Ихэс лам нар нь тамгатай хутагт, хүрээ хийдийн мяндагтан лам нараас

**Засаг.** Хошуу захирсан ноёдыг засаг гэнэ. 1691 онд Долооннуурын чуулган дээр Манжийн хаан Халхын 35 ноёныг "засаг" хэмээн өргөмжилжээ. Халхын засаг ноёд нь хошууг үе улиран захирдаг Чингисийн удам угсааны ноёд, тайж нар болно.

бүрдэнэ. Тэднээс хамгийн нөлөөтэй нь Халхын Жавзандамба хутагт юм. Тамгатай хутагтууд харьят шавь нарыг захирдаг байжээ.

Нийгмийн дунд давхарга болох малчин ардуудыг гүйцэтгэх алба үүргээр нь **хамжлага, сум, шавь хэмээн ялгана.**

 Ноёд тайж нарын харьят алдыг хамжлага; тамгатай хутагт, хувилгаадын харьят нарыг шавь; Манжийн төрийн алба залгуулагчдыг сүм алд хэмээн. Хамжлага, шавь нар нь ноёд, тайж, хутагт хувилгаад алба нийлүүлэн, мал сургийг нь өсгөн үржүүлэх үүрэгтэй байв.

**Сурвалж-1:** Ноёд, тайж нарын авах гувчуур: "...Аливаа монгол ван, гүн, тайж нар жил бүр өөр өөрийн албатаас алба авцгаахад таван үхрээс дээш бүхий хүнд нэг хонь ав. Хорин хонь бухийд нь нэгэн хонь ав, дөчин хонь бүхийд хоёр хонь. Хэдий олон хэмээв нэмж авбаас болохгүй. Хоёр ухэр бүхий хүнд зургаан тогого аму ав. Алба барих, чуулган чуулах, хүрээ нүүх, охин өгөх, бэр авахын зэргийн хэрэг болвоос зуун гэрээс дээш нь болвоос арван гэрийн дотроос морь нээ, ухэр тэрэг нэг ав. Тааван үнээнээс дээш бүхийд нь нэгэн малу (лонх) арз ав, зуун хониноос дээш бүхийд нь нэмж нэгэн хэсэг эсгий ав. Дэмий блонтаа авбаас болохгүй... Харьят албат хэрэв шалтгаалж үл өгөх нь бүй бөгөөс харьят ван, гүн, тайж нар дураараа өөрөө залхагтуун..."

«Гадаад Монголын төрийн засах явдлын яамны хууль зүйлийн бичиг»-ээс.

“Тэмдэгт бичиг барихын учир нь энэ Данжин Их хүрээний газраа хэдэн жил бурханы сургууль хийж баахан эрдэм сурч өдгөө хутагтын шарилын бурхан суврагаа бүтээх тус хийсний хөхүүлэн үүнд гүн билигт цол хайрлаад дээдийн алба авахыг үл хэлэлцэхээс гадна харьят ноён би үүний биеэс малын алба авахыг дархлав. Үүний тул тэмдэгийн бичиг тавьсаныг тэмдэглэв. Тэнгэрийн тэтгэсний гучин нэгдүгээр он (1766) намрын тэргүүн сарын арван”

Засаг төрийн жүн ван Далай дайчингийн бичгээс.



- Сурвалж 1, 2-ыг уншаад дараах асуултад хариуулна уу?
  - Ноёд, тайж нарын алба гувчуур адваг хэмжээг тооцоолно уу?
  - Хошууны засаг ноён ямар тохиолдолд алба гувчуураас чөлөөлдөг байсан бэ? Энэ нь хэр үнэслэлтэй гэж үзэж байна вэ?
  - Ноёд, тайж болон Жавзандамба хутагтын алба гувчууруыг харьцуулж дүгнэлт хийнэ үү?

**Сурвалж-2:** Жавзандамба хутагтын шавь нарын алба: "...Жавзандамба хутагтын сангийн шавь нарын дотроо олон засгууд (ноёд)-ын сайн хэрэг үйлдэхэд, хөрөнгө мал бүхий хүнийг өргөж ном унших хэрэгт хэрэглэгүүгэй хэмээх..."

...Үзээгүй тайж өлбөрөхөд хүрсэн хойно, албатыг хутагтад өргөвд өрөнгөв малыг гүйж амь улжуулах нь буй. Эс бөгөөс тэдний эцэг эх, үзээгүй хүүхдийг шавь нар ардад өргөвд өхдэн мал авах нь буй. Эс бөгөөс бяцханаас эцэг, эхүү, шавь алд хурааж хөвгүүн болгож тэжээх нь буй. Сангийн хуулинд тэдний шавийн ардын дотор ядуу, хөрөнгө малгүй нь болвоос сангаас жил бүр хувцас, цай олгуулан тэжээн.

Хогисон (тэнхэрэсэн) хойно нэгэн өрхийн хүний нэрийн дор хэдэн мал бүхий явдлыг гурван жил нэгэнт байцаан долоон ам бүр их мал нэжээд, хонь таваадыг хасаж агуулаад, үлдсэн малд оносон цай тавин тоонд хүрээс тавин цай авна. Тавин цайнд хүрэхгүй болвоос огт албан авах газаргүй. Энэ цайг авахад жил бүр тэмээ тутам зургаагаад цай, морь ухэр тутам дөрөөвд цай. Хонь тутам нэгжээд цай алба авна..."

Монгол Улсын үндэсний Төв архивын баримтаас.

Жавзандамба хутагтын шавийн харьят нь ямар хүмүүсээс бүрдэж байсныг тодорхойлоорой. Монголын хутагтууд Манжийн хаанд захирагдааар байсан учир шалтгааныг нотлоорой.

Монголын нийгмийн доод давхраа нь **гэрийн боолчууд** байв. Тэднийг дайны олз, худалдагсад, шагналд ирэгсэд, ялд унагсад бүрдүүлнэ. XIX зууны эцэс болоход тэд алба барьдаг хамжлага болон хувирчээ.

Манж нар монголчуудыг барьж захирах төр-цэргийн бүхий л үйл хэрэгтэй тэднийг дайчлан ашигласан юм. Монголчууд Манжийн төрд түшмэг байгаагаа илтгэсэн жасаалах алба, хааны мэдлийн болон албаны мал адгуулах, цэргийн, харуул, өртөө, цагдаа, аж ахуйн, манжийн засаг захирагааны зардал зэрэг олон зүйлийн **алба** залгуулж байлаа.

Монголд хятадын **худалдаа-мөнгө хүүлэл** ноёлж, эдийн засгийг эвдэн бусниулжээ. Монголын эдийн засгийн өрөөсгөл байдал улам гүнзгийрч, нийгмийн хөгжил саатан доройтов.

 Алба. XVII зууны үеэс эзэн хааны буюу улсын чанартай алба татварыг “алба”, ноёднын татлагыг “гувчуур” гэж ялган нэрлэх болжээ. Алба нь биеэр гүйцэтгэх ба эд хөрөнгө, малаар төлөх хоёр үндсэн хэлбэртэй байв.

XVIII-XX зууны эхэн үед монголчуудын амьдралд тодорхой хэмжээний өөрчлөлт орсон юм. Тухайлбал, аж төрөх ёс, худалдаа, шашин шутлэг зэргийг дурдаж болно. Нөгөө талаар тухайн үеийн монголчуудын нийгмийн харилцаа, эрдэм боловсрол, соёлын хөгжилд ч зарим өөрчлөлт гарав.

XVII-XVIII зууны үед монголчуудын хууль цаазын мэдлэг улам баяжиж, томоохон цаазын бичгүүд буй болжээ. «Халх журам» хуулийг Манжийн эрхшээлд орсны дараа ч хэрэглэсээр байв.

XVIII зууны 70-аад оноос эхлэн Монголд албаны сургуулиудаар Манжийн засаг захирагааны түшмэдийг бэлтгэх болов. Эрдэмтэй лам нар олширч, их, бага таван ухааны судар номыг орчуулан, өөрсдөө ном зохиол бичиж байв.

Үндэсний монгол бичгийг сургахад гэрийн сургууль чухал үүрэгтэй байв. XVIII-XIX зуунд Монголын түүхчдээс Рашипунцаг, Сүмбэ хамбо Ишбалжир, Инжинааш нар сурвалж бичигт шүүмжлэлтэй хандаж, түүхэн үйл явдлыг эргэцүүлэн үнэнийг тодруулахаар хичээж байжээ. Тухайлбал, Чингис хааны угсааны тайж, зохиолч Инжинааш монголчуудын хүчирхэг байсан түүхийг дурдан, дарлагдахыг эсэргүүцэн, идэвх зүтгэлтэй байхыг уриалжээ.

Өгүүлэн буй үед монголчууд уул овоогоо тахиж, наадмаа хийж, хувцас, эд зүйлээ урлан хэрэглэж, ургийн бичгээ тасралтгүй хөтлөн, уламжлалт хэв маягаараа амьдарч байв. Гэвч XIX зуунаас манж нар хятад соёлын нөлөөнд автаж, Монгол нутагт хятад хүмүүс ирж суурьшихыг хязгаарлаж байсан урьдын бодлогоо цуцалснаар хятад соёл тодорхой хэмжээгээр нэвтрэх болов.

**Сурвалж-3:** "...Гэрийн сургаал улсын үндэс болой...Чин улсын Энх-Амгалангийн үеэс Монголын гэрийн сургаал муудаж ирсээр, одоо ламын сургаал дэлгэрэнээс хурал чуулган дээр одоо лам нар орж, эртний хурлыг ганжуур унших хурал болов. Ноёд язгуур харцас удам ч цөм эртний сонсголыг дараа дараа умартааар ирж Чин улсын Төр гэрэлтийн\*\* оноос Монголын гэрийн сургаал их л муудаас. Улам дунд зэрээс дээш ноёд язгуурын гэрийн сургаал их л муудаас. Харин дундаас дор зэргийн сургаал эртний ёс үгийг үнэмшиж явах өрх аль олон байна. Эдүгээгийн Халх дөрвөн аймаг болон Хөх нуур зэрэг газрын өрх гэрийн дотор эртний сонсгол мэт ёстой үг аалиар явж байна. ...Гэрийн сургаал самуун болов. Тэмцэх түшээ дээгих зорилт хаанаас ирнэ..."

Лувсанчойдон. "Монголын зан аалийн ойлбор" зохиолоос.

1. Гүн ухаан, шалгадаг ухаан, дуун ухаан, зохист аялгуу, холбон найруулах, анагаах ухаан, зүрхий зэрэг ухаан юу судалдаг вэ?
2. Монголчуудын аж байдлын өөрчлөлтөд ямар ямар ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ?
3. Монголчуудын гэрийн сургаал буурсан учир шалтгааныг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээнд тайлбарлаарай.

### 5. Монголчуудын тусгаар тогтолцын төлөө тэмцэл, хөдөлгөөн



- Бослого тэмцэл гарах үеийн түүхэн нөхцөл байдал ямар байсан бэ?
- Монголчууд ямар хэлбэрээр бослого тэмцэл гаргаж байв?
- Монголчуудын тэмцэл хөдөлгөөн ямар үр дүнд хүрсэн гэж бодож байна?

**Өвөр монголчууд Манжийн эсрэг тэмцсэн нь.** Манж нар Өвөр Монголыг эзэлсний дараа Цахарт зүүн, баруун гарын найман хошууг байгуулж, Лигдэн хааны хүү Эжэйн дүү Абунаид чин вангийн зэрэг залгамжлуулан захицуулжээ. Харин Абунаid, түүний дүү Бүрни, Лувсан нар 1675 онд Манжийн ноёрхлыг эсэргүүцэн босож тэмцээд амь үрэгдсэн байна.

1755-1758 оны Манжийг эсэргүүцсэн зэвсэгт бослого тэмцлийн үйл явцад Өвөр Монголын зарим ноёд мөн оролцжээ. Манжийн төрөөс Өвөр Монголыг хянан захирах хатуу бодлого хэрэгжүүлсэн юм. XIX зууны дунд үеэс бослого тэмцэл удаа дараа гарах болсон нь Манж Чин улсын дарангуйлал, нутгийн

ноёд, хятадын мөнгө хүүлэгч худалдаачдын мөлжлөг, хятад иргэд нутаг бэлчээр булаан эзэмшиж тариа тарин суурьших болсон зэрэгтэй холбоотой байв. Тухайлбал, 1859-1868 онд Зуу-Удын чуулганаас гаралтай Байлинга, Мялсэнгэ нарын удирдсан бослого Өвөр Монголын зүүн гурван чуулганы хошууд, хязгаар мужуудыг хамран өрнөжээ.

1858, 1905-1907 онд Ордосын хошуудад гарсан **дугуйлангийн хөдөлгөөнд** оролцогод болзоот газар цугларч, дугуйран суугаад эрх баригчидтай тэмцэх аргаа хэлэлцэн тогтдог байв. Оролцогчид нь 300-800 орчим байжээ. 1905 оны намар Жирэмийн чуулганы өмнөд Горлос хошуунд **Тогтох тайжийн** удирдлагаар зэвсэгт бослого гарчээ. Тэд хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн пүүсийг эвдэн сүйтгэж, ерийн данс харааг устгаж, хөрөнгийг нь нутгийн ядууст тараан өгч байв. 1906 онд Тогтох тайж нөхдийн хамт ууланд гарч бүгэн, жил гаруй шахам хугацаанд Чин улсын цэрэгтэй 104 удаа тулалджээ. Тэд Чин улсын цэргийн давуу хүчинд дийлдэн ухарсан бөгөөд Халхын Сэцэн хан аймаг уруу зугатав.

**Сурвалж-1:** “...Бадаргуулт төрийн 34-р (1908) он, дөрвөн сард Сэцэн хан аймгийн Сан бэйсээс мэдүүлсэн нь: дээрэмчин Тогтох олон хүнийг дагуулж тус хошуунд байсан хятад пүүсүүдийн мөнгө зоос, эд барааг дээрэмдсэн...Хүрээний хэрэг шийтгэгч сайдв Янь Чжи дөрвөн сарын 13-нд сэргийлэх хорооны даргаар 13 цэрэг удирдуулан, салаан даргаар захицуулан 12 цэрэгээр туслуулан хөдөлгөөд Бичигтэй хэмээх газар хүрээд тулалдаж Тогтохын хулгай хүмүүсээс нэгийг алж, Хүрээний цэрэгээс нэг шархдаа. Тогтох даруй хүмүүсээ дагуулан Оросын хязгаарт оргон орсон...”

Чэнь Чунь цүү. «Гадаад Монголын ойр үеийн түүх» зохиолоос.



Э. Тогтох тайж  
(1863-1922)



Тогтох тайж хятад пүүсүүд рүү довтлох болсон шалтгаан юу байж болох вэ?

Сурвалж 1-д өгүүлсэнчлэн Тогтох тайжийг дээрэмчин хэмээсэнтэй та санал нийлэх үү? Яагаад?

1907 онд Жирмийн чуулганы Жалайд хошуунд тайж гаралтай Цогдалайн удирдсан зэвсэгт бослого гарчээ. Энэ бослого бэлчээр нутгаа хамгаалахыг гол зорилго болгосон тул Чин улсын засгийн газар уг хошуунд газар хагалбарлахаа түр зогсоосон байна. Манж Чин улсын ноёрхлын эсрэг шинжтэй байсан тэмцэл XIX зууны сүүлч гэхэд Манжийн дарангуйлал, газар хагалбарлах, хятад тариачдад газар түрээслэх, худалдах, харийн шашныг дэлгэрүүлэхийг эсэргүүцсэн шинжтэй болжээ.

**Ойрад монголчууд Манжийн эсрэг тэмцсэн нь.** 1723 онд **Лувсанданзан** тэргүүтэй ноёд Хөхнуур, Төвөдийн бие даасан байдлыг хадгалахын төлөө зэвсэгт бослого гаргав. Тэд Зүүнгар улсаас тусламж авч чадсангүй. Учир нь, Хөх нуурын зарим ноёд Зүүнгарын Цэвээнравдантай дайсагнасан харилцаатай байв. Манж Чин улс Хөх нуурт гурван замын их цэрэг оруулан 1723-1724 онд Лувсанданзангийн цэргийг бут цохисонд, Лувсанданзан Зүүнгар руу зугатан гарчээ.

XVII-XVIII зууны Монголын тусгаар тогтолын тэмцлийн дотроос хамгийн далайцтай нь **1755-1758** онд гарсан бослого юм. Тэрхүү бослогыг Зүүнгарын **Амарсанаа**, Хотгойдын ван **Чингүнжав** нар удирдджээ. Амарсанаа 1755 оны 11-р сарын 11-нд Бор талын газар биээ Зүүнгарын хаанд өргөмжлөв. Гэвч эцэстээ Амарсанаа, Дондогмаанж тэргүүтэй бослогын удирдагчид хүчээ нэгтгэн тэмцэж чадсангүй, харин ч өөр хоорондоо тэмцэлдэж ялагдал хүлээжээ. Амарсанаа ялагдаад, Хасагийн зүг зугатан гарчээ. Дондогмаанж Манжийн цэрэгт цохигдсон боловч 1756 оны эцсээр үлдсэн цэргийн хамт Цоросын хан Галсандорж, Хойднын хан Баяр, зaisan Занагарбу, Ням нартай хамтран тэмцэж, Манжийн цэрэгт цохилт өгчээ. Харин Занагарбу, Ням нар хаан ширээ булаацалдан, Галсандоржийг барьж алав. 1757 оны 3 сарын үед Амарсанаа нутагтаа буцан ирсэн боловч тэд хүчээ

нэгтгэж чадалгүй Манжийн эсрэг тус тусдаа тэмцсэн юм. 1757 оны 6-7-р сард Амарсанаа 3000 цэргээ удирдан Манжийн цэрэгтэй хагас сар орчим тулалдсаны эцэст ялагдал хүлээжээ. Тэрээр цөөн хүний хамт Орост зугатан очоод өвчний учир нас эцэслэв. 1758 оны эцэс хүртэл Зүүнгарын босогчид хэсэг бүлгээр тулалдаар байжээ. Манжийн цэрэг хааныхаа зарлигаар, 1757-1760 оныг хүртэл Зүүнгарын монголчуудыг олон арван мянгаар нь хядсан юм.

**Сурвалж-2:** "...Тэр хир дагасан тэргүүлсэн хулгай Амарсанаа хойд замын хязгаар дахиньг тогтоох зүүн этгээдийн туслаач жанжин болон явах бөлгөө. Даваач баригдсаны хойно Амарсанаа аргадаж, Илийн газрыг ээлслүүэй хэмээсний тулд хаан түүний зальтыг айлдаад зарлигаар түүний ах Чимхүүртэн лугаа хамт бааралхуулан аваачаар одоохуйд умар дахиньг тогтоогч жанжин Банди, Нуцгэний цэргийн хүрээнээс Эринчиндоржийн гаргаж, харгалзуулан мордуулбай. Чимхүүр Амарсанааны тэрслүү төв мэдэгдсэнэйн мэдээд Эринчиндорж лугаа барьтугай хэмээн нарийвчлан дуртгаваас уг эс авбай. Өрөнгийн газарт хурсний хойно Амарсанаа хойт замын хязгаар дахиньг тогтоох зүүн этгээдийн туслаач жанжны тамгыг Эринчиндоржид тушааж, нутагт буцаж ачаа тээшийг засацаасугай хэмээн хуурмагаар хэлэлцэж, Эрчис голоос яаран оргоов. Хойт өдөр Эринчиндорж гүйцвээс (нэхвээс) гүйцэнгүй..."

Галдан туслаач "Эрдэнийн эрих хэмээх түүх болой" зохиолоос.

1. 1755 онд болсон энэхүү үйл явдал нь туслаар тогтнолын тэмцлийн эхлэл мөн уу? Яагаад?
2. Сурвалж-2-оос Манжийн хаан Амарсанаад үл итгэн хэнээр харгалзуулж байсныг тодруулаарай.
3. Халхын Эринчиндорж ванг Амарсанаатай хувалдсан хэмээн үзсэн нь хэр үндэслэлтэй вэ?
4. Алтайн нурууны өврөөс эх аяч Хөөдүн Булган голтой нийлээд Өрөнө нэртэй болж Улэнгэр нурт цутгадаг голыг газар зүйн зураг ашиглан олж тэмдэглээрэй.

**Халх монголчууд Манжийн эсрэг тэмцсэн нь.** 1750-иад онд Манж нар Зүүнгар улсыг эзлэх аян дайнд бэлтгэх явцад Халхаас авах Манжийн алба нэмэгдэж, ард түмний байдал эрс доройтсон нь зэвсэгт тэмцэл өрнөх нөхцөл болов. Манжийн ноёрхолд Халхын **II Богд Жавзандамба** хутагт, Түшээт хан Ямпилдорж, Засагт хан Балдир, Сэцэн хан Манибадар, Сайн ноён Дэчинжав, Дамиран гүн зэрэг том ноёд ихэд дургүйцэж, битүү эсэргүүцэж байв. 1756 оны 4 сард чин ван Эринчиндоржийг Амарсанаагийн хэрэгт холбогдуулан цаазаар авсан нь **II Богд тэргүүтэй Халхын** том язгууртнуудыг тэмцэлд өдөөжээ.

1756 оны 6-7 сарын үед Манжийн хааны зарлигаар Зүүнгарын бослогын эсрэг хөдөлгөсөн их цэргийн нэгэн багийг толгойлж явсан шадар ван Чингүнжав дайны талбараас босож, цэргээ удирдан нутгийн зүг явав. Мөн Түшээт хан, Засагт хан, Сэцэнхан, Сайн ноён нарын зэрэг олон ноёд Манжийн харуул, өртөө, цэргийн албыг хаяж, тус туслын нутагт нэгэн зэрэг буцсанаар зэвсэгт тэмцэл эхэлжээ.

Бослогын цэргийн багууд Манжийн цэрэг, хятадын худалдаачдын суусан хот суурингууд болон салангид тусгай явсан манж түшмэд, хятад худалдаачид, урвагч монгол ноёдыг цохиж байв. Мөн зарим өртөөний ард босож, Манжийн цэрэг, түшмэдийн унаа залгах боломжийг тасалдуулав. 1756 оны 11-р сарын үеэр бослогыг даруулахаар томилсон Улиастайн жанжин Цэнгүнжав Хотгойдын зүг дайрав. Бослогод нийлсэн олонх ноёд Манжийн цэргээс айж тус туслын цэргийн хамт салж явсан тул Чингүнжавын цэрэг ихэд цөөрч, тэрбээр Шишгид голын зүг ухарчээ. Чингүнжав Манжийн цэрэгт баригдаж, Бээжинд гэр бүл, эхнэр хүүхдийн хамт хүргэгдэн, 1757 оны 3-р сарын 11-нд цаазлуулсан юм.

1757-58 оны үест **II Богд** болон Түшээт хан Ямпилдорж, Засагт хан Балдир, Сэцэн хан Манибадар, Дамиран гүн нарыг манж нар хорлох, шийтгэх зэргээр яллажээ.

Монголын ард түмний 1755-1758 оны туслаар тогтнолын төлөөх зэвсэгт бослого дарагдаж, удирдагч Амарсанаа, Чингүнжав нар амь үрэгдсэн боловч монголчууд тэрхүү тэмцэл, түүний удирдагч нарыг алдаршуулан дурссаар ирсэн нь туслаар тогтнолоо сэргээх их тэмцлийн уриа дуудлага болсон билээ.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. XVII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ

**Сурвалж-3:** "... Чингүнжав оргосон Урианхайг нэхэж Хөх усны зэрэг газарт хүрээд цаашаа давших орсондуй дур мэдэн цэрэгээ авч хойш буцсан бөгөөд түүний айлтгасан нь: Олон халхчууд гаслалдан хэлэлцэнэ. Бас Амарсанааг барихад дэмий л олныг зовоож улсын цалинг ашиггүй сүйтгэнэ. Цэргийг бүрмөсөн татаж өвөл нарыг уг нутагт илрээж, олон амьтныг жарааваас зохино. Хэрэв удтال ясаар нэгэн хэрэг гарч ирвэл улсын нэрд холбогдсон явдал буй гэж огoot дайлсан, тэрсэлсэн адил дэмий хэлэлцжээ ....энэ ангид үгаас Урианхай цэрэг 500, Хотгойд цэрэг 250, Халх цэрэг 100 илүү, бүгд 800 илүү цэрэг байв."

Хэрэг шийтгэх сайд Шумин, Арантай нараас Манжийн ханд айлтгалаас. (1756.7.21).



- Сурвалж 3-т ямар үйл явдлын талаар өгүүлж байна вэ?
- Сурвалжийн мэдээнд тулгуурлан дүгнэлт хийгээрэй.

XIX зууны үе болоход монголчуудын тэмцэл эдийн засаг, улс төрийн шинжтэй болж өөрчлөгдөв. Алба татвар, хятад худалдаачдын мөлжлөгийг эсэргүүцэх нь улам опширчээ.


Сайн ноён аймгийн олон хошууны цэргүүд 1880 оны 7-р сарын 12-нд Онолтоор удирдуулан бослого гаргажээ. Тэрхүү бослогод 247 цэрэг хамрагджээ.

Ихэтуаны бослогыг даруулахаар Халх Монголоос татсан 2000 монгол цэрэг 1900 онд Улиастайд Энхтайваны удирдлагаар бослого дэгдээв. 1910 онд Их Хүрээнд лам нар хятадын мөнгө хүүлэгчдийг эсэргүүцэн тэмцэв. Мөн үед Ховдод хятад худалдаачдыг эсэргүүцсэн хөдөлгөөн гарчээ.

XX зууны эхнээс Манжийн **"Шинэ засгийн бодлого"** хэрэгжиж, асуудал монголчууд угсаатны хувьд орших эсэх хэмжээнд тавигдав. Энэ бүхэн ард түмний эсэргүүцэл тэмцэл улам хүчтэй өрнөхөд хүргэсэн ажээ.



**Шинэ засгийн бодлого.** Манж хятадаас Монгол зэрэг нутаг орныг алдахгүй байх, нöөрхлоо батлагах үүднээс 1902 оноос хэрэгжүүлж эхэлсэн улс төр, эдийн засаг, соёлын шинэтгэлийн бодлого. Энэ хүрээнд хятад тариачдыг Монголд нүүлгэн шилжүүлж эхэлжээ.



1. Монголчуудын бослого тэмцлийн голомтыг газар зүйн зурагт зааж тэмдэглээрэй.
2. 1675, 1723, 1750-цад оны тэмцлийн үе шатууд юу шэрхийлж байна вэ?
3. Монголчууд хүчээ нэгтгэж чадаагүй нь Манжийн төрийн бодлого, нүүдлийн аж төрөх ёс, газар нутгийн алслалын зэрэгцээ бие даах салан тусгаарлах узлэлтэй холбоотой юу?
4. Тэмцлийн хэлбэрүүдийг жагсан бичиж, гол хэлбэрийг нь яланг тодруулаарай.
5. Монголчуудын бослого тэмцэл нь дараагийн ямар үйл явцыг нөхцөлдүүлсэн бэ?

## II БҮЛЭГ. МОНГОЛ УЛС СЭРГЭН МАНДСАН НЬ (1911-1924)

1911 он	1915 он	1921 он	1924 он
Монголчууд тусгаар тогтнов.	Монгол Улс автономит болов.	Үндэсний хувьсгал ялав.	Хаант засгийг халав.



- Юуны учир 1911 онд Монголд эрх чөлөөний хувьсгал өрнөв?
- Тусгаар тогтнолын үнэ цэн, ач холбогдол юунд орших вэ?

### 1.1911 оны хувьсгалын ялалт, ач холбогдол

XIX зууны сүүл үеэс нийт Монгол даяар Манж-хятадаас салж, тусгаар тогтнох арга зам эрэлхийлэн тэмцэх болов. Харийн эрхшээл дор, ядуу буурай аж төрж ирсэн хийгээд олон улсын байдал хурцдаж, их гүрнүүдийн өрсөлдөөн хүчтэй болсон зэрэг олон хүчин зүйл үүнд нөлөөлжээ. Чин гүрний төрийн бодлого өөрчлөгдэж, “Шинэ засгийн бодлого” хэрэгжүүлж эхэлсэн нь нэрмээс болов.

**VIII Богд Жавзандамба** хутагт тэргүүтэй Монголын ноёд язгууртнууд тэрхүү тэмцлийг манлайлан удирдсан билээ. Тэд Өвөр монгол, Хөх нуур, Барга, Алашаа зэрэг бүх монголчууддаа хандан тусгаар улс байгуулах цаг болсныг зарлан мэдэгдэв. Мөн тус туслын харьят хошуу нутгаас манж, хятад түшмэдийг хөөн гаргаж, эрх мэдлээ эргүүлэн авахыг уриалж байлаа. Тэр үеийн эх орончид бүх **МОНГОЛ ОВОГТНОО** нэгтгэсэн Их Монгол Улсаа сэргээн байгуулахыг зорьж байв.

1911 оны 12-р сарын 29-нд Монгол Улс тусгаар тогтносныг даяар олонд тунхаглан зарлав. VIII Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын шашин, төрийг хослон баригч, наран гэрэлт Богд хаанаар өргөмжилжээ. Төрийн 5 яамыг байгуулан, оны цолыг **Олноо Өргөгдсөн** хэмээн тогтоож, Их Хүрээг Нийслэл Хүрээ гэж нэрлэв. Төр улсын бүхий л эрх мэдлийг монголчууд барьж, аливаа хэргийг өөрсдөө мэдэж шийдэх болов. Тийнхүү Монгол Улс дахин сэргэн мандаж, дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн туурга тусгаар төр улс болон тогтнон хөгжих эхлэл тавигдсан билээ. Тийм ч учраас энэ өдөр нийт монголчууд баясан хөөрч, сүслэн залбирч, ёслон тэмдэглэжээ.

**Олноо өргөгдсөний он.**  
1911 оны 12-р сараас  
1924 оны 11-р сар хүртэл  
Монголд “Олноо өргөгдсөн”  
хэмээх оны цолыг хэрэглэж,  
тулаар “Монгол улсын” болгон  
өөрчилж хэрэглэжээ.

1911 оны 12-р сарын 29-ний өдрийн яз ёслол болсон цаг мөчид Хоөд, Улиастай, Алтанбулаг, Ерөө зэрэг олон газар, Монголын өнцөг булан бүрт хумуус Хүрээний зүг ханёдаж, нэээн зэрэг сөгдөн мөргөж, зул, хүж өргөн баясчээ. Үүнийг биеэр үзсэн гадаадынхан олон монголчуудын нүд үрд өмнө хэзээ ч ингэж очтон гэрэлтэж байсныг хараагүй хэмээн бичсэн байдаг. 1911 оны хувьсгал нь нийт монгол угсаатны хүсэн хүлээсэн үйл явдал, үндэсний сэргэн мандлын үзэл санааны бодит үр дүн байв. 2011 оноос хойш энэ өдрийг дахин улс үндэсний бүх нийтийн баярын өдөр болгон тэмдэглэж байна.

- Монголчууд баярлан хөөрч, сүслэн залбирах болсны учрыг ярилцаарай.


Монголын төр 1912 оны 1-р сард Улиастайг, 8-р сард Ховдыг чөлөөлж, 1913 онд Өвөр Монгол руу 5 замын их цэргээ илгээсэн билээ.

1911 оны хувьсгалын үр дүнд Монгол Улс Манж Чин гүрний эрхшээлээс гарч, олон улсын хуулийн этгээдийн хувьд **де факто** тусгаар улс болсон юм.

Хувьсгалын ялалтын үр дүнд улсаа улс шиг улс болон эмхлэн тохишуулахад чиглэсэн олон арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж нээгдэв.

**Де-факто (de facto).**  
Тухайн улс хэрэг дээрээ бодитойгоор оршин буйт,  
тэр улсыг “тодорхойгүйгээр”  
хүлээн зөвшөөрч буйг  
илэрхийлэх нэр томъёо.

Зураг 1. Монгол Улсын засаг захиргааны хуваарь. 1911-1923



1. 1911 оны хувьсгалыг оройлон тэмцэн ямар эх орончдыг ТА БҮХЭН МЭДЭХ ВЭ?

2. Улс орныхоо төлөө тэмээчийн нэр алдар түүхэнд тодор тэмдэглэгдэн улдээгийн учир ку вэ?

3. Газарын зурагт тулгуурлан тухайн үеийн Монгол Улсын засаг захиргааны хуваарийг өнөөгийн хуваарытай харьцуулж судална уу.

4. Газар зүйн зураг дээр өөрийн оршин сурж буй нутгийн тухайн үеийн засаг захиргааны харьцалыг барилж авсан подорхойлно уу.

## 2. Монгол Улсын сэргэн мандлын эхлэл (1911-1920)



- Улс орон оршин тогтоно, хүчирхэгжихийн үндэс суурь юунд орших вэ?
- Бусдын нөлөө, дарамтад орохгүй байхын тулд бид ямар байх ёстой вэ?

1911 оны хувьсгал ялсан тэр цаг мөчөөс туурга тусгаар Монгол Улсын үндэсний сэргэлт, хөгжил, дэвшлийн шинэ түүх эхэлсэн юм. Энэ түүхийн эхний хуудас 1911-1920 онд бичигдсэн билээ.

Шинэ тулгар Монгол Улс оршин тогтоно, хүчирхэгжихийн тулд төр улсаа бэхжүүлэх, төрийн байгууллаа төгөлдөржүүлэх, цэргийн хүчээ зузаатгах, эв нэгдлээ сахин хамгаалах, эдийн засаг, соёлоо сэргээн хөгжүүлэхийг чухалчилж байв.

Юуны өмнө төр улсаа засан тохинуулах, төрийн байгуулал, засаглалын тогтолцоогоо боловсронгуй болгохыг зорьж байлаа. Дээд, Доод танхим бүхий Улсын хурлыг 1914 онд байгуулсан нь улс төрийн аливаа хэргийг олноороо зөвлөн хэлэлцэж, гарц шийдэл олох ардчилсан зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дэвшилтэй алхам байсан юм.

**Сурвалж-1:** "...Улсын сүрийг бадруулан хаан ээний өмнө, шашин төрийн төлөө зүтгэхэд хялбарыг эрэхгүй, бэрхээс зайлхагүй, эдүгээгийн байгуулсан төрийн тул энэхүү батлан тогтоосон тангараг сахилыг нүдний цөцгий, зүрхний топът мэт хичээнгүйлэн хайрлана".

Төрийн түшмэдийн өргөдөг тангарагаас.

Монгол Улс байнгын цэрэгтэй болох, цэргийн эрдэмд сургах, зэр зэвсгээр хангах арга хэмжээ авчээ. Цэргийн насны эрчүүдийг дайчлан татах замаар цэргийн хүчээ бүрдүүлэв. 1912 онд Хужирбуланд цэргийн сургууль байгуулж, 1913 онд монгол цэргийн дагаж мөрдөх 23 зүйлтэй дүрэм гаргажээ. Оросоос зэр зэвсэг, цэргийн сургагч авч ажиллуулав.

Хууль цаазаа шинэтгэхэд анхаарч, "Жинхэнэ дагаж явах хууль дүрэм", "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг"-ийг боловсруулан гаргав. Олон улсын жишгээр Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлж, Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн даалгавраар Ж.Цэвээн "Улсын эрх" гэх бүтээл гаргажээ.

**Төрийн алба хаагчдыг алба үүрэгтээ хайнга хандсан, хуурмаг үйл ажиллагаа явуулсан бол зэрэг, хэргэм бууруулах, 100 ташуур жанчих, 35 дөнгөө дөнгөлөх, жилийн пүнлүү /цалин/ хасах, малаар торгоо шийтгэл оноож байжээ. Тэрчлэн Улсын хурлаас хоцрох, таслах тохиолдолой тогтоосон хэмжээний зулын шар тоосор торгодог байлаа.**

Монголын төр улс орныхоо аж ахуй, эдийн засгийг сэргээн хөгжүүлэх тодорхой алхмуудыг хийв.

Мал сүргээ өсгөн үржүүлэх, эрүүлжүүлэх, газар тариалан хөгжүүлэх, өвс хадлан бэлтгэх бодлого явуулав. 1913 онд 30-аад зүйлтэй гэрээ байгуулж, Оросын малын эмч нар Монголын төв ба хойд нутагт ажиллажээ. Тэд үхрийн мянган өвчнөөс сэргийлэх тарилтыг 121000 гаруй үхэрт хийсэн байна. Албаны тариаланд хэрэглэх анжис, борной, хүрэ, шар үхэр, морь зэргийг буцалтгүйгээр өгч дэмжлэг үзүүлж байлаа. Одоогийн Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгоны ойролцоо Богдын сангийн өвс хадах газрыг байгуулав.

Ноос угаах, арьс шир, өлөн гэдэс боловсруулах, цайны навч түүж боловсруулах газар, зэвсгийн засварын газар, мод, шил зүсэх газар, төмрийн дархны газар, тоосго цохих газар, мал нядлах газар, савангийн үйлдвэр, утсан холбоо, цахилгаан гэрлийн хороо, хэвлэлийн хороо зэрэг 370 орчим үйлдвэрлэл, үйлчилгээний газар байгуулагджээ. Тэдгээрийн ихэнх нь гадаадын үйлдвэр

эрхлэгчдийн мэдэлд байсан хэдий ч монголчууд тэдгээрт ажиллаж, тэднээс суралцаж байлаа.

Уурхай баялгийг ашиглах явдалд анхаарч, 1913 онд "Монгол улсын хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ"-г батлав. Дүрэмд зааснаар олборлосон цагаан алт, очир алмас, эрдэнийн чулууны орлогын 20-50%-ийг, чулуун нүүрсний 5-10%-ийг татварлах болжээ. Мөн ой мод, ургамал, мөөг, жимс, загас зэрэг баялгаа ашиглахын зэрэгцээ гадаадын пүүсээс ашгийн татвар авах болов.

Монгол дахь Хятадын худалдаа мөнгө хүүллийн үйл ажиллагааг хязгаарлах, нөлөөг багасгах, зарим өр ширийг хүчингүй болгох арга хэмжээ авчээ.

1912 оны Монгол-Оросын гэрээгээр орос худалдаачид гаальгүйгээр худалдаа эрхлэх эрхтэй болов. 1912-1915 онд Оросоос Монголд худалдаалах бараа 2 дахин нэмэгдэж, Монголын зах зээлийн хэрэгцээний 35 орчим хувийг хангаж байжээ. Гадаад, дотоод худалдаа тогтвортожиж, монголчуудад ч худалдаа эрхлэх таатай нөхцөл бүрдсэн юм. Цэдэвсүрэн, Чагдаржав нарын худалдаачид 1918 онд мал, малын түүхий эдийг гадагш гарган худалдах Харилцан туслах хоршоо байгуулж байжээ.

Монголын Засгийн газар улсын санхүүг цэгцэлж, 1914 оноос улсын нэгдсэн төсөв бий болгов. 1916 онд "Улсын хөрөнгийг захирагазар"-ыг байгуулж, үндэсний банк байгуулах, мөнгөн тэмдэгттэй болохыг эрмэлзэж байлаа.

Монгол Улсын сэргэн мандалтыг **соёл, боловсролоо эрхэмлэн хөгжүүлэхээс** ангид үзэх аргагүй. Монголын төр соёлын шинэтгэл, өөрчлөлт хийхэд ихээхэн анхаарчээ. 1912 онд 47 сургачтай анхны иргэний сургуулийг Нийслэл Хүрээнд байгуулав. Улмаар орон нутагт 60 гаруй бага сургууль хичээллэх болжээ. Мөн Орос хэл, бичгийн сургууль нээж, Хаант Орос улсад хүүхэд запусаа явуулан сургаж эхлэв.

1913 оноос "Шинэ толь", 1915 оноос "Нийслэл Хүрээний сонин бичиг" зэрэг тогтмол хэвлэл бий болсон нь олон түмний соёл гэгээрэлд хувь нэмрээ оруулж байлаа.

**Сурвалж-2:** "Эдүгээ монголчууд нэгэнтэй тулгар төр байгуулж, тусгаар улс болсноос хойш зүй нь элдэв эрдэмд боловсорч, яаравчлан хүчтэй чийрэг болохыг хичээвээс зохих тул манай бичгийн хороо гадаад олон улсын хэрэглэж ахуй зүйл бүрийн эрдмийг томьёолон бичиж... олон монголчуудын эрдэм сурахад нэмэр болгоно. Үүнээс гадна цагийн байдлыг дагаж Монгол Улс төр лүгээ холбогдсон чухал сонин зүйлийг хураангуулан тоочилж бичээ. ... Ертөнцийн байдал, элдээхийн дээрх хүн төрөлхтний балар эртнээс нааш улаан улмаар аж төрсөн ба ухаан эрдэмд боловсролоор ирсэн түүх, Монгол ба бусад олон улсын түүх, тооны ба одны шинжлэх ухаан, элдэв зүйлийн гайхамшигт цадиг, аж төрөхийг засах ба хүний бие сувиллын зүйл эдгээрийг мэдэх чадахын хэрээр гаргаж байх болно". "Шинэ толь" хэмээх сонин бичгийн эхний дугаараас.

1918 онд "Зарлигаар тогтоосон Монгол Улсын шаштийр" гэх 12 дэвтэр түүхийн бүтээл гарчээ. Эрх чөлөөгөө тэмцэн олсон монгол түмний үндэсний үзэл, сэтгэлгээ сэргэж, аман зохиол, урлагийн хөгжилд шинэ дэвшил гарав.

1. Сурвалж-1 болон нэмэлт мэдээлэлд тулгуурлан төрийн албан хаагчдын ёс зүй, үүрэг, хариуцлагыг өнгөрөн, одоо, ирээдүй гурван цагийн холбоо хамааралд нь тайлбарлана уу.
2. Эдийн засгийн хөгжил улс орны оршин тогтнол, сэргэн мандалтай ямар хамааралтай болох талаар асуудал дэвшүүлж шийдвэрлээрэй.
3. Сурвалж-2-ын мэдээллийг уншаад тухайн үед соёл боловсролын талаар ямар бодлого баримталах байсныг тодорхойлно уу.
4. Тэр үеийн сонин, сэтгүүлийн нийтлэлийн бодлого, зорилго ямар байсныг орчин үетэй харьцуулан дүгнээрэй.

### 3. Монгол Улсын тусгаар тогтнолын хувь заяа



Улс орны тусгаар тогтнол юугаар баталгааждаг хүчин зүйлс юу вэ?  
Улс орны оршин тогтнолд их гүрнүүдийн бодлого хэрхэн нөлөөлдгэвэ?

**Монгол Улсын гадаад орчин.** 1912 оноос Монгол Улс тусгаар тогтнолоо олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх, нийт монгол түүргатнаа чөлөөлөн нэгтгэхийн төлөө шаргуу тэмцэв. Дэлхийн улс орнуудтай харилцаа тогтоох, гэрээ байгуулахыг чухалчилж байв. Гэвч хоёр хэрш, тэдний байр суурийг харзасан бусад улсууд ч Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байлаа.

**Сурвалж-1:** “Бүгд найрамдах Дундад Иргэн Улсын нутаг дэвсгэр нь 22 муж, Ар, Өвөр Монгол, Төвөөд, Хөх нуураас бүрдэнэ”. Дундад Иргэн Улс (ДИУ)-ын түр Үндсэн хуулийн 3-р зүйлээс. (1912.3.10.)

Монгол Улс Хаант Оросыг түшиглэн тусгаар тогтнолоо бэхжүүлэхийг зорив. 1912 оны 11-р сарын 3-нд Нийслэл Хүрээнд Монгол, Оросын хооронд Найрамдлын гэрээ байгуулав. Энэ үйл явдал Монгол Улс бие даан оршиж буйг нотлон харуулсан юм. Энэхүү гэрээгээр Орос улс, Гадаад Монголыг **автономит эрхтэй** оршин тогтох, Хятадын цэрэг оруулахгүй байхад нь туслах үүрэг хүлээхийн хамт Монголд худалдаа эрхлэх давуу эрх олж авчээ.

Хятадын тал дээрх гэрээг ихэд эсэргүүцэж, улмаар Оростой далдуур хэлэлцэн тохиролцож чаджээ. Орос, Хятад хоёр 1913 оны 11-р сарын 8-нд Бээжинд, Монголын тухай тунхаг гаргав. Түүнд, Орос улс, Монгол дахь Хятадын эзэн эрхийг хүлээн зөвшөөрсөн бол ДИУ, Гадаад Монголын автономитыг хүлээн зөвшөөрчээ. Энэхүү Тунхагийг Монгол Улс эрс эсэргүүцэж байлаа. Энэ бүхэн Орос, Хятад, Монгол гурван улс Хиагтад хэлэлцээр хийх үндэс болов. Монголын асуудлаар санал зөрөлдөж байснаас, 1914 оны 9-р сард эхэлсэн хэлэлцээр 9 сар сунжран үргэлжилжээ. 1915 оны 6-р сарын 7-нд баталсан Хиагтын гэрээгээр Монголд автономит эрхийг тулган хүлээлгэсэн



**Тусгаар тогтнол** бол тухайн улс үндэстний бие даасан бүрэн эрхт байдал, хараат бус төр засаг, үндэсний язгуур эрх ашиг, хил хязгаарын халдашгүй дархан байдал, түүх, хэл, соёлын дархлаа, хүн ардын эрх, эрх чөлөө, хөгжил дэвилийн баталгаа юм.

юм. Гэсэн хэдий ч Монгол Улс нь тодорхой хил хязгаар, нутаг дэвсгэртэй, өөрийн эзэн хаантай, үндэсний засгийн газар, цэрэг армитай, бусад улстай худалдаа, эдийн засгийн гэрээ, хэлэлцээр байгуулах эрхтэй байсан билээ. Тиймээс, бусад улс орнууд хүлээн зөвшөөрөөгүй ч Монгол Улс тусгаар тогтносон улсын шинжтэй оршиж байсан гэж үздэг.



Тусгаар тогтнол гэдгийг бид хэрхэн ойлгох вэ? Тусгаар тогтносон улс орон гэдгийг олон улсын хүрээнд хэрхэн тодорхойлдог вэ?

**Сурвалж-2:** “Нэгд, байнгын хүн ам; хоёрт, тухайлан заагласан нутаг дэвсгэр; гуравт, төр засаг; дөрөвт, бусад улсуудтай харилцаанд орох чадамж”... “бусад улсуудаар хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь улсыг тодорхойлох хүчин зүйл болохгүй.”

“Улсуудын эрх, үүргийн тухай Монголын Конвенцii”-ийн 1, 3-р зүйлээс. (1933.)

Гадаад Монголын нутаг дэвсгэрийг Халхын 4 аймаг, Ховд, Хөвсгөлийн хязгаар, Дарьганга хошуугаар хязгаарласны уршгаар бусад монгол түүргатнаа нэгтгэх боломж олон улсын эрх зүйн хүрээнд хаагдаж, бусад монголчууд хилийн гадна тасран үлдэх үндэс тавигджээ.

**Монголын автономит эрхийг цуцлав.** 1917 оны 2-р сарын хувьсгалаар Орост хаант засгийг түлхэн унагаж, улмаар 10-р сард большевикууд засгийн эрхэнд гарав. Үүний улмаас Орост иргэний дайн дэгджээ. Энэ завшааныг ашиглан



**Автономит эрх.**  
Өөртөө засан тогтноо эрх гэх утгатай, аль нэг эзэн улсын хяналтын дор оршиж, дотоод эрх мэдлээ бие даан хэрэгжүүлэх эрх.

Хятадын засгийн газар Оросын хаант төр үгүй болсон тул “Хиагтын гурван улсын гэрээ”-г хүчингүй гэх болов. Монгол улсын гадаад орчин нэн эздрээтэй болж, Монголын эрх баригчид Орос дахь үймээнээс түгшин, дотор зуураа санал зөрөлдөөнтэй байв.

Монгол дахь Хятадын төлөөний сайд Чэнь И энэхүү нөхцөл байдлыг ашиглан Монголын автономит эрхийг цуцалж, Хятадад нэгтгэх бодлого явуулж эхэлжээ. Тэрээр Монголын эрх баригчдыг ятган автономит эрхээс татгалзуулах зорилгодоо хүрэхийг хичээв.

**Сурвалж-3:** Хятадын Засгийн газар, Гадаад Монголын нийслэл Өргөөд суугаа Хятадын элчин сайд Чэнь И-гээс Монгол хошуудын тэргүүдийн гарын үсэг бүхий өргөдөл бичиг хүлээн авсныг уламжлсан илтгэл авав. Уг өргөдөл бичигт монголчууд хэдэн жилийн өмнө далаалд үйүүлэгчдэд мэхлэдэн автономийг тунхагласан боловч тэр цааас хойш оросуудад дээрэлхүүлэн бүйгаа нэн тодорхой өгүүлжээ... Тэд өргөдөл бичигтээ автономийг халж, Хятадын засгийн газрын ивээлд эргэн баатх хүслээ илэрхийлж байна... Чэнь И өргөдөл бичгийг зөвшөөрөхийг зөвлөөд, хэрэв [Хятадын] засгийн газар тээнэгэлзэх аваас боломжийг үүрд алдаж магадгүй хэмээн нэмж сануулсан байна. Засгийн газар уг саналыг зөвшөөрч, цалин, тэтгэмж амлаад, энэ зорилгоор 800,000 америк доллар гаргахаар шийдвэр тухай цахилгаан мэдээг Чэнь-И-д илгээв.

АНУ-ын “Нью-Йорк Таймс” сонины мэдээнээс. (1919.10.31).

Ерөнхий сайд Г.Бадамдорж Богд хаанд биеэр бараалхаж, автономит эрхээсээ сайн дураар татгалзах, Чэнь И-гийн тулган шаардлагыг дамжуулжээ. Гэвч Богд хаан шаардлагыг шууд хүлээж авсангүй. Бадамдорж дахин Чэнь И-тэй уулзаж, автономит эрхээс татгалзах нөхцөлүүдийг тохирсон гэрээ бичиг үйлдэхээр тохирчээ. Чэнь И “Гадаад Монголын хойчийг сайжруулах 64 зүйл” гэх гэрээний төсөл боловсруулж, түүнийгээ Монголын эрх баригчдаар хүлээн зөвшөөрүүлэхийг оролдов. Гэвч 1919 онд Хятадын генерал Сюй Шүжан гэгч Монголд томилогдон ирсэн нь байдлыг өөрчилжээ.

**Сурвалж-4:** "...Богд хаанаас Хятад элчин Чэнь И-г Монголын засгийн эрх баригчид лугаа нам нийлж автономит засгийн устгахаар хүйеэлдэв хэмээн битүүлэг буруушааж...бас ч ард олоны зүгээс засгийн эрх баригчдаас Хятадад төрөө худалдахаар сэдээлэв хэмээн цуу уг тасралтгүй сонсдох ба Хүрээний гол хурдан дор нэрэгүй бичиг наалдуулж шүүмжлэх эзргээр шар, хар олонх ард автономит засгийг устгаж Хятадад нийлхийг дурлах үүгүй байдал илрэхий мэдэгджээ. Энэ нь Олноо Өрөөгдсөний 9 дүгээр оны (1919 он) зуны сүүл сарын үес болмой... тэр хооронд Сюй Шүжанаас .... мөн оны намрын сүүл сард...цэргийг авч Хүрээнд орж ирээд Монголын засгийн эрхийг барих ерөнхий сайд Бадамдорж нар лугаа уулзаж автономит засгийн газрыг устгахаар төлөөвлөн хэлэлцэж буй чимээг сонсов.

Н.Магсаржав. “Монгол Улсын шинэ түүх” бүтээлээс.

Сюй Шүжан Монголын автономийг устгах талаар эрс хатуу байр суурьтай байв. Түүний тулган шаардсанаар Г.Бадамдорж 1919 оны 10-р сарын сүүлээр автономит эрхээсээ татгалзах асуудлыг Дээд, Доод хурлаар хэлэлцүүлэв. Дээд хуралд зөвшөөрөх санал давамгайлж, Доод хурал эсэргүүцэв. Энэ үест Богд хаан, Жалхан хутагт тэргүүтэй төлөөлөгчдийг Бээжинд илгээж, Хятадын ерөнхийлөгчөөс Монголын автономийг устгахгүй байхыг хүсжээ. Гэвч 11-р сарын сүүлээр Сюй Шүжан Богд хаан тэргүүтнийг цэргийн хүчээр айлган сүрдүүлсээр Монголын автономийг цуцлахыг зөвшөөрүүлэв. Хятадын ерөнхийлөгч 1919 оны 11-р сарын 22-нд Монголын автономийг цуцлах зарлиг гаргажээ. 1920 оны 1-р сарын 2-нд Сюй Шүжан Монголын автономит засгийг халсныг зарлан сүр бадруулсан тусгай ёслол үйлдсэн юм. Тийнхүү Монгол Улс тусгаар тогтолоо алдаж, Хятадын цэргийн дэглэм тогтов.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС СЭРГЭН МАНДСАН НЬ (1911-1924)

- 1. Сурвалж-1-ийн үзэл санаа, мөн чанарыг тайлбарлана уу? Яагаад ийм заалт оруулах болов?
- 2. Сурвалж-2-“Монтевидеогийн конвенцii”-ийн засалтыг өмнөх сэдвүүдэд өгсөн баримт мэдээлэл, бүдүүч, газрын зураг, дотоод, гадаад бодлого, ўл ажиллагаа зэрэгтэй уялдуулан холбож, 1911-1919 онд Монгол Улс тусгаар тогтносон улсын шинжтэй оршин байсан эсэхийг номтолно уу.
- 3. Сурвалж-3, 4-ийг шинжлэн судлаад дараах асуултуудад хариулна уу.
  - Сурвалж-3-т өгүүлснээр Чэнь И Засгийн газартай Монголын эрх баригчид зээлээ барагдуулж, Хятадын засгийн газраас цалин, тэтгэмж авахын тулд автономит эрхээсээ татгалзахыг хүссэн гэж илтгэжээ. Та түүний илтгэлтэй хэр санал нийлэх вэ?
  - Монголын эрх баригчид автономит эрхээсээ татгалзсан шалтгааныг мэдэхэд Сурвалж-4 яагаад хэрэгтэй вэ?
  - Чэнь И, Хятадын засгийн газар Монголын автономийг устгалгүй тээнэгэлзэх аваас энэ боломжийг ўүрд алдаж магадгүй хэмээн яаран сануулсан. Тэр яагаад энэ сануулгыг Засгийн газартай өгөв?
- 4. Шалтгаан, үр дагаврыг тодорхойлно уу.
  - 1919 оны сүүлээр Монголын автономит эрхийг яагаад устгасан бэ? Үүнд холбогдох шалтгаануудыг жагсаан бичнэ үү.
  - Таны бичсэн шалтгаануудаас Монголын автономит эрхийг устгахад нөлөөлсөн хамгийн гол шалтгаан аль нь байсан бэ? Хариултаа тайлбарлаарай.
  - Өөрийн бичсэн шалтгаануудыг хооронд нь холбон, Монголын автономит эрхийг устгасан ўл явцыг бүдүүвчээр харуулна уу.

### 4. 1921 оны хувьсгалын ялалт, ач холбогдол

-  - Улс үндэсний язгуур эрх ашиг, эрх чөлөө, тусгаар тогтолын үнэ цэн юунд орших вэ?  
- 1921 оны хувьсгал хэрхэн өрнөв? Хувьсгалын үр дүн, ач холбогдол юу вэ?

1921 оны хувьсгал тохиолдлын чанартай, санамсаргүй өрнөсөн хэрэг явдал байсангүй. Түүнийг 1918-1920 онд Монголд өрнөсөн ўл явдлууд, тухайн үеийн дотоод, гадаад байдал нөхцөлдүүлсэн юм.

 **Сурвалж-1:** “...Санамсаргүй Олноо Өргөгдсөний 9-р он зуны цаг Хятадын Сюй Шүжан хэмээгч гурван этгээдийн гэрээ бичгийг шууд зөрчин...Богд хаан ба Засгийн газрыг цэргийн сүрээр айлган цоюж автономитыг устгахыг гүйн өргөх бичиг гаргаж өгтүгэй хэмээн албадан шахамдуулж эх бичгийг өөрсдөө зохион өгч тамга даруулан аваад засгийн газрыг устган монголчуудыг санааны дураар эзэрхэн дарлаж...ван гүн лам нар арав илүү хүнийг дараа удаа барин авч... эрүүдэн шүүх эзгрээр маш зовоож ... олон монголчуудыг хэтэрхийгээр дарлан зовоож тэсэхүйээ бэрх болсон...Богд хааныг барин авч, хураг лам нар хийгээд олон хошуу шавийн ван гүн түшмэл ардын хөрөнгө эд малыг цөлбөн талж авах, энгийн суусан эр эм, хөгшин няляхасыг учир үгүйээр занчин шархлааж, буудаж алах эзргийн гашуун зөвлөнг тоолж барахгүйд хүрсэн” Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны бичгээс, Олноо Өргөгдсөний 11-р он, цагаан сарын 18.

 - “Уут уут мөнгөөр улсаа худалдсан сайдуудаа. Хүүдий хүүдий мөнгөөр Хүрээгээ худалдсан ноёдуудаа” хэмээн тухайн үед ардууд шоглон хэллэлцэх болсон шалтгааны талаар оюун дүгнэлт хийгээрэй.

Бий болсон нөхцөл байдал эх орон, үндэс угсаа, шашин соёлоо гэх монгол хүн бүрийг бухимдуулж, тэмцлийн арга зам эрж сувэгчлэхэд хүргэв. 1918 оны дунд үеэс Нийслэл Хүрээнд “Зүүн Хүрээний” бүлэг, “Консулын дэнжийн” улмаар “Угсаатан хэргэмтний” гэх бүлгэм бий болжээ.

 **Сурвалж-2:** “...бидний эдгээр нөхөд өөрсдийн ашиг завшааныг эрмэлзэхгүй дан гагц харьят Монголын шашин үндэс ба олон түмэн ардыг гол усны гашуун зөвлөнгөөс гэтэлгэх, амар төвшинийг олгох замыг нээгдүүлэн соёрх хэмээх үг зохион, сүүгээр хадаат бичиж, Хүрээний Улаан сахиусны өмнө өргөж, зул хуж шатаан басхүү энэ тухай хэрэгт бидний бие няцалт буцалгүйээр зүтгэсүгсэй хэмээх тангарагийг тавьжээ.” (1920.1.5). МАХН-ын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд бүтээлзээс.(1928).

Эрх чөлөөгөө эргүүлэн олж авах тэмцэлд аль нэг гадаад улсаас дэмжлэг тусламж авах зайлшгүй шаардлага тулгарав. Угсаатан хэргэмтний бүлгэм АНУ,

 Коминтерн. Коммунист, ажилчны намуудыг нэгтгэн удирдаж чиглүүлэх, үзэл суртлаа түгээн дэлгэрүүлэх, хувьсгалт тэмцэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор 1919 онд байгуулсан олон улсын байгууллага.

Японтой холбоо тогтоохыг оролдож байжээ. Гэвч Зөвлөлт Орос улс (ЗОУ)-д хандахаас өөр боломж олдоогүй юм. ЗОУ, **Коминтерний** зүгээс ч Монголыг сонирхон, байдлыг сайтар ажиглан судалж байлаа.

1920 оны 6-р сарын сүүлээр Хүрээний ба Консулын бүлгэмийнхэн хамтран МАН хэмээх улс төрийн байгууллага байгуулж, ЗОУ-аас тусlamж хүсэхээр тогтжээ. Энэ үүргийг С.Данзан, Х.Чойбалсан, Д.Бодоо, Д.Чагдаржав, Д.Догсом, Д.Лосол, Д.Сүхбаатар нарын 7 хүнд даалгасан юм. Тэд 8-р сард Эрхүү хотноо хүрэлцэн очиж, Зөвлөлтийн талд санал хүсэлтээ уламжлан, хэд хэдэн удаа уулзалт хийжээ. ЗОУ-аас тусlamж авах хэрэг амар хялбар байсангүй. Нийслэл Хүрээнээс-Дээд Шивээ-Дээд Уд-Эрхүү-Омск-Москва хүртэл урт холын зам туулав.

 Хувьсгалчид “МАН” гэх модон тамга хэрэглэж байсны дээр хоорондоо харилцахдаа 400-аад угтэй нууц түлхүүр ашиглаж байжээ. Ж: “Малын үнэ мүү. Хээр морь эмгэгтэй. Бутковоос янчаан авах төлөвтэй. Георгийгээр хүргүүлнэ. Мөнгөний явдалд яар. Мөнгөний хариу даруй өг. Иван”. (Тайлал: Хятадын байдал муудаж байна. Сий Шүжаны харилцаа улам ширүүч байна. Тусlamжийн бичигт Богдоос тамга даруулж авах төлөвтэй. Догсомоор хүргүүлнэ. Тусlamж авах явдлыг яараачил, тусlamж авч буй тухай даруй мэдээд. Д.Бодоо). Үндэсний Төв Архиевын баримтаас.

 **Сурвалж-3:** “Хамгийн гол нь Монголын автономийг сэргээн тогтооход туслалцаа үзүүлээч гэдгийг л Монголын төлөөлөгчид ЗОУ-аас хүсэж байгаа юм. Энэхүү тусlamжийг дор дурдсан хэлбэрээр хэрэгжүүлж болох юм. 1.Олон улсын хэмжээнд дипломатын талаар дэмжлэг үзүүлэх. 2. Зөвсээр туслах. 3. Техник хэрэгсэл болон цэргийн сургаач нараар туслах. 4. Улсын зээл олгох”. ОК(б)Н-ын Сибирийн төвчооны уулзалтын тэмдэглэлээс.(1920.8.21. Эрхүү).

ЗОУ-аас тусlamж дэмжлэг авах асуудал шийдэгдэж байх үед буюу 1920 оны 10-р сарын 2-нд барон Унгерний захирсан “Азийн морин дивиз”-ийн 800-аад цэрэг Онон голын сав, Гилбэр харуулын нутгаар Монголын хил рүү цөмрөн орж иржээ. Унгерн “Богд гэгээнийг хаан ширээнд нь залж, автономит засгийг сэргээн босгоно”, “Монголчуудыг хятадаас авран чөлөөлнө”, “Их Монгол улсыг байгуулна” гэх зэргээр мэдэгдэж, монголчуудыг талдаа татаж, цэрэгтээ элсүүлж байв. Монголчууд ч тэдний хүчийг ашиглан Хятадын гар савраас ангижрахыг хүсч байлаа.

Барон Унгерн 1921 оны 2-р сарын 4-нд Нийслэл Хүрээг эзлэн авчээ. Хүрээг чөлөөлөхөд олон зуун монгол цэрэг оролцжээ. Богд гэгээнийг хаан ширээнд эргүүлэн залж, Жалханз хутагт Дамдинбазарын тэргүүлсэн Засгийн газар байгуулагдав. Богд хаан барон Унгернд “үе улиран хан зэрэг, дархан чин вангийн хэргэм, улсын их баатар жанжин” цол шагнасан байна.

1921 оны эхнээс Ардын намынхан тэмцлээ улам идэвхжүүлэв. Журамт цэрэг элсүүлэх, бодлого, зорилго тодорхойлох, зохион байгуулалтаа бэхжүүлэх, ухуулга, таниулга хийх арга хэмжээ авч байлаа. 1921 оны 2-р сард Д.Сүхбаатарыг цэргийн жанжнаар томилжээ. 1921 оны 3-р сарын 1-3-нд Дээд Шивээ (Троицкосавск)-д болсон зөвлөлгөөнөөр “Эрмэлзэх авран зүйл”-ийг баталж, МАН-ын Төв Хороо (TX)-г 4 хүнтэй сонгожээ. Намын TX-ны даргаар С.Данзан, гишүүдэд Ц.Дамбадож, Д.Лосол, Коминтерний 1 төлөөлөл байхаар шийдвэрлэжээ.

3-р сарын эх гэхэд цэргийн тоо 400 гаруйд хүрч, дөрвөн хороо болгон эмхлэн байгуулав. Анхны хороон даргаар Б.Пунцаг, О.Цэрэндорж, Ц.Хасбаатар, Ч.Базарсад нарыг томилжээ. Монголын хувьсгалчид юуны өмнө Хиагтыг гамин цэргээс чөлөөлөхийг зорив.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС СЭРГЭН МАНДСАН НЬ (1911-1924)

Хиагтад Хятадын 25-р морьт дивизийн штаб, 500 хүнтэй морьт хороо, 40 хүнтэй хотын комендант, 1400 орчим хүнтэй 4 морьт хороо, нийтдээ 2000 шахам цэрэг 12 пулемёт, 7 их буу бүхий цэргийн хүч байрлаж байжээ.

1921 оны 3-р сарын 13-нд эрх чөлөөний тэмцлийг удирдан зохион байгуулах Ардын түр засгийн газар (АТЗГ)-ыг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. АТЗГ байгуулагдсанаар Монгол хоёр Засгийн газартай болов.

1921 оны 3-р сарын 17-нд гамин цэргийн эрх баригчдад тулган шаардах бичиг өгчээ. Хятадын тал хариу өгөөгүй тул Хиагтыг 3 талаас нь довтлон байлдаж, 3-р сарын 18-ны шөнө ялалтаар өндөрлөв.

Гамин цэргийг устгасны дараа АТЗГ, МАН-ын өмнө цагаантны эсрэг тэмцэх, улс орноо бүрэн чөлөөлөх зорилт тулгарав. ЗОУ-аас цэрэг зэвсгийн тусlamж хүсч, улаан цэргийн Аялан байлдах корпус цагаантантай тэмцэхээр Монголд орж иржээ.

**Сурвалж-4:** “1-д, цагаантан Монголд бүгж улмаар ЗОУ-д шинэ аюул занал учруулж болох; 2-т, цагаантан монголчуудад нөлөөгөө дэлэрүүлж, эндээс шинэ цэргийн хүч бүрэлдэхээд нь саад учруулах үүднээс; 3-т, Японы узуулэх нөлөөг зогсоох; 4-т, Хятадын эзэнэлийг устгах, 5-д (эхэд хоосон орхисон) зэргийг харгалзан б-д, Дорно дахины ард түмний секцийн тэргүүлэгчид Зөвлөлтийн цэргийг Монголын нутагт нэн даруй оруулах нь чухал гэж санал нэгтэй тогтгэв.”

ОК(б)Н-ын Сибирийн Төвчооны яялтай хуралдааны протоколоос. (1921. 06.16. Эрхүү).

1921 оны 6-р сарын 28-нд АТЗГ, МАН-ын ТХ-ны хамтарсан хурлаас Нийслэл Хүрээг чөлөөлөх шийдвэр гаргаж, байлдааны төлөвлөгөөг батлав. Цэргийн хамтарсан хүчин 6-р сарын 30-нд Алтанбулагаас хөдөлж, түрүүч нь 7-р сарын 6-нд Нийслэл Хүрээнд оржээ. Цэргийн гол хүч 7-р сарын 8-ны өглөө Нийслэл Хүрээнд ирэв. 7-р сарын 10-ны өдөр, морин цагт засгийн эрх шилжүүлэх ёслол болж, Ардын Засгийн Газар (АЗГ)-ыг байгуулав. 7-р сарын 11-нд Богдыг хэмжээт эрхт хаанаар өргөмжилжээ. Оны цолыг хэвээр хэрэглэж, “Ардын эрхтэй хэмжээт цаазат улсын засгийг явуулах” болсныг олон түмэнд зарлан тунхаглав. Мөн өдөр цэрэг, ардын цуглаан, хувьсгалын ялалтын баяр наадам болжээ.

1921 оны хувьсгал нь шинж чанарын хувьд үндэсний ардчилсан хувьсгал байлаа. 1921 оны хувьсгалын үр дүнд Монгол Улс тусгаар тогтнолоо дахин олж, түүхийн нэгэн шинэ үе эхэлжээ.

1. 1920 оны 8-р сард ЗОУ-ын тал “тусламж аваад ямар засаг байгуулах, ямар аргаар тэмцэх зэргийг тусгасан бичгийг МАН-ын нэрийн өмнөөс бичиж өгөх”-ийг шаардсан нь Монголын төлөөлөгчдийн дунд хүрц маргаан үүсгэсэн юм. Үүний учир шалтгааныг бусад мэдээлэлтэй холбон шинжилж дүгнэх тодорхойлно уу.
2. Сурвалж баримт, мэдээлэлт тулгуурлан хүснэгтийн дагуу шинжлэн судлаад, хариултаа нотлон тайлбарлаарай.

Хувьсгалын шалтгаан, хүчин зүйлс		Хувьсгалын гол удирдагчид	Хувьсгалын үр дүн, ач холбогдол
Дотоод	Гадаад		

3. ЗОУ-ын зүгээс, “Монголын ард олны үндэсний хөдөлгөөнийг үзэл суртлын талаар эзэмдэн авч... чиглүүлэх” заавар (Монгол-Түвэдийн хэлтсийн үйл ажиллагааны заавраас) өгч байсан баримтыг задлан шинжилж, хийсэн дүгнэлтэй танилцуулна уу.
4. Монгол болон ЗОУ-ын хүсэл зорилго, ашиг сонирхлын талаар ямар оюун дүгнэлт хийж болох вэ?

## 5. Хэмжээт цаазат хаант Монгол Улс (1921-1924)



- Хэмжээт цаазат хаант Монгол Улсын шинж онцлог юу байв?
- Монгол Улсын бүрэн эрх, тусгаар тогтнол бүрэн баталгаажиж чадсан болов уу?
- Монголын нийгэм, эдийн засаг, соёлд ямар өөрчлөлт гарав?

1921 оны хувьсгалын ялалтаар Монгол Улс тусгаар тогтнолоо эргүүлэн олж, хөгжил дэвшлийн зүг улс орноо хөтлөн жолоодох түүхэн боломж дахин нээгдэв. Монгол Улс үндэсний ардчилсан өөрчлөлтийн бодлого явуулахыг чухалчилж байв.

Үүний тулд юуны өмнө **тусгаар тогтнолоо бататгах, дотоод, гадаад байдлаа бэхжүүлэх** шаардлага тулгарав.

АЗГ цагаан цэргээс улс орноо бүрэн чөлөөлөх тэмцлийг эн тэргүүнд явуулав. 1921 оны 8-р сард улс орныхоо төв хэсгийг, 11-р сар хүртэл зүүн хязгаарыг, 1922 оны эх гэхэд баруун хязгаарыг тус тус цагаантнаас бүрэн чөлөөлсөн юм. 1921 оны намар Хасбаатар, Дамбадорж нарын удирдсан цэргүүд Толбо нуурт 42 хоног бүслэгдэн байлдсан нь тэр үеийн хамгийн хүнд бэрх тулалдаан байлаа.

1921 оны 9-р сарын 10-14-нд Монгол ардын засгийн газраас дэлхийн олон улсад хандан хэмжээт цаазат хаант Монгол Улс байгуулагдсаныг зарлан мэдэгдэж, найрамдалт харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн юм. ДИУ мөн л Монголын тусгаар тогтнолыг эрс эсэргүүцэж, өөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг гэх үзлийг баримталсаар байв.

Харин ЗОУ Монголын хүсэлтийг хүлээн авсан хэдий ч бүрэн утгаар дипломат харилцаа тогтоож чадахгүй байв. С.Данзан тэргүүтэй Монголын төлөөлөгчид Москвад айлчилж, 1921 оны 11-р сарын 5-нд найрамдлын гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр хоёр тал Засгийн газруудаа харилцан хүлээн зөвшөөрч, бүрэн эрхт төлөөлөгч суулгах, улс тэр эдийн засгийн тааламжтай харилцаа тогтоохоор болов. Хятадын зүгээс цэрэг-улс төрийн дарамт шахалт үзүүлж, тусгаар тогтнолд заналхийлж байсан нөхцөлд Монгол улс ЗОУ-ыг түшиглэсэн нь чухал алхам байлаа.

Монгол-Хятадын харилцаанд ЗОУ зуучийн үүрэг гүйцэтгэж, хэрэг дээрээ Монголоос Хятадыг шахаж, өөрийн нөлөөний бус болгох бодлогыг далдуур туштай явуулж байлаа. Тийм нөхцөлд Монгол Улс үнэндээ ЗХУ-ын халхавч нөмөр дор, түүний дагуул холбоотон байдалтай оршиж, тусгаар тогтнол, бие даасан байдлаа хадгалж үлдэх арга зам эрэлхийлэхэд хүрэв.

**Сурвалж-1:** “БНМАУ нь Хятадын суверенитетийн дор автоном байх хэлбэрийг бид тунхаглах боловч хэрэг дээрээ улс төр, эдийн засгийн байгууллын хувьд Монголыг Зөвлөлт мэдэгжүүлэхэд ойртуулахын тулд бид ажиллана”. ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичеринээс Монгол дахь бүрэн эрхт төлөөлөгч Никифоровт өгсөн заавраас.

1924 оны Зөвлөлт, Хятадын гэрээнд Монголыг Хятадын нэг хэсэг хэмээн заасан нь манай улсын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх боломжийг олон жил хаасан юм.

**Сурвалж-2:** “Зөвлөлт Засгийн газар Гадаад Монгол нь Дундад Иргэн Улсын нэг хэсэг мөн болохыг хүлээн зөвшөөрөх бөгөөд үз нутаг дэвсгэр дэх Хятадын бүрэн эрхийг хүндэтгэнэ”. Зөвлөлт-Хятадын 15 зүйлт гэрээ бичгийн 5-р зүйлээс. (1924.5.31).

Монголын төр улс орныхоо **дотоод байдлыг засан тохинуулахад** хүч анхаарал хандуулав. 1921 оны хувьсгалд Монголын нийгмийн бүхий л давхаргын төлөөлөл оролцож, улмаар үндэсний эв нэгдлийг эрхэмлэсэн эвслийн шинжтэй

засаг байгуулсан билээ. Энэ сацуу улс төрийн тогтолцоогоо боловсронгуй болгох, “сонгож байгуулдаг засаг” буюу Бүгд найрамдах засаг тогтоох, хуучин нийгмийн харилцааг халж өөрчлөх бодлого хэрэгжих эхэлсэн юм. Ерөнхий сайд Д.Бодоо Монголд **хэмжээт цаазат (Үндсэн хуулт) хаант төр** илүү тохиromжтой гэж үзэж байлаа. Тиймээс тэрээр ардын эрхт хэмжээт цаазат хаант төрийн тогтолцоог хуульчлан баталгаажуулахыг зорьж байв.

1921 оны намар Улсын Их Хурал хуралдах хүртэл ажиллах олны төлөөллийн байгууллага болох **Улсын түр цагийн хурал** (УТЦХ)-ыг байгуулав. Энэ үеийн улс төрийн тогтолцооны нэг хэсэг болох УТЦХ нь бодлого, шийдвэр боловсруулах, зөвлөх эрхтэй өвөрмөц байгууллага байлаа.

УИХ хуралдаж, Үндсэн хууль батлах хүртэл Богд хаан ба АЗГ-ын хоорондын харилцааг зохицуулах шаардлага гарсан тул 1921 оны 11-р сарын 1-нд **“Тангарагийн гэрээ”**-г батлан мөрдүүлжээ. Түүнийг “Хэмжээт засагт ард улсуудын үндсэн хуулиудын гол утгыг баримтлан тогтоосон” юм. Тиймээс “Тангарагийн гэрээ” нь хэрэг дээрээ Үндсэн хуулийн үүрэг гүйцэтгэж байсан гэж хэлж болно. 1921 оны сүүлээс Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажил эхэлж, 1922 оны 5-р сарын 29-нд тусгай комисс байгуулжээ. Энэ ажил багагүй саад, бэрхшээлтэй тулгарч, 1924 он хүртэл үргэлжилсэн билээ.

АЗГ орон нутагт өөрийн бүрэн эрхт төлөөний түшмэдийг томилон суулгаж, улмаар орон нутгийн засаг захиргааг ардчилсан үндсэн дээр өөрчлөх бодлого явуулж эхлэв. 1923 онд “Засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм”, “Монгол Улсын нутаг захиргааны дүрэм”, “Их шавийн захиргааны дүрэм”, 1924 онд “Ховдын харьят газрын захиргааны дүрэм” зэргийг батлан гаргажээ.

Нийгэм-эдийн засгийн хүрээнд хийх ардчилсан өөрчлөлтийн хамгийн гол зорилт нь хуучин нийгмийн харилцааг халах явдал байв. АЗГ-аас 1922 оны 1-р сарын 25-нд **эзэн, хамжлагын харилцааг халах** түүхэн шийдвэр гаргаж, 5-р сарын 5-нд ноёд, тайж нарын хамжлага захирах эрхийн тамгыг хураан авчээ. Ард олныг нийгмийн хүлээс, ноёдын мэдлээс салгаж чөлөөлсөн нь маш чухал ардчилсан өөрчлөлт байв.

**Төрөөс аж ахуй, эдийн засгаа сэргээн хөгжүүлэх**, ард олны аж амьдралыг дээшлүүлэх, улс орны үндсэн баялаг болох мал сүргээ өсгөн үргжүүлэх явдалд эн тэргүүнд анхаарав. Улсын сан хөмрөгийг арвижуулахад чиглэгдсэн тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байлаа. Өртөө, улааг цэгцэлж, гадаадын худалдаачдад төлөх өрийг хүчингүй болгон, алба татварын бодлогыг өөрчилж, харийнхны мэдэлд байсан үйлдвэр, уурхайн газруудыг улсын болгох арга хэмжээ авчээ. Шуудан холбооны газар, Монголын харилцан туслалцах хоршоо байгуулж, санхүү, банкны тогтолцоог бүрдүүлэн, үндэсний мэнгэн тэмдэгттэй болох алхам хийв.

1923 онд үндэсний эдийн засгаа бүх талаар хөгжүүлэх үзэл баримтлал болох “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх баримт бичгийг батлан гаргав.

**Сурвалж-3:** “...Орос, Хятад, Рибин (Япон), Америк, Англи, Герман зэргийн олон их, бага улс  
дотроос зарим нь эзэрхэг шунахай бөгөөд бага буурайг дарламтгай ба залгимтгай, зарим нь хурц  
эрдэмтэй, зарим нь бүдүүлэг байх мэт чанар дүрс адилгүй учир, зүй нь харилцан худалдаа ашиг,  
эрдэм соёлын тухай гэрээ болзоо тогтоон нэвтрэлцэхэд хүрвэл эрхбиш хэдэн давхар эргэцүүлэн  
хянаж, тогтоовол зохино. ...шилэн сонгоход хүрвэл аль ч талаар Герман, Орос, Америк гэх мэтээр  
дэс дараалан орно за...”

“Эдийн засгийн үндсэн бодлого”-ын 17-р зүйлээс.

Монголын төр, улс орны дэвшил хөгжил **соёл боловсролыг эрхэмлэх** явдалтай салшгүй холбоотой хэмээн үзэж байв. 1921 оны 11-р сард 3 жилийн бага сургууль дахин нээж хичээллүүлжээ. Бага, дунд сургуулийн танхимиын дүрэм батлан гаргаж, Дотоод яаманд “Сургуулийн хэлтэс” байгуулан сургуулийн хэргийг хариуцуулав.

**Сурвалж-4:** Бага сургуулийг 3 жил, дунд сургуулийг 5 жилийн хугацаатай тогтоож, бага сургуульд 8-13 насны хүүхэд, дунд сургуульд бага сургуулиа төгссөн 10-16 насны хүүхдүүдийг суралцуулна. Мөн тус орны тухайн байдлыг харгалзан монгол бичиг төсөөлөх 14-18 насны хүүхдийг дунд сургуульд бас хамруулан сурган. "Бага, дунд сургуулийн танхимын дүрэм"-ээс. (1922).

1922 оноос багш бэлтгэж эхлэн, 1923 онд Багшийн сургууль байгуулжээ. Мөн 1922 оноос цэрэг, улс төрийн боловсон хүчинээ ЗОУ-д илгээн сургах болов.

Сурах бичиг гаргах, түгээхэд анхаарч "Цаасан шувуу", "Оюунтүлхүүр", С.Жамъяны зохиосон "Монгол үсгийн цагаан толгой", "Урт өдрийн улийт үгийн бичиг" гэх зэргийг хэвлэн, хэрэглэж байлаа.

**Сурвалж-5:** "...Үүнээс дээш тоочсон олон зүйлүүдийг бүрэн бүтэн сайнаар, ёсоор явуулсугай хэмээхүл ард түмэн даяараа ерийн эрдэмд боловсрох хэрэгтэй. Үрьд, эдүгээ аль цагт, орон газар хаана ч атугай, эрдмээр илүү нь эрхбиш түрүүлдэг учиртайг дэлхий дээрх олон улс ухамсарлан мэдэж, эрдэмд боловсруулахыг засгийн бодлозвын манлай болгожээ. Улс эрдэм мэжэс болбоос ажил үйлдвэр нь бүдүүлэг, эд хөрөнгө ба сүр хүчин буурай, хэрэв эрдэм дэлгэрсэн болбоос элдэв зүйлийн боловсон арга хэрэглэж, эд хөрөнгө зузаан, сүр хүчин их болно... Учир тиийм тул эдийн засгийг үүрд бат нот, арвин зузаан болгоех хэмээвээс ард түмнийг эрхбиш ерийн үсэг бичиг, утга уянга ба тусгай ашиг тус бухий эрдмүүдэд сургахыг үрьдал болговол зохино".

"Эдийн засгийн үндсэн бодлого"-ын 18-р зүйлээс.

Хүн амын эрүүлийг хамгаалах, өвчин эмгэгээс сэргийлэх, эмчлэх, уламжлалт эмчилгээний зэрэгцээ орчин үеийн эмнэлэг байгуулах арга хэмжээ авч байв.

1921 оны 11-р сарын сүүлээр орчин цагийн шинжлэх ухааны анхны байгууллага болох "Судар бичгийн хүрээлэн" байгуулагдав. Тус хүрээлэн ховор чухал ном судар цуглуулах, судлах, орчуулах, судалгааны ажил явуулах, түүх, соёлын дурсгалыг хамгаалах ажил хийж байлаа. Гадаадын улс орнууд, эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллах болж, 1922 оноос Р.Ч.Эндрюсийн экспедиц, 1923 оноос П.К.Козловын шинжилгээний анги Монголд ажиллаж гайхамшигт нээлтүүд хийжээ.



1. Сурвалж-1, 2, 3-т тулгуурлан Орос, Монголын байр суурийг тодорхойлно уу?
2. Сурвалж-4, 5-ын мэдээнд тулгуурлан боловсролын салбарыг гарсан өөрчлөлтүүдийг жагсаан бичнэ уу.
3. Боловсролын үнэ цэн, ач холбогдлыг үнэлж, зэрэмбэлнэ уу.

### 6. Монгол Улсын хөгжлийн талаарх үзэл баримтлалууд



- Монголын эрх баригчид улс орныхоо цаашдын хөгжлийн талаар ямар нийтлэг болон ялгаатай чиг шугам баримталж байсан бэ?
- Голлох зүтгэлтнүүдийн үзэл баримтлалд ямар ялгаа байв?
- Монгол Улс хөгжлийн чиг шугамаа сонгоход гадаад хүчин зүйлс яагаад нөлөөлөв?

1921 оны хувьсталийн өрнөл үеэс хөндөгдөн яригдаж ирсэн нэг гол сэдэв бол Монгол Улсын цаашдын хөгжлийн чиг шугамын асуудал байсан юм. Уг хувьстайл ноёд язгууртууд, бичиг, цэргийн түшмэд, жижиг хөрөнгөтнүүд, лам нар, энгийн ардууд зэрэг нийгмийн бүх давхаргын төлөөлөл оролцсон тул улс орны цаашдын хөгжлийн талаар янз бүрийн үзэл бодол зэрэгцэн оршиж байв. Тэдний нэг хэсэг нь уламжлалт төр ёс, хаант засгаа хэвээр хадгалан хөгжих ёстой гэсэн байр суурьтай байлаа. Харин нөгөө хэсэг нь олон улсын чиг хандлагыг баримтлан ардчилсан төрийн байгуулал тогтоон хөгжих нь зөв гэж үзэж байжээ. Тэрчлэн шинэ тулгар Монгол Улсын хувь заяа, цаашдын хөгжлийн чиг шугам ямар байх нь ЗОУ, Коминтерний анхаарлын төвд цаг ямагт байсан юм. Зарим асуудлаар тухайн үеийн Монголын удирдагчид ч харилцан адилгүй үзэл бодол илэрхийлж байв.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС СЭРГЭН МАНДСАН НЬ (1911-1924)

Догсомын Бодоо (1885-1922) Их шавийн харьят, лам явсан. Шинэтгэгч үзэлтэн, соён гэгээрүүлэгч, багш, сэргүүлч, нийтлэлч. Шанзуудын яаманд бичээц, "Шинэ толь", "Нийслэл Хүрээний сонин бичиг"-ийн идэвхтэй ажилтан, Хүрээн дэх Орос сургуульд монгол хэл бичгийн багшиар ажиллаж байв. Консулын дэنجийн бүлээмийг үндэслэгч, 1921 оны хувьсгалын гол удирдагчдын нэг. 1920 оны зун ЗОУ явсан 7 төлөөлөгчийн нэг. Хувьсгалын зарим баримт бичгийн эх зохиогч. 1921 оны 3-р сараас АТЗГ-ын Гадаад хэрэг эрхлэсэн түшмэл, 4-р сараас АТЗГ-ын дарга, 7-р сараас Ерөнхий сайд бөгөөд Гадаад яамны тэргүүн сайдын тус ажиллаж байв. 1922 онд хилсээр хэлмэгдүүлж буудан хороосон ба 1997 онд цагаатгаж, нэр төрийг нь сэргээжээ.



**Сурвалж-1:** "Бидний Ардын намын хүн нар Орос улсын ... цэрэг хүчийг хэрэглэн автономитыг олоод, Хутагтыг хэмжээтэй эрхтэй эзэнд өргөх, ...нэгэнт бусдын гарын өөрийн дотоод эрхийг олохуй лугаа сацуу, гадаадын элдэв ёс ба ялангуяа ардын эрх тусыг үйлдэх ёс суртлыг нийтлэх арга замыг хир чадах чинээгэр явуулж, баахан засрах төлөөийг олж, мэдэл нээгдэх байдлыг үзмээц нэг хоёр жилийн дотор дахин хувьсаж, цөөн эрхтнийг эвдэвлэл дотоодод эвдрэл бага, гадаадад шүүмжлэлгүй хэрэг бүтэх ... болно".

МАН-ын төлөөлөгчдөөс ОКБН-ын ТХ-ны Сибирийн товчоонд өргөсөн бичгээс. (1920.8.29).

Д.Бодоо, ардын эрхт, хэмжээт цаазат засаг тухайн цаг үед нэг хэсэгтээ тохиромжтой, өөрийн өвөрмөц онцлогт тохирсон замыг сонгон, дарлал мөлжлэггүй, ард түмнээ адил тэгш үзэн, шашнаа дэлгэрүүлэн, эв найрамдлыг эрхэмлэн, боловсрон хөгжих ёстой гэж үзэж байлаа.

**Сурвалж-2:** "Эдүгээс манай Монгол Улс нь их бүдүүлэг бөгөөд боловсорсон олон улсын адил их, бага улаан үзэлт улс огт тохиорхгүй, хурлын эрхт БНУ бас хэцүү, хуучин ёсоор хэмжээгүй эрхт эзэнт улс байгуулбал... улс төрийн эвдрэл үүсгэх ба дээд, доод 2 анги болж үлэмжхэн хувьсгал гаран зөвлөн зүйдүүр эдэлсээр эзэст нь урьдын автономитын эвдрэлт лүзээ дахин учрах болохуул бидний ядуу ард яахин тэсвэрлэж чадах аж. Иймийн учир хэмжээт эрхт эзэнт улс байгуулсан буюу. Энэхүү хэмжээт хэмээсэн үг нь төрийн хэргийг сайд хийгээд яам, олны төлөөлөгчдийн хурлаар юу гэж тогтосоныг эзэн эвдэхгүй, шашин багшийн хэрэгт төр албан газраас хамаарахгүй ...Хэмжээт эзэнт улсыг бат лут хэмээн баримтлахад Англи улсыг өмнөх толь болгож болно"

Цорж мэргэн, Зуугийн хувилгаан наарт Ерөнхий сайд Бодоогийн бичсэн захидаас.

Солийн Данзан (1885-1924) Сайн ноён аймгийн Сүжигт бэйсийн хошууны харьят. Сангийн яаманд түшмэлээр ажиллаж байсан. Хүрээний нууц бүлээмийг үндэслэгч, 1921 оны хувьсгалын гол удирдагчдын нэг. 1920 оны зун ЗОУ явсан 7 төлөөлөгчийн нэг, МАН-ын анхны дарга. 1921 оны 3-р сараас АТЗГ-ын эрхэлсэн түшмэлээр ажилласан. 1921 оны 7-р сараас Монгол Улсын Сангийн яамны сайдар, 1923 оны хавраас Бух цэргийн жанжин, Ерөнхий сайдын жинхэнэ орлогчоор ажиллаж байв. 1921 оны 11-р сарын 5-нд ЗОУ-тай гэрээ байгуулсан Монголын төлөөлөгчдийн тэргүүн. 1924 оны 8-р сард хилсээр хэлмэгдүүлэн буудан хороож, 1992 онд цагаатгаж, нэр төрийг нь сэргээжээ.



С.Данзангийн хувьд, Монголд Бүгд найрамдах засаг тогтоох, хүн төрөлхтний түүлж ирсэн жам ёсны дагуу, шат дараалан хөгжих ёстой гэж үзэж байв.

**Сурвалж-3:** "Юун хэмээвээс өртөнцийн хүн төрөлхтөнд бүгдээр найрамдах буюу зөвлөлдөх мэцсийн олон зэрэг дэс, байр байх бөгөөд үлгэрлэвээс, авирах гишгүүрт нэгээс үүсгэн дэвших ба усанд гүехэнээс гүнд орохоор одохын утга адил буй. Үнийн зэрэг дэс солигдвоос үл болох....нүүдэл, суурьшсан улс аль нь боловч журам сурталд түшиглэн амьдардаг. ...хүчирхээ буурайн ёс суртлыг нэвтрэгсэг түүнээс уламжлан өөрийнхөө ёс занишил лугаа аль зохицдож нийлэлцсэнэйг сонгон авч журамлахын тулд, хэн этгээд харилцан боловсрон мэдэж тэмцэлгүйээр засах шинэгээхийн ёсиг явуулжад....Хэмжээт эрхт засагийг сайжруулан явуулахад сэцэн сэргэлэнг сонгон сургаж, дэлхий дахини ёсон сурталд нэвтэрч, өөрсдөө тэмцэлгүй, зүйгээр засаж чадах хуртлээ эрдэмтнийг сонгох, хуучин шинийн төв дундыг барьж түр явуулах" шаардлагатай гэж С.Данзан үзэж байжээ. Ө.Бадрах. Намаас баруун бөөрөнхийчүүд лүзээ тэмцэн амжилттай их тэмцлийн туршлага номоос.(1932).

Уламжлал, шинэчлэлийг хослуулах, ардчилсан чиг шугамыг баримтлан хөгжих ёстой гэж үзэгдсийн бас нэг төлөөлөл нь Д.Сүхбаатар байлаа.

 Дамдины Сүхбаатар (1893-1923) Их Хүрээний Амгаланбаатарт төрсөн. 1912 онд цэргийн алба хааж, бага даргын сургууль төгсөн, пулемёт салааны даргаар ажиллаж байв. 1918 оноос Хэвлэлийн хороонд үсэг өрөгчөөр ажилласан. Энэ уедээ Хүрээний нууц бүлгэмдэл элсчээ. 1920 оны зүн 30У явсан 7 төлөөлөгчийн нэг. Монгол Улсын тэр, цэргийн зүтгэлтэн, улсын баатар, ардын цэргийг үндэслэн байгуулагч. Хиагтыг чөлөөлөх байлдааныг биечлэн удирдсан, 1921 оны хувьсгалын гол удирдагчын нэг. 1921 оны 7-р сараас Монгол Улсын Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжнаар ажиллаж байв. 1921 оны намар 30У-д очсон төлөөлөгчийн бүрэлдэхүүнд оролцжээ. 1923 оны 2-р сард нас барсан.



**Сурвалж-4:** “Богд хаанаа эрдэнийн сууринаа хэвээр залж өргөмжлөн, элдэв хэргийг явуулж бүхий нь бурхны шашнаа хүндэтгэж, ард түмнийг амгалан түйл дор хүргүүлэн, тэгш журамт, баян хүчирхэг улс болохыг гол болгосон хэрэг болой. ...иймийн тул, түшмэл цэргүүд бүгдээр эртний ёс суртал, эдүгээх шинэ засгийн бодлого, зорилтыг гүнээ ухамсарлан мэдэж, гажуугаас зайлж, шударгад дэвжик, мууг гээж, сайндуулж ултич, өөр өөрийн хүлээсэн албан хэрэгт үнэн санаа, чин зорилгоор хичээнгүйэн зүтгэгтүн”.

Жанжин Д. Сүхбаатарын хуулан сэнхруулсэн бичгээс. (1922).

Монголын улс төрийн зүтгэлтнүүд үндэсний өвөрмөц онцлог, уламжлалаа харгалзахын зэрэгцээ дэвшилтэт ардчилсан төрийн хэлбэр болох Бүгд Найрамдах байгуулал тогтоох, бүх монгол овогтоо нэгтгэх, тусгаар тогтнолоо хамгаалан бэхжүүлэх талаар үзэл санаа нэгтэй байсан юм. Харин тэдний хороонд яс хаях, хутган үймүүлэх, хагаралдуулах явдал гарч, зарим асуудлаар санал зөрөлдөж байсан тал бий.

Нэгөөтэйгүүр энэ үед Коминтерн, ЗОУ-ын зүгээс Монгол Улсыг социалист чиг шугамаар хөгжүүлэх бодлого, үзэл баримтлалыг хүчтэй сөргүүлэн тавьж байсан билээ. Үүнд тухайн үед Монголд ажиллаж байсан Элбэгдорж Ринчино, Т.Р.Рыскулов нарын төлөөлөгч, сургач нар гол үүрэг гүйцэтгэжээ. Тэд зорилгодоо хүрэхийн тулд Монголын удирдагчдын доторх үзэл бодол, байр суурийн зөрөлдөөнийг өлгөн авч, нэгийг нөгөөгийн эсрэг түлхэн ашиглаж замаа цэвэрлэх, байр сууриа бэхжүүлэх алхмуудыг дэс дараатай хийж байв. Д.Бодоо, С.Данзан тэргүүтэй цөөнгүй зүтгэлтнүүд улс төрийн тавцангаас зайлуулагдсан нь үүний тодорхой илрэл юм.

**Сурвалж-5:** “МАН-ын эцсийн зорилт нь эв хамтын ёс мөн бөгөөд нам капитал хөрөнгөтний хөгжлийн шатыг алгасах зорилгод хүрэхээр урагшаа давшиin явж байна. Нам энэ зорилтыг тавьж, явуулах арга замыг олж тогтоохдоо чухамхүү ямар анги, хучнийг шүтэн түшиглэх тухай зүйлийг тавидал зохино. ... намын түшиг, шутах гол этгээд бол нэгэнт дунд ба хоосон ядуу этгээд болой...”.

Э.Ринчино. “Монголын хувьсгалын ирээдүй цагийн байдал төлөв” хэмээх бичгээс.



1. Сурвалж 1 дэс суулан шалтгаалж, Монголын хувьсгалын 30У даа түүслэлийг асахын түүлю ямар утга агуулгатай бичиг өргөв? Түүний учир шалтгаан юу болохыг тодорхойлно уу.
2. Сурвалж-2, 3-ыг харьцуулан шинжлэх замаар Д.Бодоо, С.Данзан нарын үйл хэрэг, үзэл бодлыг хээлэлцээрэй.
3. Сурвалж-4-ийг судлаад өөрт төрсөн сэтгэгдлээ цөөн үгээр бичиж бусдадаа тайлбарлана уу.
4. Сурвалж-5 болон бусад мэдээллийг ашиглан ЗХУ, Коминтерниий зүгээс Монголд социалист чиг шугамыг тулган хүлээлгэхийг хүчлэн эрмэлзэж байсны учир шалтгааныг тайлбарлаарай.
5. Дээрх үзэл баримтлалуудаас хамгийн оновчтой гэж үзэж байгаагаа сонгон авч тухайн үеийн нөхцөл байдалтай холбон үндэслэлээ тайлбарлана уу.



### III БҮЛЭГ. БНМАУ СОЦИАЛИЗМЫН ЗАМААР (1924-1990)

1924 он

1946 он

1961 он

1966 он

Монгол Улсад  
Бүгд Найрамдах  
засаглал тогтв.

БНМАУ-ыг  
хөрш улсууд хүлээн  
зөвшөөрөв.

НҮБ-ын бүрэн  
эрхт гишүүн  
болов.

Социализм  
байгуулж дуусгах  
зорилт дэвшүүлэв.



- БНМАУ ягаад Зөвлөлтийн дагуул улс гэгдэх болсон бэ?
- Монгол Улс социалист байгуулалтын замыг сонгосон шалтгаан юу байсан бэ?
- Монголчууд дэлхий дахинтай зэрэгцэн хөгжихөд нөлөөлсөн хүчин зүйлс юу байсан бэ?

#### 1. Монгол Улсын анхдугаар Үндсэн хууль

1921 оны хувьсгал ялсны дараа Монгол Улсын Үндсэн хуулийг боловсруулах ажил эхэлжээ. Монголын төрийн зүтгэлтнүүд үүнд ихээхэн нухацтай хандаж, Д.Бодоо, Ж.Цэвээн нар өөрсдийн санал бодлыг тусгасан төслийг боловсруулж байв.

1922 оны 5-р сарын 29-нд Үндсэн хууль боловсруулах комиссыг Шүүх яамны сайд Н.Магсаржаваар ахлуулан, Ж.Цэвээн, Ч.Бат-Очир нарын бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Тэдэнд "...Англи мэт улсын хуулиас товчлон авч эдүгээгийн явуулан буй засгийн байдалд нийлүүлэн зохиох" удирдамж өгч, "бас өөр боловсронгуй хүмүүсийг урин авч хэрэглэх" эрх олгон, төсөл боловсруулахыг даалгав. Комисс Англи, Швед, Бельги, Голланд зэрэг улсын Үндсэн хууль ба түүнд дүйцэх баримтыг орчуулж судалжээ. Гэвч 1924 онд Үндсэн хууль боловсруулах комиссыг өөрчилж, шинэ төслийг Б.Цэрэндорж, Ж.Цэвээн, Э.Ринчино, П.Всесвятский нар боловсруулсан юм. Үндсэн хуулийг боловсруулахад Монгол дахь Коминтерний төлөөлөгч, Зөвлөлтийн мэргэжилтний оролцоо, үзэл хандлагын нөлөө их байсан ч Монголын төрийн зүтгэлтнүүд улс орныхоо онцлог, олон улсын жишгийг харгалзсан Бүгд найрамдах засаг тогтоох төслийг боловсруулж чаджээ.

**Сурвалж-1:** "...Үндсэн хуулийн төслийг нөхөр Всесвятскийтэй хамтран боловсруулсан юм. ЗСБНХУ хийгээд Алс-Дорнодын Бүгд Найрамдах Улсын Үндсэн хууль болон бусад янз бүрийн төслийг авч хэлэлцээд уг төсөлд бага зэргийн засвар оруулан бүхэлд нь баталсан юм..."

... БНМАУ-ын Үндсэн хуулийг (гол хуулийг) боловсруулж, Их Хурлаар батлах явдал хамгийн чухал асуудал болон тавигдаж байгаа юм. ...уг Үндсэн хууль юуны өмнө Монгол ямар бүгд найрамдах засагтай байх вэ, түүний үндэс нь юу байх вэ гэдгийг яг таг заан тодорхойлох, хоёрдугаарт, уг засаг хүн амын ямар ангийг тулгуурулах вэ? гэдгийг тогтоох, гуравдугаарт, Засгийн газрын байгууллагуудын үүргийг зааж өгөх ёстой юм.

... Үндсэн хуулийн гурав дахь гол зүйл бол байнгын тэргүүлэгчид бүхий Бага Хурлыг байгуулах явдал мөн. Их Хурлын тухай хуучин дүрэмд байнгын тэргүүлэгчийн тухай заалт байсан боловч тэр нь утгагүй зүйл байв. Шинэ үндсэн хуульд зааснаар Их, Бага Хурал хийгээд Эдийн засгийн зөвлөл бүхий Засгийн газартай байна гэдэг бол манайхны Бүх Оросын Зөвлөлүүдийн Их Хурал, Бүх Холбоотны Төв Гүйцэтгэх Хороо, Ардын Комиссар нарын Зөвлөл гэсэнтэй адил юм.

Т.Рыскуловоос КИГХ-ны нарийн бичгийн дарга Д.З.Мануильский, КИГХ-ны Алс Дорнодын хэлтсийн эрхлэгч Г.Н. Войгинский нарт явуулсан илтгэлээс.

Засаглалын ямар хэлбэрийг сонгох асуудал ид яригдаж байх үед, 1924 оны 5-р сарын 20-нд Богд хаан таалал төгсчээ.

1924 оны 6-р сарын 7-нд МАН-ын ТХ, Монголд ардын бүгд найрамдах засаг тогтоох тухай тогтоол гаргав. Түүнд төрийн дээд эрхийг ард түмний сонгосон төлөөлөгчдөөс бүрдсэн **Улсын Их Хурал** (УИХ) барихаар заажээ. УИХ хуралдуулах бэлтгэлийг хангаж, 1924 оны 11-р сарын 8-28-ны өдрүүдэд Улсын анхдугаар Их

Хурал Нийслэл Хүрээнд хуралдав.

УИХ-аар Засгийн газар, яамдын тайлан, бүх аймаг, шавь, Ховдын тариачин, Алтайн Урианхай, Хасагийн хошуудын илтгэлийг сонсож, Засгийн газраас баталсан хууль дүрэм, Үндсэн хуулийн төслийг хэлэлцжээ.

**УИХ-аар хэлэлцэн шийдвэрлэсэн хамгийн гол асуудал бол Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийг батлан тогтоосон явдал болно.**

Үндсэн хуульд Монгол Улсыг “Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс” хэмээн нэрийдэв. Үндсэн хуулиар Монгол Улсын төрийн байгууллын тогтолцоог хуульчлан баталжээ. УИХ-ыг олон шатны хурлаас буюу арван гэр, баг, сум, хошуу, аймгаас төлөөлөгч сонгон байгуулах болжээ. Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын төрийн дээд эрхийг УИХ-д хадгалах ба хурлын чөлөө цагт **Улсын Бага Хурал** (УБХ), мөн хурлын чөлөө цагт УБХ-ын Тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалахаар хуульчилж төрийн эрх мэдлийг хуваарилсан байна. Энэ нь ард түмнээс төрийн хэрэгт оролцох эрх чөлөөг Монголын түүхэнд анх удаагаа хуульчлан тунхагласан чухал ач холбогдолтой зүйл байв.

Үндсэн хуулинд иргэдийн эрхийг тунхаглаж, түүнээ хэрэгжүүлэх баталгааг хуульчилжээ. Тус улсын иргэд угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй ялгаваргүйгээр нэгэн адил эрхийг эдлэх, хүн бүр чөлөөтэйгээр уг хэлэх, хэвлэх, жагсах, хуралдах, эвлэлдэх, эрдэм боловсролыг олж авах, бусдын хөдөлмөрийг үл мөлжигч 18 нас хүрсэн иргэн бүр сонгох, сонгогдох эрхтэйг батлан тунхаглажээ.

**Сурвалж-2:** 35-р зүйл. Аливаа Хурлын төлөөлөгчдийг сонгох ба мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхгүй хумуус нь:

1. Ямагт ашигийг эрмэлзэж бусдыг зарж мөлжин амьдрагчид
2. Ямагт бусдыг хөлслөн зарах ба хөрөнгө орлого зэргийн үржлээр амьдрагч жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид
3. Үрьдын ван, гүн ба хутагт хувилгаад жич орон хийдэд үргэлж суух санваартан лам нар
4. Солиорсон ба ухаан зэвдэрсэн бөгөөд зохих газраас шинжлэн батлагдагсад
5. Эд хичээх зэргээр нэрийг гутаах явдал үйлдэж, зарга шүүх газраас ял шийтгэгдэгсэд болно.

БНМАУ-ын Үндсэн хуулиас. (1924).



1. Сурвалж-1 -ийг уншаад Үндсэн хуулийн ач холбогдлыг хэрхэн тодорхойлж байна вэ?
2. Монголд Бүгд найрамдах засаглал тогтооход нөлөөлсөн гадаад, дотоод шалтгааныг ангилж, эрэмбэлээрэй.
3. Үндсэн хуулийн төслийг эцэслэн боловсруулахад хэн голлох оролцоотой байв? Яагаад?
4. Сурвалж 2-ын мэдээнд тулгуурлан Үндсэн хуулийн 35-р зүйлийн талаар та санал бодлоо илэрхийлнэ уу.
5. Анхдугаар Үндсэн хуулийн зөрэг, сөрөг талуудыг харьцуулж дүгнээрэй.

## 2. Улс орноо хөгжүүлэх чиг хандлага, зөрөлдөөн

**Үндэсний ардчилсан үзэлтнүүдийн бодлого, үйл ажиллагаа**

1921 оноос Монголд хэрэгжиж эхэлсэн ардчилсан өөрчлөлт, шинэчлэлтийн бодлогыг **Коминтерн, Бүх Холбоотын Коммунист /большевик/ Нам (БХК(б)Н)** эв хамтын ёс руу залж, МАХН-ыг большевикчлахыг оролдон, хөгжлийн социалист загварыг тулгаж байв. Энэ шахалт дарамтыг Монголын удирдлага сөрөн зогсож, ардчилсан өөрчлөлтөө гүнзгийрүүлэхийг чармайж байлаа.

Б.Цэрэндорж, Ц.Дамбадорж, А.Амар, Н.Жадамба нар дэлхийн хүчирхэг улс орнуудтай найрамдалт харилцаа тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх, монгол туургатныг нэгэн гэр улс болгон хөгжих зорилт дэвшиүүлэн тавьж байв. Тэд ЗХУ-тай тогтоосон найрамдалт харилцаагаа бэхжүүлэхэд анхаарч, ДИУ-тай хэвийн харилцаа тогтоох талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулахын сацуу Герман, Франц улсад хүүхдүүдээ сургах зэргээр харилцаж байв.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БНМАУ-д СОЦИАЛИЗМ БАЙГУУЛАХ ОРОЛДЛОГО (1924-1990)

Нийгэм, эдийн засгийн хүрээнд “бусдыг мөлжихгүй нийтээр тэгш хөрөнгөжих”, “шашныг ариунаар мандуулах” зорилт тавьж, иргэдийн эрх чөлөө, сүсэг бишрэлийг хүндэтгэх бодлого барьж байв.

**Сурвалж-1:** ... Ялангуяа Цэрэндорж, Цэвээн, Дамбадорж, Жадамба нараас Холбоот улсын тусламж нь эдүээс туслаа мэгт болочвээсээс тийм үнэн хэрэг буюу ач тустай явдал ч бус, хэзээ ч биднийг идэх залгих гэж буй явдал Коминтерн ба Холбоот улсаас бидний улс төрийн гадаадтай харилцах явдлыг боогдуулж, эрхийг гартаа атгаж авахыг оролдох буй. Тиймийн тул эдүгээ Япон, Англи, Америк, Герман зэрэг гадаадын хучирхэг хөрөнгөтөн улстай шууд харилцаж тэдгээрийн эд хөрөнөө, эрдэм боловсролын тусламжаар түргэн хөгжиж СССР-ийн улс төрийн гадаад бодлогоос эрх биш ангижран гарвал зохиц болно эзх зэрээр хортой хувьсгалын эсэргүү санал бодлогуудыг агуулан ил далдаар эсэргүүцэн тэмцэж байсан болой...

Ө.Бадрах. Намаас баруун бөөрөнхийчүүд лүгээ тэмцсэн амжилттай их тэмцлийн туршилага номоос. (1932).

Хувийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зорилгоор дотоодын гаалийг 1925 оноос эхлэн хорогдуулж, 1928 онд бүрмөсөн халжээ. Гадаадын пүүс, аж ахуйн нэгжүүд тус улсын эдийн засагт чухал байр суурьтай байв. 1927 оны байдлаар тэд БНМАУ-ын дотоодын бараа, эргэлтийн гүйлгээний 67 хувийг гүйцэтгэж байв.

1926 оны 9-р сард Засгийн газраас төр шашны хэргийг тусгаарлан явуулах тухай хуулийг баталжээ. Тухайн үед МАХН, “шашны номлол ба ардын төрийн ёс суртлын хооронд онц харшлалтай зүйлгүй” хэмээн тунхаглаж байв. Хуучны түшмэдийг ашиглах бодлого амжилттай хэрэгжиж байв.

Гэвч Монголын удирдагчдын бодлого, үйл ажиллагаа большевик үзлийг дээдэлсэн Коминтерний удирдагчдын хатуу эсэргүүцэлтэй тулгарсан юм.

**ЗХУ, Коминтерн Монголд төрийн эргэлт зохион байгуулсан нь.** 1927 оны сүүлчээр Коминтерн, МАХН-ын байдлын тухай хэлэлцээд “тус намын доторх барууны хэлбэрэлтэй урьдахаас илүү ширүүн тэмцэх”-ээр шийдвэрлэжээ. 1928 онд Монголд Коминтерний төлөөлөгчийн газрыг И.Райтер нарын гурван хүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар тогтов. И.Райтер нар Монголд ирмэгцээ сөрөг хүчинийг зохион байгуулах ажлыг эхлүүлжээ.

БХК(б)Н, МАХН-ын VII их хуралд Коминтерний төлөөлөгчөөр Б.Шмераль, М.Амагаев, В.Макдональд нарыг оролцуулахаар шийдвэрлэж, ажиллах заавар өгчээ.

**Сурвалж-2:** ...Төлөөлөгчдийн өмнө дор дурдсан үүрэг зорилт тавьсугай.

- 1.Ажил хэргийн байдлыг газар дээр нь нарийн нягт судалж, Коминтерний Гүйцэтгэх Хороо (КИГХ)-нд зохиц мэдээлэл өгэх
- 3.Зүүн (хөдөөгүйнхний) хэсгийг дэмжиж, КИГХ-ны боловсруулсан...хөтөлберийн үндсэн дээр тэднийг зохион байгуулах
4. Намын удирдах байгууллагад ядахдаа зүүнийхний урьдын байр суурийг хадгалж үлдэх... ”  
МАХН-ын VII их хуралд оролцох Коминтерний төлөөлөгчдөй өгсөн удирдамжаас. (1928).

Коминтерний төлөөлөгчид Монголд ирмэгцээ “хөтөлбөрийг дээд зэрээр биелүүлэх боломжтой” гэж төвдөө мэдэгджээ. Тэд МАХН-ын ТХ-ны гишүүдтэй ганцаарчилсан уулзалт зохион байгуулж, тэднийг нам, төрийн удирдагчдын эсрэг түлхэж, улмаар Намын сургуулийн оюутнууд, ЗХУ-д суралцагсдыг “дайрагч отряд” болгон ашиглахаар төлөвлөжээ. Мөн МАХН-ын их хурлын өмнө хуралдсан бүгд хурлын үеэр зарим оролцогсдыг “**боловсруулах**”, айлган сурдуулэх, дарамтлах зэрээр ажиллаж, “**барууны аюул**” гэгчийг илчлэх ажлыг зохион байгуулсан байна.

1928 оны 10-12-р сард МАХН-ын VII, БНМАУ-ын V Их Хурал хуралдажээ. Намын их хурал дээр тэдний түлхээсээр зүүн жигүүрийнхэн, эрх баригчдыг Коминтерн, ЗХУ-аас салан холдохыг оролдсон, Хятад, Японд дотночлон хандсан, улс орныг хөрөнгөтний замд оруулах гэсэн зэрээр буруутган шүүмжлэв. Мөн барууны

хэлбэрэл гаргалаа, эд бол “баруунтан”, “барууны бүлэг” хэмээн буруутгаж, ажил албанаас нь зайлцуулжээ. Тэдний халааг П.Гэндэн, О.Бадрах, Б.Элдэв-Очир, З.Шижээ, Б.Лааган, Ц.Жигжиджав нарын зүүнтнүүд авсан байна.

**Сурвалж-3:** ... Монголын нутаг дэвсгэр Англи, Герман, Францын нутгийг нийлүүлснээс их мөртөө хүн ам нь ердөө л 800 мянга орчим... Монгол орон империалистууд, дэлхийн хувьсгалын дайны нөлөөнд орчихоогүй байгаа дээр нь бид тэрхүү нутаг дэвсгэрт тогтоосон нөлөөэөө хадгалж байхын тулд бусармаг муухай аргаар ч болов оролцож байхад манай зорилт оршино гэж бодож байна. Энэ зорилт нь 800 мянган малчны оронд социализм байгуулахаас ч чухал юм... Нөхөд минь аугаа их хязгаарын төлөө ердөө л 800 мянган хүн ам аж төрдөг энэ орныг бид маш хямдханаар авч болно... МАХН-ын VII их хуралд оролцсон Коминтерний төлөөлөччидийн тэргүүн Б.Шмералийн тайлангаас. (1928).

1. Зүүнтний удирдаачдын нэг О.Бадрах Монголын үндэсний ардчилсан үзэлтнүүдийг “хувьсгалын эсэргүү санал бодлогыг агуулж байсан” гэсэнтэй та санал нийлэх үү? Тэр яагаад ийнхүү дүгнэх болов?
2. Сурвалж 1,2,3-ыг уншиж харьцуулаад ямар дүгнэлт хийж болох вэ?
3. Монголын дотоод хэрэгтэй ЗХУ, Коминтерн хэрхэн оролцож байсныг тодруулахад дээрх сурвалжууд ямар хэрэгтэй вэ? Чухал ач холбогдолтой сурвалж нь таны бодлоор аль нь вэ? Яагаад?

### БНМАУ-д нийгэм журмыг хурдавчлан байгуулах оролдлого, үр дагавар.

Коминтерний түлхээсээр засгийн эрхэнд гарсан зүүнтнүүд Монголд нийгэм журам (социализм)-ыг шууд байгуулах чиг бодлогыг хэрэгжүүлж эхлэв. 1929 оны 12-р сарын 3-нд Коминтернээс тусгай зааврыг МАХН-ын ТХ-нд ирүүлж, “БНМАУ-ыг хөрөнгөтний бус замаар буюу нийгэм журмын замаар хөгжүүлэх төлөвлөгөө зохиож ажиллах, богино хугацаанд нийгэм журмыг байгуулахдаа ЗХУ-ын туршлагыг хэрэглэх тухай” заажээ. Коминтерний төлөөлөгч В.Кучумов дээрх зааврын үзэл санааг МАХН-ын VIII их хурлын тогтоолд (1930) тусгаснаар Монголд зүүний алдаа завхрал лавшран гүнзгийрэв. Энэ үед иргэдийг удам угсаа, хөрөнгө, үзэл бодол, шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхах явдал газар авч, язгууртан, чинээлэг иргэд, сүм хийдийн хөрөнгийг хураах, хамтралжуулах, гадаад худалдаанд онц эрх тогтоох, хувийн худалдаа, тээвэр, үйлчилгээг хязгаарлах, сүм хийдийг хаах, лам нарыг албадан хар болгох зэрэг кампанит ажлыг өрнүүлэв.

Юуны түрүүнд нам эвлэл, төрийн албанаас баруунтан хэмээгдэгсдийг “цэвэрлэх” ажлыг эхлүүлж, хагас жилийн дотор намын 18 мянган гишүүнээс 5 мянга гаруйг нь хөөжээ. Намыг нэг ангийн болгох, ядуу үгээгүй нарыг намд элсүүлэх ажил өрнүүлснээр 2 жилийн дотор МАХН 40 мянган гишүүнтэй болсон байна.

Монголд ажиллаж байсан гадаадын пүүс компанийн үйл ажиллагааг зогсоож, гадаад иргэдийг хөөн гаргах ажиллагааг эхлүүлж, экспортын гол бүтээгдэхүүн – малын түүхий эд, ангийн арьс үсийг гадагш гаргах онц эрхийг улсын мэдэлд авчээ.

Хувийн өмч, хувийн хөдөлмөрийг устгах, энгийн худалдаа, жин тээврийг шахах бодлого явуулав. Үүний улмаас бараа таваарын хомсдол нүүрлэж цай, гурил, будаа, даалимба эд бараагаар гачигдаж, амьдралын түвшин доройтоход хүрчээ.

**Сурвалж-4:** ... 1931 оны 3-р сард санаанд багтмааргүй баримт илрүүлсэн. Монголын төв хоршооны агуулахад ... 130 мянган төгрөгийн хулдаас, янз бүрийн гоёл чимэглэлийн зүйл 913 төгрөгийн, ... 130 мянган төгрөгийн их үнэтэй тоглоом, Улаанбаатар дахь Монголын төв хоршоо хилэн үстэй тоглоомон тэмээг ширхгийг нь 75-100 төгрөгөөр үнэлэн худалдаж байсан бол амьд тэмээ 25-40 төгрөгийн үнэтэй байсан нь үнэндээ доромжилсон хэрэг болсныг тэмдэглэх хэрэгтэй.

... Монголын төв хоршооны агуулах, дамжуулах цэгүүдэд бараа их хэмжээгээр хурийтталж байгаагаас зарим бус нутгийн хүмүүс өлсгөлөнгийн байдалтай байна... Таваарын өлсгөлөнгөөс болж говийн бүсээс 2000 өрх айл мал хөрөнгийн хамт хил даесэн байна...

МАХН-ын Төв Хянаан шалгах комиссын өрөхийн сургагч П.И.Гапеевын рапортаас. (1932).

Шашинтай тэмцэхдээ хамгийн харгис аргыг хэрэглэж байв. Иргэдийн сүсэглэх шүтэх эрхэнд халдаж, лам нарыг элдвээр хавчин хяхаж байлаа. Зая бандида, Хамба номун хан, Хүүхэн хутагт зэрэг нэр нөлөө бүхий лам нарыг баривчлан хороожжээ. Сүм хийд, лам нарт албан **татварын онцгой бодлого** тулгажээ. 1930 оны байдлаар Монголын нийт мал сүргийн 12,8 хувь буюу 3 сая нь жасад харьяалагдаж байв. Жасын мал хөрөнгийг шууд хураах нь нам, засгийн нэр төрд халтай байсан тул жасын малыг ядуу хоосон ба дунд аж ахуйтнаар, хамтралд гэрээгээр маллуулах шийдвэр гаргав. Энэ дагуу 1930 оны 2-р сараас "**жасын кампани**" гэх бодлого хэрэгжүүлж, жасын малыг шилжүүлэн хариулуулах нэрээр хураан авчээ. Тэгснээр сүм хийдийн малын 87 хувь буюу 2,6 сая толгой мал улсын мэдэлд гартишиж, бүх сүм хийдэд өрдөө 392 мяняган толгой мал үлддээ.

Монголын нийгмийн чинээлэг хэсгийн мал хөрөнгийг хураах балмад ажиллагаа 1929 онд эхлэв. Феодалын хөрөнгө хураах Төв комиссыг 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаа нь Х.Чойбалсанг томилжээ. Хөрөнгө хураах ажил 1932 оны эх хүртэл үргэлжилж, хуучны түшмэд, ноёд, язгууртан, хутагт хувилгаад, баян чинээлэг ардын 1560 гаруй өрхөөс 11 сая орчим төгрөгийн хөрөнгө хураасан байна. Хөрөнгийг хураахдаа өрхийн ам бүлийн тоог харгалзалгүйгээр 100 хувийн хөрөнгийг үлдээн түүнээс илүү гарсныг хураах журмаар гүйцэтгэжээ. 100 хувь гэдгийг тооцоходоо 30 төгрөгийн хөрөнгийг 1 хувьтай тэнцүүлэн боджээ.



Зураг 1. Хөрөнгө хурааж буй нь

**Сурвалж-5:** "...Хөрөнгө хураах асуудлаар бид томьёолол өгсөн..., ... хоёрдугаарт, хурааж авсан хөрөнгийг яах вэ? ... ядуучуудад юу ч өгөхгүй байна гэдэг бол ардууд манай талд орохгүй болно гэсэн үг... Бид хөрөнгийг сангийн аж ахуй, хамтрал, ядуучуудад тарааж өгөхийг санал болгож байна."


П.Гэндэн, З.Шижээ нартай И.А.Пятницикийн хийсэн уулзалт ярианы тэмдэглээс. (1932).

Зүүнтнүүд **хамтралжуулах бодлогыг** хүчлэн хэрэгжүүлэв. 1932 оны эх гэхэд 55.000 өрхийг нэгтгэсэн 752 хамтралтай болжээ. Хамтрал нь дотроо **коммун**, **артель**, **нөхөрлөл** гэсэн хэлбэртэй байв. Малчдыг хамтралд албадан оруулж, хураасан малыг хамтралд хуваан өгчээ. Нийгэмчилсэн мал, хөрөнгө үрэгдэн шамшигдаж байсны улмаас 1930 онд 23,7 сая байсан мал өрдөө хоёр жилийн дотор 16,3 сая болж 7,4 сая толгойгоор хорогдсон юм.

Тэрчлэн зүүнтнүүд засаг захиргааны уламжлалт хуваарийг өөрчлөн зохион байгуулж, 13 аймаг болгон хуваажээ.

! - Зүүнтнүүд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөх болсны учир шалтгаан юунд байсан гэж бодож байна вэ?

Зураг 2. Монгол Улсын засаг захиргааны хуваарь, 1931 он



1. Энгийн худалдааг хаасны улмаас үүссэн нөхцөл байдлыг тодорхойлно уу.  
 2. Хөрөнгө хураах Коминтерний зөвлөмжийг Монголын тал ямар арга барилаар, яагаад хэрэгжүүлэх болөв?  
 3. Хөрөнгө хурааж, худалдаа, тээвэрт улсын онц эрх тогтоосны шалтгааныг дүгнэж бичээрэй.  
 4. Зураг-2-ыг ажиглан 1931 оны засаг захиргааны хуваарийг өмнөх болон одоогийн засаг захиргааны хуваарытай харьцуулж ижил болон ялгаатай талыг тодруулаарай.

### 3.1932 оны зэвсэгт бослого, дүрвэх хөдөлгөөн

Зүүнтнүүдийн алдаатай бодлого, үйл ажиллагааны уршгаар БНМАУ-ын эдийн засаг, нийгмийн амьдрал гүн гүнзгий хямралд оров. Ард иргэд хэвийн аж төрөх боломжгүй болсноос нутгаа орхин хил даван нүүж эхэлжээ. 1930 оноос дүрвэх хөдөлгөөн эхэлж, 1932 оны дунд үе хүртэл үргэлжлэв. Одоогийн Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл аймгийг хамарчээ. Дүрвэгсдийн дотор лам, ноёд төдийгүй нам, эвлэлийн гишүүд, төрийн хууль тогтоох байгууллагын гишүүд хүртэл байжээ. Бүрэн бус мэдээгээр 42000 гаруй хүн дүрвэх хөдөлгөөнд хамрагдсан гэж үздэг. Тэр, засгаас авч явуулсан арга хэмжээний үрээр нэлээд хэсэг нь эргэж ирсэн ба 1940 он хүртэл буцаж ирэх явдал үргэлжилсээр байв.

Зэвсэг барин тэмцэх явдал 1929 оноос эхэлжээ. 1930 оны хавар Чандмань уулын аймагт нэлээд зохион байгуулалттай тэмцэл эхэлж, түүнд лам голдуу 600 гаруй хүн оролцсон ч бослогыг цэргийн хүчээр дарав. Шүүх таслах комиссын тогтоолоор 33 лам, 9 феодал, 25 ардыг олны өмнө буудан хороож, 40 гаруй хүнийг 10 жил хүртэл хорих ялаар шийтгэжээ.

1932 оны 4-р сарын 12-нд Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хялганатын хүрээнд зэвсэгт бослого дэгджээ. Босогчид зохион байгуулалтад орж, хуучин ноёнхийн нэрээр “Очирбатын яам” гэгчийг байгуулжээ. Тэд “шарын цэрэг” элсүүлэн, ойр зэргэлдээ орших сумдыг түйвээн хүрээгээ тэлсээр байв. Бослогыг удирдаж байсан тэргүүн, жанжин, хувилгаад нь ард олны дургүйцэл, тэмцэл хөдөлгөөнийг далимдуулан хуучны байгууллыг дахин сэргээхийг эрмэлзэж байлаа.

### Сурвалж-1: Нөхөр Сталин Танаа.

Монгол дахь байдал сүүлийн хэдэн хоногт эрс муудлаа. 5-р сарын 30-нд Цэцэрлэг хотын 500 винтов бүхий 1195 хүнээс бүрдсэн гарнizon бүхлээрээ босч засгийн байгууллагыг устгаад... бослогыг дарж буй отрядууд ихэд ядарч туйлдсан байна. Хөвсгэлийн районд бослого дахин гарах аюултай байна. ....Манайхаас туслахгүй бол эднийхэн (монголчууд) байгаа хүчээрээ бослогыг дарж дийлэхгүй гэж Охтн үзэж байна. Нийслэл Хүрээнд байдал хамгийн аюултай байгаа бөгөөд манай талаас туслахгүй бол алдаж магадгүй байна...

... Охтины саяын мэдээ тийм ч үнэн зөв биш бөгөөд биднийг осолтой хэрэгт татан оруулахын тулд байдлыг зориуд дэврэгэсэн болотоюй... Монголд манай цэргийг явуулах нь осолтой ажил гэж үзэж байна... энэ хэрэг дээр сайтар бэлтгэлгүй яaran шийдвэр гаргах нь Японтой зөрчил зэрэлдээн үүссэж, ЗСБНХУ-ын эсрэг Япон, Хятад, Монголын нэгдмэл фронтын бааз суурь болж магадгүй... Монгол дахь Зөвлөлтийн хүмүүс, төлөөлөгчдийн газрын ажлын тухай гэрч баримт болох элдэв баримт бичиг, шифр, протокол мэтийн бичиг цаасыг Монголоос ЗСБНХУ-д нэн даруй маш нууцаар авч гарахыг зөвлөе. Ямар ч нөхцөлд энэ туйлын чухал. И.В.Сталин.      БНМАУ-д Зөвлөлтийн цэргийн тусламж үзүүлэхийг хүч И.В.Сталинд явуулсан, мөн И.В.Сталинаас хариу илгээсэн цахилгаан утасны мэдээнээс. (1932).

Босогчид замдаа тааралдсан сургууль, хоршоо, хамтралыг тонон дээрэмдэх, устгах, орон нутгийн төр, захиргааны байгууллагын ажилтан, нам, эвлэлийн гишүүдийг баривчилж зүй бусаар тамлан хороох зэргээр ардын төрөөс өшөө хонзон авах шинжтэй болон хувирчээ. Тэдний дунд ардын засагт хамаг хөрөнгөө дээрэмдүүлсэн баячууд, шашин шүтээнээ доромжуулсан сүсэгтэн нараас гадна нам, эвлэлийн гишүүд, захиргааны ажилтнууд, бүр Улсын Их, Бага Хурлын гишүүд ч байжээ. Бослого хоромхон зуур хүчээ авч Дөрвөд (Увс), Ховд, Завхан, Алтай, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Өмнөговь аймгийг хамарчээ. Засгийн газраас зэвсэгт бослогыг дарах бүрэн эрхт комисс байгуулан ажиллуулж, Монгол ардын хувьсгалт цэрэг (МАХЦ), Дотоодыг Хамгаалах Газар (ДХГ)-ын тусгай морыт хорооны хүчийг дайчилжээ. Зэвсэгт бослогын тухай Москвад байнга мэдээлж байв. Зарим эх сурвалжид тэмдэглэнснээр бослогыг дарахад Зөвлөлтийн улаан армийн анги салбар оролцсон байна.

### Сурвалж-2: 10. Монголын тухай.

- Дараах үндсэн арга хэмжээ боловсруулахыг комисст даалгах:
1. Монгол нөхдийн үндсэн алдаа бол Зөвлөлт БНУ бол хөгжсөн аж үйлдвэртэй, пролетари бүхий социалист улс, харин БНМАУ бол хөрөнгөтний ардын ардчилсан улс гэдгийг ойлгохгүй, ЗХУ-ын зөвлөлт засгийн бодлогыг тэд сохиороо хуулж байгаад оршиж байна
2. Энэ алдаа бол Монголд өрнөж байгаа бослогын гол шалтгаан мөн.
3. Хэрэв хөрөнгөтний ардчилсан БНУ-ын бодлогыг зөв ойлгож, энэ алдаагаа засахгүй бол Монгол Улс оршин тогтоноход агуул занал хөвээр байх болно.

БХК(Б)Н-ын Төв Хорооны Улс Төрийн Төвчооны хуралдааны протоколоос. (1932).

1933 оны 4-р сарын 19-30-нд бослогын толгойлогчдыг шүүх хурал явагдаж Ч.Самбуу (дүвчин), Ц.Жамц, Б.Түгж, Б.Аюурзана, Б.Жамсрандорж нарын 18 хүнд цаазлан хороох ял, 15 шүүгдэгчид хорих ял онооожээ.

Энэхүү бослогыг Монголын түүх бичлэгт 1932 оны лам нарын бослого, хувьсгалын эсэргүү бослого гэж нэрийдэж байсан нь ташаарал юм. Учир нь энэ үйл явдалд зөвхөн лам нар бус Монголын нийгмийн бүхий л давхрааныхан оролцож, тухайн үеийн нам төрийн бодлогыг эсэргүүцэн тэмцсэн билээ. Тиймээс судлаачид 1932 оны бослогыг **иргэний дайны шинж чанартай** гэж үздэг.

1. Дүрвэх хөдөлгөөн, зэвсэгт бослого гарах болсон үндсэн шалтгаан чухам юу байсан бэ?
2. Монголын түүх бичлэгт эмнэ нь 1932 оны зэвсэгт бослогыг лам нарын бослого, хувьсгалын эсэргүү бослого гэж нэрлэдэг байсны учрыг тайлбарлаж, өөрийн санал дүгнэлтээ бичнэ үү.
3. Түүхэн баримтууд хэр үндэстэй гэж бодож байгаа талаар саналаа хэлнэ үү.
4. Сурвалж-1, 2 дээр ажиллан мэдээллийг батлах буюу няцааж, үндэслэлээ тайлбарлаарай.
5. БНМАУ-ыг яагаад хөрөнгөтний ардчилсан улс гэж Зөвлөлтийн тал тодорхойлох болсон талаар тунгаан бодож саналаа илэрхийлнэ үү.

#### 4. Шинэ эргэлтийн жилүүд дэх өөрчлөлт шинэчлэл, ахиц дэвшил

1932 оны 5-р сард БХК(б)Н-ын ТХ-ны Улс Төрийн Товчоо Монголын талаар тусгай тогтоол гаргав. Тогтоолд, Монголын хямрал нь тус улсын нам засаг, Коминтерний төлөөлөгчдийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гэв. ЗХУ-д социализм байгуулж буй туршлагыг шууд хуулбарлан хэрэглэсэн, нийт лам нарын эсрэг тэмцэж, ардын сүсэг бишрэлийг доромжилсон, Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөн, хувийн өмч хөрөнгийг хураасан, энгийн худалдааг устгасан, чинээлэг ардын эсрэг тэмцсэн нь гол алдаа болсон гэж тэмдэглэжээ.

1932 оны 6-р сарын 29-30-нд МАХН-ын ТХ, Хянан байцаах Төв Комиссын хамтарсан онц III бүгд хурал хуралдav. Тус хурал зүүнтний алдаа завхралын шалтгааныг нийгэм журмыг хурдавчлан байгуулах зорилгоор хувьсгалын одоогийн шатанд тохирохгүй бодлого явуулснаас болсон гэв. Цаашид БНМАУ шинэ маягийн хөрөнгөтний ардчилсан бүгд найрамдах улсын шинж чанартайгаар оршин тогтоно ёстой гэж тодорхойлжээ. МАХН-ын удирдлагыг өөрчилж, УБХ-ын Тэргүүлэгчдийн даргаар А.Амар, Ардын Сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайдаар П.Гэндэн нарыг сонгон баталжээ. Онц бүгд хурлын шийдвэрийг түүхнээ “Шинэ эргэлтийн бодлого” гэж нэрлэдэг.

**Сурвалж-1:** “Эдгээр нугалаа мушгилт буруу ташаа болсон зүйлүүд нь нийт нам бол ардын хувьсгалт ардчилсан Бүгд Найрамдах улс болох Монголын БНУ-ын эдийн ба үндэс байдалын онц зүйлүүдийг ойшоосонгүйг гэрчилж буй бөгөөд Монголын БНУ-ын онц байдлуулдлыг ойшоолгүй, СССР-ийн зөвлөлт засгийн аж ахуй, улс төрийн ажлын арга бодлогуудыг хэвээр буулган авч хэрэглэсэн ба СССР бол Бүгд Найрамдах Монгол улсаас онц тусгай өрнөн хөгжсөн аж үйлдвэртэй ба пролетарийн бөгөөд үйлдвэрийн зэвсгийн өмчтэй ёсиг устгасан нийгэм журамт улс мөн хэмээхийг анхааралгүй суп тавьсан болно.”


МАХН-ын Төв Хорооны онц III бүгд хурлын тогтоолоос.

Тус хурлаас улс орныг хямралаас гарган хөгжлийн хэвийн замд оруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заажээ. Үүнд:

- Ардын Засгийн газрыг бэхжүүлэх, үндэсний ардчилсан үзлийг чиг баримжаа болгох,
- Хамтрал, коммуныг татан буулгах, энгийн нэгдлүүдийг байгуулах,
- Чинээлэг ардыг хавчих явдлыг зогсоох, ардын аж ахуйтны хувийн идэвх санаачилга, баяжих, хөрөнгөжихийг сайшаан дэмжих,
- Хувийн хөдөлмөр, худалдааг хөгжүүлэх,
- Албан татварын бодлогоор ядуу, дунд ардуудад хөнгөлөлт үзүүлэх, улс, хоршооллын байгууллага, хувь хүмүүст зээл олгох,
- Шашин шүтлэгийг бүрэн чөлөөтэй болгох зэрэг болно.

Зүүнтний үеийн хууль дүрэм, заавар журмыг хянан үзэх, шинэчлэн боловсруулах ажил эхэлж, 1932-1934 онд 300 шахам хууль дүрмийг баталжээ. Ардын аж ахуйтны мал сүргээс хураах албан татварыг хөнгөвчилж, чинээлэг аж ахуйтанд зээл олгодоггүй байсан хуучин журмыг халж, нийт аж ахуйтанд зээл олгох, хянаж байх шинэ журмыг тогтоов. Шинэ эргэлтийн бодлогын үрээр 1940 он гэхэд мал сургийн тоо толгой 26,204 мянгад хүрч, 1932 оныхоос 39.1 хувиар өссөн байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БНМАУ-д СОЦИАЛИЗМ БАЙГУУЛАХ ОРОЛДЛОГО (1924-1990)



Зураг 3. Аж үйлдвэрийн комбинатын нээлт дээр А.Амарын хэлсэн үгтэй дурсгалын хөшөөний бичээс

Өмчийн бүхий л хэвшлийг дэмжиж, эн тэнцүүхэн хөгжүүлэхийг чухалчилж байв. Аж үйлдвэрийг хөгжүүлэхдээ улсын үйлдвэрийн газрыг байгуулах, хоршоолсон гар үйлдвэрийг бэхжүүлэн олшууллах, хувийн гар урлалыг зохистой дэмжих бодлого барьж байлаа. 1933-1935 онд Аж үйлдвэрийн комбинат, Төв цахилгаан станц, Хатгалын

ноос угаах үйлдвэр байгуулагдаж үндэсний аж үйлдвэрийн суурь тавигджээ.

Шинэ эргэлтийн эхний жилүүдэд буюу 1932-1933 онд ард олны шүтэх, сүсэглэх эрхийг сэргээн хэрэгжүүлсэн боловч 1933 оны 7-р сараас эхлэн өөрчлөгдөв. Өргөн олны сүсэг бишрэлийг хүчээр хориглож, лам нарт хэд хэдэн төрлийн татвар ногдуулан хураах болсон ба нам, эвлэлийн гишүүдийг шашин шүтэх эрхийг хориглож, улмаар 1938 оны эхээр бүх сүм хийд хаагдсан билээ.

Үндэсний соёлын өвийг феодалын соёл хэмээн үгүйсгэж, хуучин сэхээтнийг бүхэлд нь хавчин гадуурхаж байсан явдлыг зогсоов. 1934 оноос бичигтэн бүр бичиг үсэг үл мэдэх хүмүүсийг сургах ажил өрнүүлснээр хүн амын бичиг үсгийн түвшин дээшлэв. 1935 онд нийт хүн амын 5,6 хувь нь бичигтэй байсан бол 1940 онд 20,8 хувь болж нэмэгджээ.

Монгол орны ургамлын нэр төрлийг бүртгэх, ургамал, хөрс, ус бэлчээрийн судалгаа хийгдэж байв. Монгол орны физик газарзүйн зургийг хэвлэн гаргажээ.

Театрын урлагийн хөгжилд гарсан том дэвшил нь “Учиртай гурван толгой” жүжгийг 1934 онд Төв театрин тайзнаа тоглосон явдал байв. 1935 онд “Монгол кино” үйлдвэр байгуулагдаж, дараа жил нь “Монгол хүү” гэх анхны уран сайхны кино дэлгэцнээ гарав. Ном хэвлэлийн ажил өргөжин 1921 онд 1000 даралт хуудас хэвлэж байсан бол 1936 онд 12 сая болж өсчээ. 1930-аад оны эцэст 5 сонин, 7 сэргүүл нийтдээ 90 мянян хувь хэвлэгдэж, 10 хүн тутамд нэг хэвлэл оногдох болжээ. 1934 оны 9-р сарын 1-нээс байнгын радио өргөн нэвтрүүлэг явуулах болсон нь хүн амын соёлын гэгээрэлд ихээхэн нөлөө үзүүлэв.

Шинэ эргэлтийн бодлого нь Монголын нам, төрөөс 1928 оны эцэс хүртэл хэрэгжүүлсэн үндэсний ардчилсан хөгжлийн чиг шугамыг сэргээн хэрэгжүүлсэн үйл явц байлаа. Шинэ эргэлтийн жилүүдэд Монголын улс төрийн зүтгэлтнүүдийн бие даасан бодлого, үйл ажиллагаа дахин идэвхжиж, эдийн засаг, соёлын салбарт багагүй амжилт олсон юм.

1. Зөвлөлтийн тал Монголын улс төр, эдийн засгийн амьдралыг өөрийн үзэмжээр залж байсны учир шалтгаан, гол хөшүүрэг нь юу байсан бэ?
2. Зөвлөлтийн тал БНМАУ-д тулган хэрэгжүүлэхийг оролдсон социализм байгуулах зорилтоосоо татгалзах болсны учир шалтгааныг тайлбарлана уу.
3. Жижиг хувийн өмчтөнийг дэмжих бодлого нь социалист нийгэм байгуулах үзэл баримтлалтай зөрчилдсөн болохыг шалтгаан, үр дагаврын холбоонд нь тайлбарлаарай.
4. Сурвалж 1-ийн мэдээнээс ямар дүгнэлт хийж болох вэ?
5. Зураг 3-т буй аж үйлдвэрийн комбинатын нээлт дээр А.Амарын хэлсэн үгтэй дурсгалын хөшөөны бичээсийг уншиж, шинэ эргэлтийн бодлогын ач холбогдлын талаар дүгнэлт хийгээрэй.

## 5. Улс төрийн хэлмэгдүүлэлт: үйл явц, үр дагавар

Монголд хууль ёсыг ноцтой завхруулж улс төрийн талаар хэлмэгдүүлэх явдал 1922 онд Ерөнхий сайд Д.Бодоог хилсдүүлэн хөнөөснөөр эхэлжээ. ЗХУ, Монголыг нөлөөнийхөө хүрээнд байлгах бодлогоо үргэлжлүүлэн, лам нарын эсрэг эрс хатуу тэмцэн устгахыг шаардаж байв. 1933-1934 онд Монголын буриад голдуу иргэдийг хувьсгалын эсэргүү, Японы тагнуул гэх зохиомол хэрэгт холбогдуулан хэлмэгдүүлжээ.

Монголын түүх бичээгт ард иргэдээ угсаа гарал, үзэл болд, хөрөнгө чинээгэр нь ялагварлан хилсээр залхаан цээрлүүлсэн явдлыг хэлмэгдүүлэлт гэж нэрлэдэг.

Тэрчлэн ЗХУ, Монголын удирдлагад дуулгавартай, зааврыг нь ягштал биелүүлэх хүнийг дэвшүүлэхийг зорьж, А.Амар, П.Гэндэн, Г.Дэмид нарыг “манай чиг шугамыг хангаж чадахгүй” гэж үзэн зайлцуулах арга хэмжээ авчээ. Зөвлөлтийн шууд оролцоотойгоор 1936 оны эхээр ДХГ-ыг **Дотоод Явдлын Яам (ДЯЯ)** болгож, урьд нь Ерөнхий сайдын орлогч болгоод байсан Х.Чойбалсанг сайдаар нь томилуулжээ. Тэрээр 1937 оны 9-р сарын 2-нд **Цэргийн Явдлын Яам (ЦЯЯ)**-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжнаар томилогдсоноор хүчний байгууллагын бүх эрх мэдэл түүний гарг төвлөрчээ. Ингэснээр Монголд нэг хүний ганцаар дарангуйлах **тоталитар дэглэм** тогтох нөхцөл бүрдэж, хууль ёс ноцтой зөрчигдөхөд хүргэжээ.



### Тоталитар дэглэм.

Нэг үзэл суртал, нэг хүний дарангуйлалд тулгуурладаг, ардчилал, хууль ёсыг тажуудуулдаг улс төрийн дэглэм.

Нь Ерөнхий сайдын орлогч болгоод байсан Х.Чойбалсанг сайдаар нь томилуулжээ. Тэрээр 1937 оны 9-р сарын 2-нд **Цэргийн Явдлын Яам (ЦЯЯ)**-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжнаар томилогдсоноор хүчний байгууллагын бүх эрх мэдэл түүний гарг төвлөрчээ. Ингэснээр Монголд нэг хүний ганцаар дарангуйлах **тоталитар дэглэм** тогтох нөхцөл бүрдэж, хууль ёс ноцтой зөрчигдөхөд хүргэжээ.



**Сурвалж-1:** ...Хүнийг сэжиг таавраар дайчлан баривчлах, мөрдөн байцаалтыг хууль бус аргаар явуулж, тулган хавчих замаар хилс хэрэг хүлээлгэж, нээсийн жагсаалтаар Онц бүрэн эрхт комисс оруулан үйл олионор нь буудан алах явдал Дотоод яамны эн үеийн үйл ажиллагааны гол арга болж байжээ. ...Хэзээ хэнд элссэн, хэнийг элссүүлсэн бэ гэдээ асуулт голлон тавьж олон хүний нэр гаргасуулж болсон нь хэргийн материалиудаас тодорхой харагдаж байна. ....Хүний бие махбодийг тарчилган зовоох эрүү шүүлтийн өөр нэг хэлбэр бол хорих журам байжээ. Нээг дор үй олон хүн оруулж, унтах, хээтэх, сууж амрах болопцогүй болгон хориж байсан ба өдрийн цагт унтахыг чандлан хорилож, өдөржин суугаа буюу босоо байгаад, шөнөд нь аваачин удаан цагаар мөрдэж, хүнийг тэсвэрлэшгүй байдалд оруулж нойроор хавчин зовоодог байсан... мөн цементэн шалтай, дэвсгэргүй, гол түлдэггүй хүйтэн жижиг өрөөнд хүнийг дан өмд цамцтай нь оруулж түгжээд, цонхыг нь онгорхой байглаж осгоодог харгислал 1949 он хүртэл хэрэглэгдэж байжээ...

“Улсын аюулаас хамгаалах байгууллагын ажилд гарч байсан алдаа завхралын шалгасан дүнгийн тухай” илтгэлээс. (1962).

1937 оны 8-р сарын 24-нд ЗХУ-ын Дотоод хэргийн ардын комиссарын орлогч М.П.Фриновский, Батлан хамгаалахын ардын комиссарын орлогч И.Н.Смирнов, ЗХУ-аас БНМАУ-д суух бүрэн эрхт төлөөлөгч С.Н.Миронов нар Улаанбаатарт ирж, Японоос БНМАУ-ыг эзлэх төлөвлөгөө гэгчийг Монголын удирдлагад танилцуулж, “Заговор” (Хуйвалдаан) гэх 115 хүний нэрийн жагсаалтыг гардуулжээ. Уг жагсаалтын дагуу хүмүүсийг дайчлан баривчлах ажиллагaa 1937 оны 9-р сарын 10-ны шөнө эхэлжээ. Энэ хэрэгт яамны сайд дарга нараас жирийн ардыг хүртэл олон мянган хүнийг баривчилж, тэдэнд “Японы тагнуулын байгууллагын даалгавраар БНМАУ-ын нутагт тагнуул үйлдэх, бослого гаргах, хорлон сүйтгэх үйл ажиллагaa явуулах гэж байсан” хэмээн хилс ял тулгаж шийтгэжээ. Энэ үйл явц 1937-1940 онд оргилдоо хүрснийг **их хэлмэгдүүлэлт** гэж нэрийддэг.

БНМАУ-ын VII Их Хурлаас сонгогдсон УБХ-ын гишүүдийн тал илүү хувь нь хэлмэгдсэнээр төрийн эрх барих дээд байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүй болжээ. Засгийн газрын гишүүдийн ихэнх нь, Монгол ардын хувьсгалт

цэрэг (МАХЦ)-ийн удирдах бие бүрэлдэхүүний 85 хувь нь хэлмэгджээ. Монголын удирдагчдыг Зөвлөлтийн хуулиар яллан ЗХУ-ын шоронд хорьж, тамлан зовоож хороож байв. БНМАУ-ын Бага Хурлын дарга Д.Догсом, орлогч дарга Д.Лосол, Ерөнхий сайд А.Амар, П.Гэндэн нарын улс төрийн зүтгэлтнүүд ЗХУ-ын шүүхээр яллагдан амь наасаа алджеэ.

ЗХУ, И.В.Сталины зүгээс лам нарыг шууд устгах зааврыг тулгаснаар лам нарыг Монголын ард түмний дайсан, Японы түшиг тулгуур хэмээн олноор нь баривчилж цаазалжээ. Албан баримтаар 1937-1939 онд нийт 17 мянга орчим лам нарыг хороож, хорьж шийтгэжээ. Монголын соёл шашны голомт болсон 700 гаруй сүм хийдийг устгав.

**Сурвалж-2:** ... Бүх 767 хүрээ хийдээс эмхэтгэн цэвэрлэж зохих газруудад нь хуваарилан олгосон 724, одоо цэвэрлээгээтэй 6, хуваарилалтад ороогүй 37 болно. Энэхүү цэвэрлэлт ба дусгальтын ажил нь нилээд удаан хугацааны дотор явагдаж өнөөрсөн бөгөөд ийнхүү удааширсан шалтгааныг дурдваас

1. Эл сүм хийдийн доторх бурхан ном буюу элдээ хог новш нь үлэмжхэн их бөгөөд түүнийг эмхэтгэн цэвэрлэхэд түйлийн хүнд учраас
2. Цэвэрлэх устгах зүйлийг олон нийтийн өмнө ил суп задгайгаар устгаж шатаах хийгээд ажиллан суллаж болохгүй дээр орон нутгийн ардууд нь нутгийн бэлчээрийн аясаар хүрээлийг нутагласан газрууд ч байсан учраас зарим нэг цагт ажиллаж болохгүй шалтгаан тохиолдож байсан.
3. Зэс гуулин эдлэл ба аж ахуйн хэрэгслүүдийг нэгтгэн хураамжлах явдалд хөсөг уналгын талаар цаг ямагт боогдож саатаж байсан..."

Шашны хэрэг эрхлэх газрын орлогч дарга тохинуулагч Баярсайханы рапортаас. (1939).

### Зөвхөн их хэлмэгдүүлэлтийн үед 20000 гаруй хүнийг цаазаар авч, 5740 гаруй хүнд янз бүрийн хугацаагаар хориных ял ногдуулжээ.

Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийг гадаад, дотоод хүчин зүйл нөхцөлдүүлсэн юм. Үүнд, өөрийн аюулгүй байдлаа хангах, нөлөөний бүс, түшиц газраа хадгалах, өргөтгөх, үзэл суртлаа дэлгэрүүлэх гэсэн ЗХУ-ын **геополитикийн** ашиг сонирхол гол нөлөө үзүүлжээ. Хэлмэгдүүлэлт нь ангич үзэл онолын мөн чанараас, түүнийг сохроор даган хүлээн зөвшөөрснөөс үүдэлтэй байсан юм.



Зураг 4. Хэлмэгдэгсдийн дурсгалд зориуласан хөшөө

1940-өөд оноос үзэл суртлын ажил бол ангийн тэмцлийн хэлбэр гэх чиг хандлага тогтов. МАХН-ын Төв Хорооноос “Улсын хөгжимт драмын театрын уран бүтээлийн тухай”, “БНМАУ-ын түүх, утга зохиолыг дунд сургуульд зааж байгаа байдлын тухай”, “Ардын унших бичгийн тухай” зэрэг тогтоол гаргаж, олон хүнийг түүх, соёлын өв уламжлалд ангич намч байр сууринаас хандаагүй, үндсэрхэг үзэлтэн хэмээн хэлмэгдүүлжээ. Социалист байгуулалтын үед хэлмэгдүүлэлт нь нам, захиргааны арга хэмжээ авч шийтгэх, хүний нэр төр, нандин чанарыг гутаах, үзэл бодлоор хавчин гадуурхах, нэр хоч өгөх зэрэг олон хэлбэртэй болж үргэлжилжээ.

1. Сэжигтнийг гэмт хэрэг үлдсэн эсэхийг тогтоохдоо хүнлэг бус арга хэрэглэхийн хор уршиг, үр дагаарыг тодорхойлно уу? Тэр үед эрүү шүүлт хэрэглэж байсныг хэрхэн нотлох вэ?
2. Сүм хийдийг устган цэвэрлэх болсны үр дагаарын талаар ямар дүгнэлт хийж байна вэ?
3. Хэлмэгдүүлэлтийн хор уршиг, үр дагаарыг бүдүүвчээр илэрхийлээрэй.
4. Социализмын үеийн хэлмэгдүүлэлтийн хэлбэрүүдийг баримт түшин нэрлэнэ үү. Ямар ялгаатай байсан бэ?
5. Хэлмэгдэгсдийг цагаатгах талаар төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны утга учир юунд оршиж байна вэ?

## 6. Дэлхийн II дайны үеийн БНМАУ, тусгаар тогтнолын бэхжилт

**Халх голын дайны ялалт, ач холбогдол.** 1930-аад оноос дэлхий дахинд эдийн засгийн хямрал гүнзгийрч, зөрчил хурцадсанаас олон улсын байдал ээдрээтэй болж иржээ. Герман, Итали, Японы гурвалсан холбоо бий болсноор дайны шинэ голомт үүсэв. Японы эрх баригчид Азид түрэмгийллээ идэвхжүүлж, 1932 он гэхэд Зүүн хойд Хятад, Өвөр Монгол, Манжуурыг эзэлж **Манжго** хэмээн улс байгуулжээ. 1934 оны эцэс 1935 оны эхээр БНМАУ-ын дорнод хилд Японы цэргийн томхон хүч хуримтлагдаж, Японы аюул бодит зүйл болж иржээ. Ийм нөхцөлд манай улс батлан хамгаалах хүчээ нэмэгдүүлэн бэхжүүлэхэд онцгой анхаарах шаардлага бий болсон байна.

1934 оны дунд үеэс Япон, Манжго-гийн талаас БНМАУ-ын хилийг зөрчих, хилийн харуул руу довтлох, хил орчмын нутгийн хүн ардыг түйвээн дээрэмдэх явдал шатлан өргөжиж, 1935 оны 1-р сард Халхын сумийг цэргийн хүчээр эзлэн авчээ. БНМАУ-ын Засгийн газар цэргийн мөргөлдөөнийг өргөтгөхгүй байх, хилийн будлианыг яриа хэлэлцээний замаар зохицуулах санал тавьж, 1935 оны 6-р сард Манжуур өртөөнд БНМАУ ба Манжго-гийн төлөөлөгчдийн хэлэлцээр эхэлжээ. Гэвч уг хэлэлцээ тодорхой үр дунд хүрээгүй юм. Японы аюулаас сэргийлэх үднээс 1936 оны 3-р сарын 12-нд БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд Харилцан туслалцах Протоколыг Улаанбаатар хотноо байгуулж, “хэрэв энэхүү гэрээ тогтоосон нэгэн этгээдийг цэргийн хүчээр довтолбол бие биедээ элдэв тусламж, мөн цэрэг зэвсгийн тусламж үзүүлэх үүрэг хүлээх”-ээр тогтжээ.

1937 онд БНМАУ-ын Засгийн газрын хүсэлтийн дагуу Зөвлөлтийн цэргийн анги нэгтгэлүүд манай улсын нутагт ирж, тус улсын дорнод хязгаарт байрлав.

**Сурвалж-1:** ... БНМАУ-д манай цэргийг оруулсан, бидний зорилгыг БНМАУ-тай хийсэн Харилцан туслалцах тухай манай гэрээний улс төр, цэргийн ач холбогдоор гэж тайлбарлан таниулах хэрэгтэй. Ингэхдээ дараах зүйлүүдийг анхаарвал зохино. ...БНМАУ-д цэргэг оруулахдаа Монголын булаан эзлэх зорилтыг ч Манжуур, Хятадад цөмрэн орох зорилгыг ч тавиагүй, гагцхүү Японы цөмрөлтөөс БНМАУ-ыг хамгаалах л зорилготой...

И.В.Сталинаас УАХЕГ-ын дарга М.П.Фриновский, Улаан Армиийн Улс төрийн Ерөнхий газрын дарга П.А.Смирнов нарт өгсөн заавраас.

**Протокол.** Хоёр улс хоорондоо харилцан тохиролцсон зүйлсээ бичгээр үйлдэн баталгаажуулсан гадаад харилцаны баримт бичгийн нэгэн төрөл.

1939 оны 5-р сард Япон, Манжго-гийн тал Монгол руу довтлон хилийн зарим нутгийг эзлэн авчээ. Монгол-Зөвлөлтийн цэргийн командлал Халх гол орчимд хүчээ хуримтлуулан 1939 оны 8-р сарын эцсээр дайсны гол хүчийг бут цохижээ. Халх голын дайнд цэргийн техник хэрэгслийн ололтыг ашиглах, турших ажил хийгдсэн ба хоёр талаас 130 гаруй мянган хүн оролцож, 1000 гаруй танк, 800 гаруй хуягт машиныг хэрэглэжээ. Энэ дайнд Япон, Манжго-гийн талаас 48 мянга гаруй, Монгол, Зөвлөлтийн 26 мянга орчим хүн амь үрэгджээ.

Халх голын дайнд ялагдал хүлээсэн, нөгөө талаар гол холбоотон Герман улс 1939 оны 8-р сарын 23-нд ЗХУ-тай Харилцан үл довтлох гэрээ байгуулсан нь Японы Засгийн газрыг хэлэлцээний ширээний ард суухаас аргагүй болгов. ЗХУ, Япон хоёр 1939 оны 9-р сарын 16-нд байлдааны ажиллагааг бүрэн зогсоох гэрээ байгуулснаар Халх голын дайн дуусчээ. Эдүгээ Халхын голын дайныг дэлхийн II дайны эхлэл байсан гэж үзэж байна. Энэ ялалт нь ЗХУ, фашизм, милитаризмын хүчтэй хоёр фронтод тулгарах аюулыг зайлзуулж, гол анхаарлаа өрнөдөр тавих цэрэг-улс төрийн ашигтай нөхцөлийг бүрдүүлсэн юм.



Милитаризм. Цэргийн хүчин чадлаа нэмэгдүүлж, түүндээ дулдуйдан эдийн засаг, улс төр, үзэл суртлын бодлогоо хэрэгжүүлдэг тогтолцоо.

**Дэлхийн II дайны үеийн БНМАУ.** Нацист Герман Харилцан үлдөвтлох гэрээгээ зөрчин 1941 оны 6-р сарын 22-нд ЗХУ-д гэнэт халдан довтолсноор БНМАУ дэлхийн II дайнд татагдан ороход хүрэв. БНМАУ 1936 оны Харилцан туслалцах Протоколоор хүлээсэн үүргийнхээ дагуу Зөвлөлтийн ард түмэнд бүхий л бололцоогоороо туслахаар шийдвэрлэжээ. Түүнчлэн 1941 оны 11-р сард хуралдсан НТХ-ны бүгд хурал тус улсын улс төр, эдийн засаг, соёл, батлан хамгаалах бүх ажлыг дайны үеийн байдалд захируулан зохион байгуулах шийдвэр гаргажээ.

**Сурвалж-2:** ....1941 онд Монгол Улсын улс ардын аж ахуйн шийдвэрлэгж зорилгууд нь малын тоо толгойг бүхий л аргаар хөгжүүлэх ба ноос үсийг аль болох ихээр цугларуулан явах хийгээд бэлтгэх зорилгууд мөн байсан болой. ...малын тоо толгой ба ноосыг цугларуулан авах явдлыг нэмэгдүүлэх явдал болбоос Монголын улс ардын аж ахуйд ихээхэн ач холбогдолтойгоос гадна юуны урьд фронтод туслалцах бололцоог нэмэгдүүлнэ.

МАХН-ын Төв Хорооны бүгд хурлын тогтоолоос. (1941.11.20).



1940-1990 он хүртэлх 50 жилийн хугацаанд БНМАУ-ын малын тоо толгой 20-иод саяд хэлбэлзэж байв. Хамгийн олон малтай байсан ўе нь 1941 онд малын тоо толгой 27,5 саяд хүрсэн бол хамгийн цөөн тооны малттай байсан нь 1945 онд 20 сая болж хорогджээ. Энэ нь 1944-1945 оны мичин жилийн зүднаар бараг 4 сая мал үхэж, дайны жилүүдэд хүнс тэжээлийн зүйлс дутагдаж байсан тул 5,9 сая малыг махны хэрэглээд зарцуулсан, өмнөх оноос 2 сая төл дутуу бойжуулсан зэрэгээш шалтгаалжээ.

Дайн үеийн хүндрэлийг давах гол нөөц нь мал аж ахуй байв. Дайны үеийн нөхцөл байдалтай уялдан малаа ёсгөх, ашиг шимийг нь бүрэн ашиглахад чиглэсэн олон арга хэмжээ авав. Малчид 1941 оноос ноос, 1944 оноос махыг улсад албан журмаар нийлүүлэх болж, ердийн хөсгөөр улсын ачааг албан журмаар тээвэрлэдэг болов. Малчдын санаачилга зүтгэлийг үнэлэх, туршлагыг нь дэлгэрүүлэх зорилгоор **Сайн малчдын улсын зөвлөгөөн** хийв. Дайны жилүүдэд ЗХУ-д нийлүүлсэн мал 2 илүү дахин, ноос бараг 2 дахин нэмэгджээ.

Дайны жилүүдэд импорт 2 дахин багасч, өргөн хэрэглээний болон хүнсний бараа ховордов. Тиймээс ард иргэдэд хүртээмжтэй олгох, үнийн хөөрөгдлөөс сэргийлэх үүднээс барааг картаар хуваарилах болжээ. Улс, хоршооплын байгууллагууд дотоод нөөц бололцоогоо ашиглаж цай, тамхи, чүдэнз, саван зэрэг өргөн хэрэглээний бараа, тэрэг, тоног төхөөрөмж, газар тариалангийн багаж сэлбэг хэрэгсэл зэрэг 60 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг шинээр үйлдвэрлэсэн байна. Улаанбаатарт гурилын үйлдвэр, аймгуудад хүнсний комбинат, гурилын тээрэм, сумдад сүү тосны завод байгуулжээ. Үйлдвэрийн газрууд, ажилчдын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, туршлага, шинэ санаачилгыг дэлгэрүүлэх зорилгоор 1943 онд **Тэргүүний ударник нарын зөвлөгөөн** зохион байгуулав.

Дайны жилүүдэд соёл, гэгээрлийн салбарт багагүй ахиц гарчээ. 1941 оноос сургалтыг **кирилл үсгээр** явуулж эхэлсэн бөгөөд нэг бичиг үсэгтэн гурван хүнд шинэ үсэг заах хөдөлгөөн өрнүүлэв. Гэгээрлийн салбарт гарсан хамгийн том дэвшил бол 1942 онд **МУИС-ийг** байгуулсан явдал юм. Тайз, дэлгэцийн урлагийн хөгжлийг “Мандухай сэцэн хатан”, “Амарсанаа” зэрэг жүжиг, “Сүхбаатар”, “Цогт тайж” кино илтгэн харуулна. 1941 онд улсын цирк нээгдэж, анхны тогтолцоо хийжээ.

Дайны эхэн үеэс Улаан армид туслах бүх нийтийн хөдөлгөөн орон даяар өрнөв. Ард олны санаачилгыг дэмжиж, Улаан армид бэлэг хуримтлуулах, фронтод бэлэг хүргэх ажлыг удирдан зохион байгуулах **Бэлэглэлийн төв комиссыг** 1941 оны 9-р

сард Засгийн газрын дэргэд, тэрчлэн аймаг хот, сум бүрд салбар комисс байгуулав. Үйлдвэр аж ахуйн газар, хөдөлмөрчид илүү цагаар ажиллах, амралтаа эдлэхгүй хөдөлмөрлөх, төлөвлөгөө нормоо давуулан биелүүлэх, хөрөнгө материал хэмнэх, тусгай захиалгат зүйлийг үйлдвэрлэх зэргээр ажиллаж байлаа.

БНМАУ өөрийн хөрөнгөөр байлдааны зэвсэг техник ЗХУ-д захиалан хийлгэж бэлэглэх явдал тусlamжийн нэг гол хэлбэр болсон юм. "Хувьсгалт Монгол" танкийн бригад, "Монгол Ард" нисэх онгоцны эскадрилийн дайчдын хоол хүнс, хувцас хэрэглэлийн зардлыг манай тал дайндуустал бүрэн дааж байв.

Тусlamжийн өөр нэг хэлбэр нь Улаан армийн хэрэгцээнд шилдэг сайн агт морьдоор тусалж байсан явдал юм. Манай малчид дайны жилүүдэд ЗХУ-д нийтдээ хагас сая шахам агт морьдыг худалдаж, 32,5 мянган морь бэлэглэсэн байна. Мөн чөлөөлөгдсөн нутгийг сэргээн босгох, Улаан армийн офицер байлдагчдын ар гэрт туслах, шархадсан цэргүүдэд бэлэг, дулаан хувцас явуулах ажил өрнөж байлаа.

Дайны жилүүдэд монголчууд фронтод найман удаагийн бэлгийн цуваа хүргэж, олон зуун сая төгрөгийн үнэ бүхий мал, эд материалын зүйлийг Зөвлөлтийн ард түмэнд өгч тусалжээ. Ийнхүү БНМАУ нь дэлхийн II дайнд шууд оролцоогүй боловч, гүн ар тал болж, фашист Германыг бут цохих үйлсэд өөрийн хувь нэмрийг оруулсан билээ.



1. Зөвлөлтийн тал БНМАУ-д цэргээ оруулах болсон гол учир шалтгаан нь БНМАУ-ыг Японы аюулаас хамгаалах гэдэгтэй Та санал нийлэх үү? Та ямар гаргалгаа гаргаж хийж чадах вэ?
2. Дайны үеийн нөхцөл байдал нь Монголын нийгэм-эдийн засгийн амьдралд ямар нөлөө үзүүлсэн бэ?
3. Дайны жилүүдэд малын тоо толгой өсөөгүй шалтгааны талаар өөрийн бодлыг бичнэ үү.
4. БНМАУ Зөвлөлтийн ард түмэнд бүх талаар тусалсны учир шалтгаан, ач холбогдлыг дүгнэн тодорхойлоорой.
5. Монгол бичээс халсан нь соёлын ололт мөн үү? Яагаад шинэ үсэгт шилжих болсон бэ?

**БНМАУ Японы эсрэг дайнд оролцсон нь:** 1945 оны 5-р сарын 9-нд нацист Герман буун өгч, Европт энх амгалан байдал тогтов. Гэвч Ази тивд Германы холбоотон милитариист Япон дайныг үргэлжлүүлэхийг эрмэлзсэн хэвээр байлаа. ЗХУ, Ялтын бага хурлаар хүлээсэн үүргээ биелүүлэн 8-р сарын 9-нд Японд дайн зарлав. БНМАУ ч энэ үйл хэрэгт өөрийн хувь нэмрээ оруулах, тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хангах үүднээс 8-р сарын 10-нд Японд мөн дайн зарлажээ. БНМАУ Японы эсрэг дайн зарлахдаа ах дүү Өвөр Монголын ард түмнийг чөлөөлөн нэгтгэх эрмэлзэл дүүрэн байгаагаа илэрхийлэв.

**Сурвалж-3:** ...Монгол ах дүү нараа, ...эдүгээ алдар гавьяат улаан цэрэг нь Ази тивийн ард түмэнд амгалан тайван байдлыг тогтоон, агуу их Монголын ард түмнийг нэгдүүлж, тэдэнд үндэсний эрх чөлөө олгох, тусгаар тогтносон улс гэр болгохын тулд Ниппоны булаан эзлэгчдийн өмнөөс шударга дайны илд мэсийг өргөв...

БНМАУ-ын Засгийн газраас Өвөр монголчуудад хандсан уриалгаас.

Х.Чойбалсан, Ж.Лхагвасүрэн нарын удирдсан МАХЦ-ийн анги нэгтгэл Өвөр Байгалийн фронтын баруун жигүүр болж, Долоннуур-Жэхэ, Чуулалт хаалганы чиглэлд давшин байлджээ. Монгол-Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлэг Японы хамгаалалтын шургуу эсэргүүцлийг дарж, томхон хот сууринг эзлэн авчээ. Жанчхүүгийн давааны бэхлэлтэд болсон 8-р сарын 21-ний өдрийн ширүүн тулалдаанд Л.Аюуш, Д.Данланваанчиг нарын БНМАУ-ын баатрууд төрөн гарчээ. Японы эсрэг дайнд МАХЦ-ийн 21 мянган цэрэг дайчид оролцон их элсэн манхан,

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БНМАУ-д СОЦИАЛИЗМ БАЙГУУЛАХ ОРОЛДЛОГО (1924-1990)

усгүй цөлийг даван туулж 950 км давшиж ялалт байгуулсан юм. Өвөр Монгол, Хятадын чөлөөлөгдсөн нутгийн ард иргэд Зөвлөлт, Монголын дайчдыг халуун дотноор угтан авчээ.

1945 оны 9-р сарын 2-нд Япон үг дуугүй бууж өгөх актад гарын үсэг зурснаар дэлхийн II дайн дуусчээ. Энэ дайнаар хувь заняны эрхээр хагацан салсан ах дүү монголчууд нэгдэн нийлэх түүхэн бололцоо олдсон ч их гүрнүүдийн тохиролцоогоор шийдэгдэлгүй үлдджээ. БНМАУ нацист Герман, милитарист Японы эсрэг шударга тэмцэлд оролцон Холбоотны үүргээ нэр төртэйгээр биелүүлсэн юм.

**БНМАУ тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа баталгаажуулсан нь:** 1945 оны Ялтын бага хурал дээр ЗХУ, Их Британи, АНУ-ын удирдагчид “**Гадаад Монголын статус КВО**”-г хүлээн зөвшөөрөх тохиролцоонд хүрчээ. 1945 оны дундуур ЗХУ, Бүгд Найрамдах Хятад Улс (БНХУ)-ын хооронд хэлэлцээр болж, Монголын ард түмэн тусгаар тогтонох эрмэлзлээ санал хураалтаар нотлон харуулбал Хятадын Засгийн газар одоогийн байгаа хил хязгаарын хүрээнд Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөр тохиролцжээ. УБХ-ын Тэргүүлэгчид 1945 оны 9-р сарын 21-нд БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай бүх нийтийн санал хураалт явуулах тогтоол гаргажээ.

**Статус-кво.** Латин хэлний “Status-quo” буюу “оршин байгаа байдал” гэдэг үгнээс гаралтай. Тухайн мечид бодит байдал дээр тусгаар оршин байгаа байдлыг төр засаг, нутаг дэвсгэрийн хэмжээнд хүлээн зөвшөөрөх утга агуулга илэрхийлдэг.

**Сурвалж-4:** 1. БНМАУ-ын сонгуулийн эрх бүхий бөгөөд 18 насанд хүрсэн тус улсын харьяат эрэгтэй, эмэгтэй бүх ард иргэд саналаа гаргана. Зөвхөн ухаан солио хүмүүс үүнд оролцохгүй.

3. Ийнхүү санал гаргуулах ажлыг анхлан баг, хорьдоор явуулж, дараагаар нь түүний дүнг сум хороо, аймаг хот, улсын хэмжээгээр нэгтгэн гаргана...

6. ...сонгогчдын нэrsийн жагсаалтад багтсан ард иргэн бүхэн санал гаргах өдөр тийнхүү санал гаргах газраа биеэрээ хүрэлцэн ирж өөрийн нэрийн дор “зөвшөөрсэн”, “татгалзсан” хэмээх хүснэгтийн нэгэнд гарын үсгийг зурснаар саналаа илэрхийлнэ.

БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний санал гаргуулах ажлыг явуулах тухай зааираас. (1945).

1945 оны 10-р сарын 20-нд орон даяар болсон бүх нийтийн санал хураалт БНМАУ-ын эрх чөлөө тусгаар тогтнолын баярын өдөр болж өнгөрчээ. Санал хураалтад сонгуулийн насны иргэдийн 98.4 хувь буюу 487.409 хүн оролцож, бүгд тусгаар тогтнолын төлөө саналаа өгчээ. Санал хураалтыг Хятадын Засгийн газрын төлөөлөгчид ажигласан бөгөөд 1945 оны 11-р сарын 10-нд УБХ-ын Тэргүүлэгчид санал хураалтын дүнг ЗХУ, Хятадын Засгийн газарт албан ёсоор хүргүүлсэн юм. Гоминданы Засгийн газар санал хураалтын дүнтэй танилцаад 1946 оны 1-р сарын 5-нд БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, улмаар мөн оны 2-р сарын 13-нд дипломат харилцаа тогтоожээ. БНМАУ хоёр хөрш улстайгаа дипломат харилцаа тогтоосноор тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа **де-юре** баталгаажуулж, олон улсын тавцан дээр гарч ирэх өргөн бололцоо нээгдэв.

**Де-юре (de-jure).** Хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн тэх утгатай, нэг улсыг нөгөө улс нь албан ёсоор хүлээн зөвшөөрч оршин тогтнож буйг илэрхийлэх хэлбэр.

1. Монголын түүх бичлэгт 1945 оны Японы эсрэг дайныг яагаад Чөлөөлөх дайн хэмээн нэрийддэг талаар өөрийн санал бодлоо бичнэ үү.
2. 1945 онд БНМАУ Японд дайн зарласны зорилго юу байсныг дүгнэн ярилцаарай.
3. Бүх нийтийн санал хураалтын ач холбогдлыг дүгнэн тодорхойлоорой.
4. Бүх ард түмний санал хураалт сонгуулийн ямар зарчмаар явагдсан бэ?

## 7. БНМАУ-д социализм байгуулах оролдлого

**Нийгэм журамд орох зорилт дэвшүүлсэн нь.** БНМАУ-ын улс төр, нийгэм эдийн засгийн амьдралд гарсан өөрчлөлтөөс үүдэн улс орны хөгжлийн үр дүнг нэгтгэн дүгнэх, дараагийн шатны бодлого зорилт, улс төрийн чиг шугамаа тодорхойлох шаардлага тулгарав. 1939 оны эцсээр маршал Х.Чойбалсан Москвад очиж нам, улсын их хурлын бэлтгэлийг хангах, МАХН-ын шинэ мөрийн хөтөлбөр, дүрэм, шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах зэрэгт дэмжлэг үзүүлэхийг Зөвлөлтийн талаас хүсчээ.

1940 оны 3-р сард МАХН-ын Х их хурал хуралдаж, МАХН-ын шинэ мөрийн хөтөлбөрийг батлав. Их хурал БНМАУ “хөрөнгөтний бус хөгжлийн зам дээр баттай зогссон” гэж дүгнэж, намын цаашдын зорилго бол “эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцсэн хувьсгалыг туйлд хүргэх”, “нийгэм журамд орох бэлтгэл үндсийг хангах явдал мөн” гэж заажээ. МАХН-ын шинэ мөрийн хөтөлбөрт намын удирдан зохион байгуулах ролийг дээшлүүлэх, марксизм-ленинизмийг өөрийн үйл ажиллагаанд удирдлага болгон явуулахаар заав. Их хурал “мал аж ахуйг хөгжүүлэх нь МАХН-ын эн тэргүүний гол зорилтуудын хамгийн чухлын нэг нь болно” хэмээгээд, малын тоо толгойг 200 саяд хүргэх зорилт тавьжээ. МАХН-аас ойрын ирээдүйн зорилт бол улс ардын аж ахуйг хөгжүүлэх, ард олны аж байдлын түвшинг тасралтгүй дээшлүүлэх, хүн ардын боловсролын хэмжээг дээшлүүлэх явдал гэж үзсэн байна. Тус их хурлаас МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалыг шинээр бий болгож, Ю.Цэдэнбалыг сонгожээ.

**Сурвалж-1:** БНМАУ-ын бодлого тус орны эдийн засагт байгаа феодализмын үлдэгдлүүдийг бүрмэсэн устгаад, хүн амын мэдрэлд байгаа феодализмын үлдэгдлүүдтэй тэмцэж улмаар нийгэм журамд орох явдлыг бэлтгэхийн тулд тус орныг капиталын ёсны бус замаар хөгжүүлэх явдлыг хангахад чиглэгджээ.

БНМАУ-ын ойрын жилүүдэд тавих үндсэн бөгөөд шийдвэрлэх зорилгууд бол... тус оронд мал аж ахуй, аж үйлдвэр, тээврийн явдлыг хөгжүүлэх, түүнээс капиталын ба мөлжигч этгээдүүдийг хязгаарлан зайлцуулах, хөдөлмөрчин олны аж байдлыг тасралтгүй дээшлүүлэх, түүнчлэн тус оронд шинжлэх ухаан ба техникийг бүхий л аргаар хөгжүүлэх, хүн ардын үсэг бичиг ба боловсролыг дээшлүүлэхэд оршино.

МАХН нь марксизм-ленинизмийн сургаалыг гагцхан зөв шинжлэх ухаан гэж батлан үзэж өөрийн ажилд удирдлага болгон явуулж, Монголын ард түмний тэмцлийг чиглүүлнэ.

МАХН-ын мөрийн хөтөлбөрөөс. (1940).

1940 оны 6-р сард БНМАУ-ын VIII Их Хурал хуралдав. Их Хурлын хэлэлцсэн нэг гол асуудал бол БНМАУ-ын **шинэ Үндсэн хууль** байв. Үндсэн хуулийн төслийг бүх ард түмнээр хэлэлцүүлж, хөдөлмөрчдийн саналыг тусгажээ. Төлөөлөгчид, БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж, 1940 оны 6-р сарын 30-ны өдөр санал нэгтэй батлав. Үндсэн хуульд улс орны хөгжлийн зорилт, онцлог, мөн чанарыг шинээр тодорхойлжээ.

**Сурвалж-2:** “БНМАУ бол эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан, цаашид нийгэм журамд давшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин ардын тусгаар тогтносон улс мөн болно” гэж заажээ.

БНМАУ-ын Үндсэн хуулиас. (1940)

Дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд чиглэсэн зарим алхмуудыг эхлүүлсэн боловч дэлхий дахин, бүс нутагт бий болсон нөхцөл байдал, түүний дотор тус улстай харилцаатай байсан цорын ганц орон болох ЗХУ дэлхийн II дайнд татагдан орсны улмаас энэ үйл явц хэсэг хугацаанд удааширан юм.

- 1. БНМАУ-ын хөгжлийг нам, улсын их хурлаас хэрхэн дүгнэсэн бэ?
- 2. МАХН яагаад марксизм-ленинизмыг гол үзэл онолоо болгосныг тухайн үеийн нэхцэл байдалтай холбон тайлбарлаарай.
- 3. БНМАУ-д социализм байгуулахад юу саад болж байна гэж үзэж байсан талаар бодлоо бичнэ үү.
- 4. Нийгэм журамд хүрэхийн тулд хөрөнгөт бус хөгжлийн замаар замнах тухай МАХН-ын бодлого хэр үндэстэй болох талаар санаал бодлоо илрэхийлээрэй.

**Төлөвлөгөөт хөгжлийн эхлэл.** 1941 оноос БНМАУ-ын улс ардын аж ахуй, соёлыг нэг жилийн төлөвлөгөөгөөр хөгжүүлж эхэлжээ. Эдийн засгийн төлөвлөлт нь нийгмийн үйлдвэрлэл, хэрэглээг төрөөс л зохицуулах зарчимд үндэслэж байв. Улмаар 1947 онд МАХН-ын XI их хурлаас улс ардын аж ахуйг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөний удирдамжийг батлав. Энэхүү төлөвлөгөө нь олон хэвшилт эдийн засгийг төлөвлөрсөн төлөвлөгөөний үндсэн дээр удирдан зохицуулах гэсэн анхны оролдлого байсан юм. Анхдугаар таван жилийн төлөвлөгөөнд БНМАУ-ын эдийн засаг, үйлдвэрлэх хүчинийг хөгжүүлэх, мал сүргийн тоог 31 саяд хүргэх, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнийг 96,8 хувиар өсгөх зорилт дэвшүүлжээ.

Таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ олон нийтийн идэвх санаачилгыг өрнүүлж, улсын үйлдвэр, аж ахуйн газруудын дунд уралдаан зохиох зэрэг хэлбэрийг өргөн ашиглах болов.

ЗХУ-ын тусламжаар Налайхын нүүрсний уурхай, Төв цахилгаан станц, Аж үйлдвэрийн комбинат, Мебелийн үйлдвэрийг өргөтгэн, Бүрэнцогт, Түмэнцогт, Чупуунхороот, Цэнхэрмандалд хувь нийлүүлсэн уул уурхайн үйлдвэр, Зүүнбаянд нефтийн үйлдвэр, Наушк-Улаанбаатарын 400 орчим км урт төмөр замыг байгуулжээ. Аймгуудад авто бааз байгуулгаждаж, ачаа, зорчигч тээвэрлэлт сайжирчээ. Аймгийн төвүүдийг цахилгаанжуулж, аймгийн төвийг нийслэл, сумтай холбосон телефон харилцаатай болов.

Зураг 5. Төмөр замын нээлт. (1949.11.7).



1950-иад онд Монголын улс төр, нийгмийн амьдралд томоохон өөрчлөлт гарлаа. 1952, 1953 онд Х.Чойбалсан, И.Сталин нар дараалан таалал төгссөн нь улс төрийн шинэ нэхцэл байдлыг бий болгов. ЗХУ-ын дотоодод гарсан өөрчлөлт, социалист систем бүрэлдэн тогтсон явдал Монголын нийгмийн амьдралд ихээхэн нөлөө үзүүлжээ. Монголд **үндэсний сэхээтний** нэгэн шинэ уе буй болж, тэдний дундаас төрөн гарсан анхны эрдэмтэд (Н.Жагварал, Д.Төмөр-Очир, Л.Цэнд) Монгол орны хөгжлийн чиг хандлага, социализм байгуулах онолын үзэл баримтлалыг дэвшүүлэх болсон байна.

1954 онд хуралдсан МАХН-ын XII их хурал БНМАУ-ын түүхэн хөгжлийн асуудлаар хэд хэдэн дүгнэлт хийв.

**Сурвалж-3:** ... Манай хувьсгалын нийт ардчилсан зорилтыг 1940 оны үед үндсэнд нь шийдвэрлэсэн юм. Манай орон барагцаалахад, тэр үеэс эхлэн социалист хөгжлийнхөө шатанд орж, феодалыг эсрэгүүцсэн хувьсгал социалист хувьсгал болон шилжиж эхэлсэн юм. Манай орон, хувьсгалын хөгжлийн социалист шинэ шатанд ормоогц, социализмыг дэлгэрэнгүй байгуулах эд материалын ба соёлын урьдчилсан нэхцэлийг хангахын тулд ихээхэн цаг шаардагдах юм. Манай нам эдгээр эд материалын ба соёлын урьдчилсан нэхцэлийг бий болгохын тул ажиллаж үрсэн, ажилласаар ч байна...

...БНМАУ-д социализм байгуулах явдал бол манай намын жанжин шугам мөн. Манай оронд социализм байгуулах явдал бол улс ардын нийт аж ахуйд социалист үйлдвэрлэлийн харилцаа, ялж, эцэст нь бүх мөлжигчдийг устгах, аливаа мөлжлэг, түүнийг үүсгэх бүх шалтгааныг устгах явдал мөн..."

МАХН-ын XII их хуралд тавьсан Төв Хорооны тайлан илтгэлээс. (1954).

Их хурал "Монгол ардын хувьсгал нь хоёр үе шатыг дамжин хөгжиж байна, эхний шат нь 1921-1940-өөд оны хүртэл үеийг хамрах хувьсгалын арчилсан шат, хоёрдугаар шат нь 1940 оноос одоог хүртэл үргэлжилж байгаа социалист хувьсгалын шат болно" гэж дүгнэв.

1940-өөд оноос манай орон хөрөнгөт бус хөгжлийн замаар замнаж, улмаар социализмд шилжих түүхэн шилжилтийнхээ үед байна гэж тунхаглах болов. МАХН үндэсний аж үйлдвэрийн хөгжлийн явцад **ажилчин ангийн** манлайлах үүрэг өсч, ажилчин, малчны холбоо бэхжиж байгаа нь социализм байгуулах чухал нөхцөл гэж үзэж байлаа. Монголд хүнд үйлдвэрийн бүх салбарыг заавал хөгжүүлэх бус ЗХУ болон социалист орнуудын тусламжид түшиглэн социализмын материаллаг суурийг тавьж болох бөгөөд хөнгөн аж үйлдвэрийн салбарыг урьдаар хөгжүүлэхээр заажээ.

Ийнхүү намын XII их хурлаас социалист байгуулалтыг шууд практик зорилт болгон тавьжээ. Тухайн үед "социализмыг дэлгэрэнгүй байгуулах" хэмээх ойлголтыг хувийн өмчийг устгаж, нийгмийн өмчийн үнэмлэхүй нöёрхлыг тогтоох явдал гэж үзэж байсан учраас ардын хувийн аж ахуйтныг хоршоолох нь хойшлуулшгүй зорилт гэж тус их хурал онцлон заасан юм.

-  1. Социализмыг дэлгэрэнгүй байгуулах тухай үзэл баримтлал хэдий үеэс эхтэй болохыг баримтаар нотол.
- 2. Сурвалж 1,2,3-ыг харьцуулан судалж, ялгааг нь тодорхойлно уу. Тэдгээрээс ямар мэдээлэл олж авсан бэ?
- 3. Мөлжлөгийг устгахын тулд нийгэм улс төрийн ямар бодлогыг авч хэрэгжүүлэх нь зохицтой гэж үзэж байсан бэ? Та юу гэж бодож байна?
- 4. Улс орны хөгжлийг шатлан хуваасан нь хэр зохицтой вэ? Энэ нь хэр үндэслэлтэй вэ?

**БНМАУ дахь социалист байгуулалт.** Социалист хөгжлийн шинэ үеийн агуулга, тухайн нөхцөлд намаас баримтлах бодлого чиглэлийг тодорхойлоход 1961 онд хуралдсан МАХН-ын XIV, 1965 оны XV их хурал гол үүрэг гүйцэтгэжээ.

1960 оноос манай орон өөрийн хөгжлийн шинэ үе, социалист нийгмийг байгуулж дуусгах үедээ орсон гэж тунхаглав. Энэ үеийн үндсэн гол зорилт бол социализмын материал техникийн баазыг байгуулах ажлыг бүхий л талаар гүнзгийрүүлэн дуусгах явдал гэж үзэж байлаа. Энэ зорилтыг хангаснаар БНМАУ аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болж, социализмыг бүрэн байгуулна гэж төлөвлөж байв.

**Сурвалж-4:** БНМАУ-д социализм байгуулж дуусгах үед МАХН-аас тавих гол зорилт бол орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшилтийн ололтыг үндэс болгож, социалист нийгмийн үйлдвэрлэх хүчинийг бүхий л талаар хөгжүүлэх, тус орны эдийн засгийн хүч чадал, социалист соёлыг түргэн хурдацтай өрнүүлэх, нийгмийн социалист харилцааг боловсронгуй болгох, хөдөлмөрчдийг коммунист ёсоор хүмүүжүүлэх ажлыг хүчтэй болгох улмаар ард түмний аж амьдралын байдал, соёлын хэмжээг цаашид дээшшүүлэх явдал мэн.

Энэ үеийн эдийн засгийн гол асуудал бол улс орноо цаашид үйлдвэржүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг механизмуулах, улс ардын аж ахуйн бүх салбарын техник хангамжийг дээшшүүлэх зэрээр социализмын материал техникийн бааз байгуулж дуусах явдал мөн МАХН-ын IV программаас. (1966).

МАХН-ын IV программд, социалист байгуулалтын энэ шатанд тавих гол зорилт нь нэгд, социализмын материал техникийн бааз байгуулж дуусгах, хоёрт, нийгмийн социалист харилцааг боловсронгуй болгох, гуравт, хөдөлмөрчдийн коммунист хүмүүжлийг хүчтэй болгох явдал гэж заажээ.

**Социализмын материал техникийн бааз** байгуулах асуудал улс орныг үйлдвэржүүлэх явдалтай салшгүй холбоотой хэмээн МАХН үзэж байлаа.



Гэхдээ хөнгөн хүнсний болон түлш эрчим хүчиний үйлдвэрлэлийг түрүүлэн хөгжүүлэх зорилт дэвшүүлж, энэ хүрээнд 1966-1982 онд төвийн эрчим хүчиний нэгдсэн системийг бий болгожээ. Улаанбаатар хотын IV цахилгаан станцыг шинээр барьж, I, III станцад өргөтгөл хийв. Налайх, Шарын голын уурхайг шинэтгэн, Багануур болон Адуунчуулуун, Таван толгойн нүүрсний орд газрын цогцолборыг шинээр нээжээ. 1976 оноос олон улсын геологийн экспедиц БНМАУ-д ажиллах болж, олон орд газруудыг нээсэн бөгөөд үүний үр дүнд Дархан, Эрдэнэт, Багануур, Бор-Өндөр, Хөтөл зэрэг аж үйлдвэрийн шинэ төв үүсч, үйлдвэрийн бүтэц, байршилд томоохон өөрчлөлт гарав.

Үйлдвэрийн хотууд шинээр байгуулагдсан нь барилгын үйлдвэрлэлийн хөгжилд нөлөөлөв. Бүх төрлийн тээвэр хөгжиж, ачаа эргэлт нэмэгдлээ. Салхит, Эрдэнэт, Мааныт, Багануурын төмөр зам, төмөр замын барилга байгууламж ашиглалтад орсноор төмөр замын урт нэмэгдэв. 1980-аад онд нийт 200 орчим хот, суурин хоорондоо агаарын харилцаатай болж, зорчигч, шуудан тогтмол тээвэрлэхээс гадна түргэн тусламжийн нислэг хийдэг болжээ. Улсын холбооны нэгдсэн систем байгуулагдаж, 1967 оноос Монголд үндэсний телевизийн нэвтрүүлэг эхлэв. Албан баримтаар, 1980-аад оны дунд үе гэхэд аж үйлдвэр, нийгмийн нийт бүтээгдэхүүний 48 хувь, үндэсний орлогын 34 хувь, хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн нийлсэн бүтээгдэхүүний 75 хувийг үйлдвэрлэж байжээ. Аж үйлдвэрийн салбарт ЗХУ-ын тусламжаар байгуулсан үйлдвэрүүд голлох үүрэг гүйцэтгэж байлаа.

МАХН-ын их хурлууд, ТХ-ны бүгд хурлаар үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн техник баазыг өргөтгэн бэхжүүлэх зэрэг зорилт дэвшүүлж байсан нь улс орныг үйлдвэржүүлэх үндсэн чиг шугам болж байв. МАХН улс орныг аж үйлдвэр, хөдөө аж ахуйн срон болгох асуудлыг томъёолоходоо үйлдвэржүүлэлтийн түвшинг тодорхойлох шалгуурыг оновчтой сонгож чадаагүй бөгөөд үндэсний орлогын 50-аас дээш хувийг аж үйлдвэрийн салбар бүтээдэг болсон цагт энэ зорилт хангагдана гэж үзэж байв. Түүнчлэн үйлдвэрлэлийг импортлох буюу хөдөлмөрийн социалист хуваарыт оролцох замаар улс орныг хөгжүүлнэ гэж тунхаглаж, БНМАУ-д хүнд үйлдвэржүүлэлт шаардлагагүй гэсэн зарчим барьж байв. Энэхүү өрөөсгөл бодлогын уршигаар Монголын аж үйлдвэрийн цар хүрээ хязгаарлагдмал, хөнгөн хүнсний салбар зонхилсон, салбарын бүтэц явцуу хэвээр үлдجээ.

**Сурвалж-5:**...манай зорилт нь социалист үйлдвэржүүлэлтийн процессыг цаашид гүнзгийрүүлэхэд оршиж байна. Энэ зорилгоор хүнд аж үйлдвэр, түүний дотор түүлш, эрчим хүч, уул уурхай, меттал болоевсруулах салбарын хамгийн ашигтай цогцолборыг хөгжүүлэх нь чухал байна. Үйлдвэржүүлэлтийг эрчимжүүлэх яедал машини болон химиин аж үйлдвэрийн зарим төрлийн үйлдвэрлэлийг бий болгож хөгжүүлэхтэй бас холбоотой... Эдгээр зорилтыг хэрэгжүүлсэнээр эсийн дунд БНМАУ-д социализмын материал техникийн бааз байгуулж дуусах зорилтод хүрэх бөгөөд ингэснээрээ манай орон хөгжингүй социалист нийгэм байгуулах түүхэн үедээ аажмаар шилжин орох нөхцөлийг хангах болно.

МАХН-ын XVIII их хуралд тавьсан Төв Хорооны тайлан, илтгэлээс. (1981).

1980-аад оны сүүлч гэхэд улс орны хөгжлийн хурдац саарч, гадаад өр нэмэгдэж, хөгжлийн тэнцвэр алдагдаж иржээ. Төсвийн алдагдал 20 гаруй хувьд хүрч, үйлдвэрлэлийн салбарын уялдаа, тэтгэн дэмжих чадвар сульдаж, ЗХУ-аас эдийн засгийн хувьд хараат улс болсон байв.

1. Сурвалж 4,5-ыг уншин харьцуулж, нийтлэг болон ялгаатай зүйлсийг тодорхойлно уу.
2. МАХН-ын программд социализм байгуулж дусгах зорилтыг тунхаглахдаа шийдвэрлэх гол зорилтыг юу юу гэж заасан талаар дүгнэж бичээрэй.
3. БНМАУ нь аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болох зорилтыг хангах гол шалгуур нь юу байсан, дээрх зорилтоо хангаж чадсан эсэхийг нотлоорой.
4. Зураг-6-г ажиллан өөрийн орон нутгийт ямар үйлдвэр байгуулагдсан болон хөнгөн хүнсний үйлдвэрүүдийн өнөөгийн байдал, ач холбогдлыг үнэлээрэй.

## 8. БНМАУ-ын нийгэм-эдийн засагт гарсан өөрчлөлт

**Улс төр, нийгмийн амьдрал.** 1956 оны ЗХУКН-ын ХХ их хурал “Нэг хүнийг тахин шүтэх явдал, түүний үр дагаврын тухай” асуудал хэлэлцэж шийдвэр гаргасан нь МАХН-ын удирдлагад зохих нөлөө үзүүлэв. 1956 оны НТХ-ны IV бүгд хурлаар Х.Чойбалсанг тахин шүтэж байсан болон хууль ёсыг ноцтой зөрчиж, үй олон хүнийг хэлмэгдүүлсэн явдлыг анх удаа албан ёсоор хэлэлцэн шүүмжилсэн билээ. Тус хурлаас нэг хүнийг тахин шүтэх явдлын уршгаар хууль ёсыг ноцтой зөрчсөн асуудлыг хянан шалгахыг Улс Төрийн Товчоонд даалгажээ. Ингэснээр олон түмэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж нээгдэж, нийгэм улс төрийн амьдрал идэвхжсэн байна. Олон түмний санал шүүмжлэлийг сонсох ажлыг Улс Төрийн Товчооноос зохион байгуулав. Гэвч энэ явдал нь эрүүл саруул үзэл бодол, чөлөөт шүүмжлэлт уур амьсгалыг үгүй хийхэд чиглэгдсэн, сэхээтнүүдийн амьг барьж, дуулгавартай байлгах гэсэн дарамт шахалтын шинжтэй үйл явдал болон хувирчээ. 1956 оны 12-р сарын 5-нд “Манай намын бодлогод харш үзэл санаа, уг өгүүлэл гарч байгаа тухай” тогтоол гаргав. Сэхээтний доторх шүүмжлэлт уур амьсгалыг “сэхээтний төөрөгдөл” гэж нэрлэв.

МАХН-аас хувийн өмчийг үгүйсгэн нийгмийн өмчийг тулгаж, нэг үзэл суртлыг тунхаглах болсноор улс төр-эдийн засаг, үзэл суртлын хүрээнд төвлөрөл

хүчтэй болж, **авторитар дэглэм** тогтох нөхцөл бүрдэв. 1960-аад оноос БНМАУ-ын улс төрийн тогтолцооны цөм нь МАХН болов. МАХН, үзэл онол үйл ажиллагааныхаа үндсийг марксизм-ленинизм хэмээн тодорхойлж, түүнийг нийгмийн бүх хүрээнд тулган хүлээлгэв. МАХН нийгмийн оюун санааны амьдралыг бүхэлд нь хянах тогтолцоог бий болгож, ангич намч, **пролетарийн интернационалч** зарчимд үнэнч байх үзэл суртлын хатуу шалгуурыг тулгаж байлаа. МАХН төр, олон нийтийн

 Зарим сэхээтэн жижиг хөрөнгөтний үзэл санаанд автагдан үзэл суртлын талаар төөрөлдөж, намын бодлогод харш уг яриа гаргасан гэж буруушааж үүний шалтгааныг тэдний улс төр, ононы мэдлэг нимгэн, амьдрал практикаас тасархай, үзэл суртлын хатуужил суугаагүйгээс болсон гэж үзсэн байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БНМАУ-д СОЦИАЛИЗМ БАЙГУУЛАХ ОРОЛДЛОГО (1924-1990)

байгууллагын дотоод хэрэгт шууд оролцож, хууль хяналтын гадна орших болсноор хүнд сурталт, захиран тушаах арга барил бүрэлдэн тогтжээ.

- **Сурвалж-1:** - Ш.Бат-Очир (Эрдэм шинжилгээний ахлах ажилтан): 1953 оноос хойш том аж ахуйтнууд цөөрч иржээ. Манайд ардын аж ахуйтны дотор аж ахуйн ялгавар гарах нь зайлшгүй болоч том хөрөнгөтнүүд болж хувирах нь юу л бол. ...Энэ талаар намаас явуулж буй бодлого хэр зүйтэй вэ? ...Санаалаа чөлөөтэй тавихыг дайсны санаа юм шиг ойлгодог талыг аль болохоор болих юм сан. Чөлөөтэй санаалыг хөгжүүлэх талаар хяналт их байгаа... онолын асуудлыг чөлөөтэйгээр тавиад олон нийтээр шүүмжлүүлж буруушаагдаж байж уг санал маань зөвөө олмоор байдаг.
- Б.Бирваа (Эрдэм шинжилгээний ахлах ажилтан): Сонгууль ихээхэн ёс төдий болж ардчиллыг зөрчиж гарч ирж байна. Сонгуулийг ард нь танихгүй мөртөө сонгож байна. ...Сантмаргац сумас Их Хурал депутат байгаа хүн нь юу ч мэдэхгүй хүн. Одоо махкомбинат дээр ажилладаг юм байна. Ард түмэндээ тус болохоор хүмүүсийг орон нутагт нь ойрыг харгалзан олж авах нь чухал.
- П.Лхамгав (Эрдэм шинжилгээний ахлах ажилтан): Сонгуулийн талаар хөдөө орон нутагт их чирэгээл болгож байна. Олон газраас хүн ард эрт босож хавчилгын журмаар шахам ирж санаалаа өгдөө. Манай сонгууль шууд гээдээ. Гэтэл үнэндээ олон шамттай байна. Засгийн газрын бүрэлдэхүүн ба Улс Төрийн Товчоог шууд сонгодог байх.

МАХН-ын Төв Хорооны дэргэдэх

Намын түүхийн институтын ажилтнуудын санал шүүмжлэлээс. (1956).

**Эдийн засагт гарсан өөрчлөлт.** БНМАУ-д социализм байгуулж дуусгах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хөдөө аж ахуйг шинээр зохион байгуулах шаардлага урган гарч иржээ. МАХН, **ардын аж ахуйтны** дунд хөрөнгө чинээний ялгаа их, мөлжлэгийн элемент байгаа, иймд нийгмийн өмч бий болгож нэгнээ мөлжих явдлыг устгах ёстой хэмээн тунхаглаж байв. Тиймээс ардын аж ахуйг “эдийн засаг дахь феодализмын үлдэгдэл”, “эрчимгүй бүдүүлэг, хоцрогдсон” аж ахуй хэмээн тодорхойлж, түүнийг өөрчлөхгүйгээр ард олны амьдрал ахуйг сайжруулж чадахгүй гэх үзэл санааг сурталдаж байв.

1958 онд МАХН-ын XIII их хурал, хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулах нөхцөл нэгэнт хангагдсан гэж дүгнээд “...ойрын гурван жилд ардын аж ахуйтны ихэнхийг сайн дурын зарчмын үндсэн дээр хоршоолон нэгтгэх нь зүйтэй” гэсэн шийдвэр гаргажээ. Малчин ардуудын зэрэгцээгээр хувийн мал аж ахуйтай байсан ажилчин албан хаагчид хүртэл малаа нийгэмчилсэн байна. 1959 оны 6-р сард Хөдөө аж ахуйн нэгдлийн шинэ Үлгэрчилсэн дүрмийг баталж, нэгдлийн гишүүдийн аминд үлдэх малын тоог хангайд 50,.govьд 75 толгойгоор тогтоов. Улмаар нэгдлийн гишүүдийн амины малыг дахин нийгэмчлэх ажлыг улс даяар богино хугацаанд явуулж 1959 онд үндсэндээ дуусчээ. Мөн онд нэгдлүүдийг томруулан нэгтгэж оны эцэст 389 нэгдэлтэй болж, нэг нэгдэл дунджаар 43 мянган малтай болсон байна.

1960-аад оноос Монголд нийгмийн өмч ноёрхож улс, хоршооллын гэсэн хоёр хэлбэрээс бүрдэх болжээ. Төрөөр хэлбэл, улсын эдийн засаг терийн өмч дангаар зонхилох болсон байна. Нийгмийн үйлдвэрлэл, хэрэглээг тэр зохицуулах зарчим үйлчилж байв. Тиймээс энэ үеийг төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үе гэж нэрлэдэг.

1979 онд нэгдэлжих хөдөлгөөн ялсны 20 жилийн ойн үеэр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал хөдөөгийн жижиг үйлдвэрлэгчдийг хоршоолох замаар социализмд дэвшүүлэн оруулах үйл хэргийг амжилттай шийдвэрлэсэн нь БНМАУ ба Монголын ард түмний амьдралд ач холбогдоороо 1921 оны ардын хувьсгалтай тэнцэхүйц үлэмжхэн түүхэн үйл явдал болсон гэх дүгнэлт хийж байв.

Энэ үеийн мал сүргийн тоо үндсэндээ нэг хэмжээнд байсан бөгөөд 1960 онд улсын бүх малын тоо 23 сая байсан бол 1990 онд 23.1 сая болжээ.

**Сурвалж-2:** "... Хүн бүр бага балчраасаа эхлэн туйлын аж ахуйч, арвич хямгач, социалист өмчийн эс ширхэг бүрийг алхам тутамдаа нүдлэн хамгаалагч, хөдөлмөрийг бишрэн шүтэгч байх ёстой".

"... Хир буртаг өчүүхэн ч хүргэхгүй нандигнан хайлаж, тахин шүтэж байх зүйл маань нэгдүгээрт нийгмийн өмч, хоёрдугаарт социалист өмчийг цогцлоон бүрдүүлэгч эх үүсвэр болсон ариун цагаан хөдөлмөр мөн".

МАХН-ын Төв Хорооны тогтоолоос. (1979).

1958 онд газар тариаланг өргөн далайцтай хөгжүүлэх шийдвэрийг МАХН-ын XIII их хурлаас гаргажээ. **Атрын анхдугаар аяны** үр дүнд 1959-1960 онд 286 мянган га атар газар хагалж, 256.5 мянган тонн үр тариа, 18.5 мянган тонн төмс, 6.9 мянган тонн хүнсний ногоо, 34.4 тонн тэжээлийн ургамал хураан авч, газар тариалан бие даасан салбар болон хөгжив. Ийнхүү манай улс олон үеийн турш газар тариалангийн бүтээгдэхүүнийг гол төлөв гадаадаас авдаг хэрэглэгч орон байснаа үйлдвэрлэн бүтээгдэхүүнийг гол төлөв гадаадаас авдаг хэрэглэгч орон жилүүдэд нэг га талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх бус харин тариалах талбайг нэмэгдүүлэх бодлого голлон барьж байлаа. Атар газар эзэмших ажил жил тутам нэмэгдсээр 1975 онд 510 мянган га-д хүрсэн байна. 1976 оноос атар газар эзэмших II аяныг явуулж, газар тариалангийн үйлдвэрлэл хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 30 гаруй хувийг эзлэх болов.

Социализмын жилүүдэд Монголчуудын аж амьдрал, соёлын түвшинд томоохон өөрчлөлт гарчээ. Үүнд: **соёлын довтолгоо** чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд түүний үрээр иргэншсэн ертөнцийн ахуйн соёл хэвшин тогтсон билээ.



1. Сурвалж 1-ийн мэдээнд тулгуурлан сэхэээтнуудээс гаргасан санал хэр үндэслэлтэй болохыг тайлбарлана уу.
2. Сурвалж 2-ын мэдээнд тулгуурлан яагаад социалист өмчийг социалист нийгмийн оршин тогтнох үндэс гэж үзэх байсныг дүгнээрэй.
3. МАХН нийгмийн харилцааг боловсронгуй болгох зорилтдоо юу юу хамааруулж байсныг ангилж бичэрэй.
4. Хүнд сурталт захиран тушаах дэглэм тогтох болсны шалтгааныг хэрхэн дүгнэж байна вэ?
5. Социалист байгуулалтын жилүүдэд хувийн өмчийг хориглосон талаар ямар дүгнэлт хийж болох вэ?
6. Ардын аж ахуйтныг хоршоолох нь социалист нийгэм байгуулах зорилтой хэрхэн уялдаж байсныг баримтаар батална уу.
7. Атар эзэмшиж, газар тариалангийн үйлдвэрлэл хөгжүүлсний ач холбогдолыг үнэлзэрэй.

## 9. БНМАУ-ЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН, СОЁЛЫН ХӨГЖИЛТ

**Боловсролын салбарын хөгжил.** 1960-аад он гэхэд боловсролын нэгдсэн тогтолцоо бүрэлдэж, хүн амын ерөнхий боловсролын түвшин дээшлэв. 1966 онд бүх хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн, шинэ системд шилжих төслийг боловсруулжээ. Сургуулийн бүтцийг 3+5+2 болгон өөрчилснөөр 1972 оноос бүрэн бус дунд боловсролыг 8 жилийн хугацаанд олгох болж, сургуулийн насны бүх хүүхдийг бүрэн бус дунд боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлэв. Бүх нийтийг бичиг үсэгтэй болгох хөдөлгөөн үр дүнгээ өгч, 1970 онд гэхэд хүн амын 89,3 хувь нь бичиг үсэгтэй тайлгаджээ. Үүнийг ЮНЕСКО үнэлж Н.Крупскаягийн нэрэмжит олон улсын алтан медалиар манай улсыг шагнасан юм.

1982 онд БНМАУ-ын **Боловсролын тухай хуулийг** батлан гаргав. 1990 он гэхэд ерөнхий боловсролын 634 сургуульд 440.9 мянган сурагч суралцаж байлаа.

Тусгай мэргэжлийн боловсролын тогтолцоо бүрэлдэн хөгжив. 1970-аад онд Техник мэргэжлийн сургууль (ТМС) олноор байгуулагдаж, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэн гаргах болжээ. Мөн ЗХУ, социалист орнуудын ТМС-д оюутан сургаж байв. Техник мэргэжлийн боловсрол хөгжсөнөөр улс ардын аж ахуйн салбарт ажиллагсдын бүтэц, соёл, техникийн боловсролын түвшинд ахиц гарчээ.


## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БНМАУ-д СОЦИАЛИЗМ БАЙГУУЛАХ ОРОЛДЛОГО (1924-1990)

Дээд боловсролтой боловсон хүчин бэлтгэхэд онцгой анхаарсны дунд 1960 онд их, дээд сургуулиудад 6900 оюутан суралцаж байсан бол 1985 онд 24600 болж өсчээ.

**Шинжлэх ухаан, техникийн хөгжил.** 1961 оны 5-р сарын 17-нд Шинжлэх ухааны хүрээлэнг Шинжлэх Ухааны Академи болгон өөрчлөн байгуулав. ШУА-д байгаль, нийгмийн ухааны суурь судалгааны ажлууд хийгдэж, манай зарим эрдэмтэд судалгааны шилдэг бүтээл түүрвижээ. Малын үүлдэр угсааг сайжруулах, элдэв өвчнийг анагаах чиглэлээр хийсэн судалгааны үр дунд Хангай, Байдраг, Торгууд, Ерөө үүлдрийн хонь, Гурван сайхан үүлдрийн ямаа, Сэлэнгэ үүлдрийн үхэр, Халиун үүлдрийн зөгий зэрэг шинэ үүлдэр гаргав. Үр тариа, хүнсний ногооны шинэ сортыг бий болгов. Олон зүйлийн эм, био бэлдмэл гарган авч, малыг эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, үргжийг идэвхжүүлэхэд хэрэглэжээ.

Монгол орны ургамал амьтны төрөл, зүйлийн судалгаа хийж, ургамал, амьтан, газар нутгийн дархлал, экологийн тэнцвэр хадгалах, Монголын Улаан номыг гаргах, ургамлын өвчин, хортонтой тэмцэх зэрэг ажлууд хийгджээ. Монгол орны геологийн тогтоц, ашигт малтмалын байршлыг тогтоожээ. Эдийн засгийн муж, дэд мужуудыг тогтоож тэдгээрийн хөгжлийн чиглэлийг тодорхойлсон байна.

Олон улсын эрдэмтэдтэй 90 орчим асуудлыг хамтран судалж байсны ихэнх нь сансар судлал, атом, биотехнологи, электроник, био болон нар, салхины эрчим хүчийг ашиглах зэрэг байгаль-техникийн чиглэлийн судалгаа байлаа. Монголын эрдэмтэд сансар судлалын "Интеркосмос" программыг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцож, 1981 онд Монгол хүн сансарт нисэв.



Зураг 7. Сансрын нисгэгч Ж.Гүррагчаа, В.Жанибеков

Нийгмийн ухааны салбараас түүх, хэл, утга зохиол, гүн ухаан, эдийн засгийн асуудлыг түлхүү судалж, олон арван бүтээл гаргажээ. Эдгээрээс хамгийн дорвитой нь "БНМАУ-ын түүх" 3 боть, Монголын гүн ухааны сэтгэлгээний хөгжил, монгол хэлний зүй, үгсийн сан, нутгийн аялгуу, Монголын уран зохиолын түүхэн хөгжил, ардын аман зохиолын төрлийг судалж түүрвисан бүтээл болно.

**Сурвалж-1:** "...Феодалын байлдан дагуулалт, хаад ноёдын хоорондын тэмцлийг хэт тоочин, түүхийг бүтээгч ард түүний роль, ангийн тэмцлийг угүйсгэсэн байна... "БНМАУ-ын түүхийн дээж бичиш" хятадын сурвалж бичгээс 120 гаруй ишлэл авсан атлаа марксизм-ленинизмыг үндэслэгэдийн зохиол бүтээлээс нэг ч ишлэл авч тусгаагүйн дээр ардын хувьсгалын түүхийн баримт бичиг, БНМАУ-ын түүхийн гурван боть зохиол зэрэг чухал сурвалж материалаас 20 гаруйхан ишлэл оруулсан нь эмхтгэгчид [Г.Сүхбаатар, Л.Жамсран] Хятадын дарлагч ангийн эрх ашигийн хамгаалсан хуучин сурвалж бичгийг түүхэн үнэ цэнтэй зүйл мэтээр товоойлгосныг харуулж байна..."

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Төвчооны тогтоолоос. (1980).

**Урлаг, уран сайхны хөгжил.** Урлаг, утга зохиол шинэ төрөл зүйлээр баяжиж, театр жүжгийн зохиолын хөгжилтэд ахиц гарлаа. 1960-аад оноос хойш Монгол кино үйлдвэр жилд дунджаар уран сайхны бүрэн хэмжээний 7-8 кино, баримтат кино 100, түүний дотор кино мэдээ 24-ийг бүтээж байв. 1988 онд "Мандухай сэцэн хатан" кино дэлгэцнээ гарсан нь манай кино урлагийн түүхэнд томоохон үйл явдал байлаа.

Дан хөгжмийн зохиол, уламжлалд тулгуурласан үндэсний болон сонгодог хөгжмийн зэмсэгт зориулсан бүтээлүүд олноор гарчээ. Бүжгийн жүжиг үндэсний болон сонгодог чиглэлээр хөгжив. Улсын дуурь бүжгийн театр байгуулагдсанаас хойш үндэсний болон дэлхийн сонгодог бүжгийн жүжиг 30 орчмыг найруулан тавьжээ.

Зургийн урлаг нь хөрөг, монгол зураг, тосон будаг, зураасан зураг, зурагт

хуудас, тайзны чимэглэл, хулдаасан ба чулуун бар зэрэг олон арга хэлбэртэй хөгжсөн байна. Уран барималчид баримал, хөшөө, дурсгалын багана, цогцолбор бүтээж иржээ. Д.Чоймболын “Сүхбаатарын хөшөө”, Зайсан толгой дахь Монгол-Зөвлөлтийн дайчдын дурсгалын цогцолбор зэргээр уран баримлын хөгжлийг баримжаалж болно. Түүнчлэн үзэл сурталд нийцээгүй гэх нэрийдлээр уран бүтээлчдийг буруутгах явдал байсаар байв.

**Сурвалж-2:** “...сүүлийн 2-3 жилд манай зарим зураач үзэл сурталгүй бүтээл гаргах, хөрөнгөтний урлагийн хэлбэрдэх арга барилыг дуурайсан хийсвэр зураг зурсан нь уран бүтээлийн зарим ажилтан харш үзэл суртлын нөлөөнд ямар нэг хэмжээгээр автагдсаныг гэрчлэх баримт мөн...”  
МАХН-ын Төв Хорооны тогтоолоос. (1969).

1960 онд биеийн тамир, спортыг хөгжүүлэх, спортын клуб, нийгэмлэгүүдийн материаллаг баазыг бэхжүүлэх, ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт биеийн тамирын хичээлийг үзэх зэрэг шийдвэр гаргажээ. 1962 онд Монголын Биеийн тамир спортын эвлэл Олон Улсын Олимпийн Хороонд элсч, Токиогийн зуны XVIII олимп, Инсбургийн өвлийн IX олимпийн тоглолтод оролцжээ. 1968 оны Мехикогийн олимпийн тоглолтоос Ж.Мөнхбат мөнгө, Ч.Дамдиншарав, Д.Сэрээтэр, Т.Артаг нар хүрэл медаль хүртсэн нь Монгол Улсын олимпийн анхны медаль байсан юм. Үүний зэрэгцээгээр хүйтэн дайны жилүүдэд социалист лагерийн орнуудтай нэгдмэл байр суурьтай байх үүднээс Олимпийн тоглолтод оролцохоос хүртэл татгалзаж байсан тохиолдол бий.

**Сурвалж-3:** “АНУ-ын эрх баригчид ... Олимпийн хартийг зөрчих явдлаа үргэлжлүүлж, Олимп-84 зохион байгуулах хорооны үйл ажиллагааг гартаа оруулж аваад, Зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг хэнээрхэл дээгдээж, зусэн зүйлийн хэт харгис, алан хядагчдын бүлэглэл, дээрэмчдийн хэрцгий бүдүүлэг дайралт, дайсагнасан ажиллагааг илэрхий өөгшүүлэн дэмжих байна. Тэдэээр даварсан бүлэглэлийн зүгээс социалист орны тамирчдын амь биед халдахаар шууд заналхийлж байна... БНМАУ-ын Үндэсний Олимпийн Хороо олимпийн тоглолтын талаар бий болсон нөхцөл байдалгүй тал бүрээс нь судлаад Лос-Анжелост болох XXIII олимпийн тоглолтод Монголын тамирчид оролцож боломжийг гэж үзэж байна...”

Монголын Үндэсний Олимпийн Хорооны мэдэгдлээс. (1984).



1. Сурвалж -1,2-ыг судлаад эрдэмтэд, уран бүтээлчдийг юуны учир буруутгасан, тэр нь хэр үндэслэлтэй болох талаар өөрийн зүээс үнэлэлт дүгнэлт хийж танилцуулараай.
2. Ангич, намч ба пролетариин интернационалын зарчимд үнэнч байх гэдэг нь ямар утгатай болохыг судлан тайлбарлана уу.
3. Дээрх зарчимд харш үзэл санаа бүхий бүтээл туурвисан бол ямар шийтгэл оноож байсныг баримтаар тодруулаарай.
4. Нийтээрээ бичиг үсэгтэй болсон давуу талыг тодорхойлоорой.
5. Сурвалж-3-т тулгуурлан БНМАУ Лос-Анжелосын зуны олимпод оропдоогүйн шалтгааныг тайлбарлаарай.

## 10. БНМАУ-ын гадаад харилцаа

Дэлхийн II дайны дараа ЗХУ, АНУ-ын ашиг сонирхол мөргөлдөж эхэлснээр хүйтэн дайны үе эхлэв. Харин 1960-1970-аад оны зааг үеэс намжмал байдал буюу харилцан ойлголцохыг эрхэмлэх болсон юм. Энэ үеийн БНМАУ-ын гадаад бодлого нь ЗХУ, социалист системийн орнуудтай найрамдал, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, нийгмийн өөр байгуулал бүхий орнуудтай энхтайвнаар зэрэгцэн орших үндсэн дээр хэвийн харилцааг хөгжүүлэх, олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход чиглэж байв. Өөрөөр хэлбэл, манай улсын гадаад бодлого нь ЗХУ-ын гадаад бодлогыг аялдан дагалдсан буюу дэлхийн улс орнуудыг нийгмийн байгууллаар

Хүйтэн дайны үе. Дэлхийн II дайны дараа нэг талаас ЗХУ тэргүүтэй социалист системийн орнууд, нөгөө талаас АНУ тэргүүтэй өрнөдийн капиталист орнуудын хооронд сергөлдхөж, дайсагнах харилцаа бий болсон үе.

нь ялгаварлан харилцах, үзэл сурталжсан шинжтэй байжээ.

Тус улсын гадаад бодлогод ЗХУ ба БНХАУ-тай тогтоосон харилцаа гол байр эзэлж байв. 1946 оны 2-р сард ЗХУ-тай Найрамдал харилцан туслалцах тухай гэрээ (20 жилийн хугацаатай) байгуулж, 1949 онд хоёр орны хооронд худалдааны хэлэлцээрт гарын үсэг зуржээ. ЗХУ-ын удирдагч Н.С.Хрущев, Л.И.Брежнев нар БНМАУ-д айлчилсан нь хоёр орны харилцаанд тохиосон том үйл явдал байв. Социалист байгуулалтын жилүүдэд ЗХУ-аас үзүүлсэн тусламж, зээлийн дунд манай улсын хөгжилд зохих ахиц дэвшил гарсан хэдий ч тус улсын хараат байдалд улам бүр орсоор байв. 1980-аад оны сүүлч гэхэд БНМАУ 20 гаруй улс оронтой худалдааны харилцаатай байснаас экспортын 73 хувь, импортын 82 хувийг ЗХУ дангаараа эзэлж байв.

1949 онд Хятадад ардын хувьсгал ялснаар БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтов. Хоёр улсын харилцаа өргөжиж, хилийн тухай гэрээ байгуулжээ. Гэвч 1960-аад оноос зарим бэрхшээл тулгарч, харилцаа “хүйтэрчээ”. Энэ нь ЗХУКН, ХКН-ын зөрөлдөөнд МАХН нь Зөвлөлтийн талыг илтэд баримтлах болсон, нөгөөтэйгүүр Хятадын талаас БНМАУ-ыг дайсагнасан шинжтэй өдөөн хатгалга, суртал нэвтрүүлэг явуулах болсонтой холбоотой юм. 1966 онд ЗХУ өөрийн аюулгүй байдлаа хангах, БНМАУ-тай байгуулсан гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт цэргээ оруулан байршуулжээ. Гэхдээ БНМАУ, БНХАУ-ын харилцаа дипломат шугамаар үргэлжилсээр байсан юм. 1980-аад оноос хоёр талын хучин чармайлтаар нааштай хандлага гарч, Монгол, Хятадын харилцаа хэвийн болох үндэс суурь тавигджээ.

1948-1950 онд БНМАУ **социалист системийн** орнуудтай дипломат харилцаа тогтоож, улс төр, эдийн засаг, соёлын харилцаагаа өргөжүүлэв. 1962 онд ЭЗХТЗ-д гишүүнээр элсэн, гишүүн орнуудтай хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зээл тусламж авч байв. Гадаад худалдааны хүрээ хэмжээ өсч байгааг харгалзан 1958 онд Худалдааны яамны Гадаад худалдааны газрыг яам болгон өргөтгөн зохион байгуулжээ.

 **Социалист систем.** Дэлхийн II дайны дараа Зүүн Европын Албани, Болгар, Унгар, Зүүн Герман, Польш, Румын, Чехословак, Югослав, Азийн Вьетнам, Хятад, Умард Солонгос зэрэг орнууд социализмын замаар замнах болсоор үүссэн тогтолцоо. 1980-аад оны сүүлч гэхэд манай гарагийн нутаг дэвсгэрийн 26,2 хувь, хүн амын 32,3 хувийг хамарч байлаа. 1990-ээд оны эхэр энэ систем задарч оршин тогтохоо болжээ.

**Сурвалж-1:** “БНМАУ бол дэлхийн социалист системийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн... ЗХУ болон социалист бусад орны ард түмэнтэй тогтоосон ах дүүгийн эвдэршгүй найрамдал, нэгдэл, дэлхийн социалист системийн ард түмний нягтралыг шийдвэртэй хамгаалж байнга бэхжүүлэхийг МАХН интернационалч ариун үүргээ гэж үзэж байна. ...МАХН бол олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн...”

МАХН-ын IV Программаас. (1966).

БНМАУ-ын гадаад бодлогод гуравдагч ертенц буюу хөгжиж буй орнууд гэгдэх Ази Африк, Латин Америкийн орнуудтай харилцах харилцаа зохих байр эзэлж байсан юм. Дэлхийн II дайны дараа Ази, Африкийн олон оронд эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж, Энэтхэг, Индонез, Алжир, Конго зэрэг олон улс тусгаар тогтнолоо олжээ. 1945-1953 онд Ази, Африкт шинэ тулгар 15 улс бий болсны олонх нь манай улстай дипломат харилцаа тогтоов.

БНМАУ, дэлхийн II дайнд Холбоотны эгнээнд баттай зогссон нь НҮБ-ын гишүүн орон байх нөхцөлийг бүрдүүлэв. Тиймээс НҮБ-ын дүрмийг зөвшөөрч, түүний гишүүн болох хүсэлтээ БНМАУ 1946 оны 6-р сард анх гаргасан юм. Гэвч

Тайвань болон түүнийг ивээн дэмжигч өрнөдийн зарим улс БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөгдөөгүй, ЗХУ-ын дагуул орон, гадаад бодлогын туршлага дадлагагүй, энх тайванч бус улс гэх зэргээр хавчин гадуурхсаар тус улс 15 жилийн турш НҮБ-д элсэж чадаагүй юм. 1961 оны 10-р сарын 27-нд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолын төслийг 9 улс дэмжиж, 1 улс түдгэлэнснээр БНМАУ НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болжээ. Манай улс НҮБ болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болов. Монгол Улсын санаачилгаар дэлхий дахинд намжмал байдал тогтоох, цөмийн зэвсгийг хорогдуулах зэрэг асуудлаар НҮБ хэд хэдэн тогтоол гаргасны дотор 1984 онд “Улс түмний энх тайвнаар орших эрхийн тунхаглал” баталжээ. Тийнхүү БНМАУ улс түмний энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоохын төлөө тэмцэлд идэвхтэй оролцож иржээ.



Зураг 8. БНМАУ НҮБ-д элсэж төрийн далбаагаа мандуулав.

БНМАУ, НҮБ-д хууль ёсны байраа эзэлснээр Өрнөдийн улс орнууд БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох боломж нээгджээ. БНМАУ 1963 онд Австри, Их Британи, 1965 онд Франц, 1972 онд Япон, 1974 онд ХБНГУ-тай дипломат харилцаа тогтоов. Гэхдээ энэхүү харилцаа нь үзэл суртал, улс төрийн шалтгаанаар хязгаарлагдмал шинжтэй байсан юм.

Монгол Улс АНУ-тай дипломат харилцаа тогтоох талаар 1960-аад оноос эхлэн хэд хэдэн удаа оролдсон боловч хэрэгжилгүй 1980-аад онтой золгосон юм. Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудал олон жил хойшлогдож, 1987 онд сая хэрэгжжээ.

**Сурвалж-2:** “А.А.Громыко: Бид энэ асуудлаар жилийн өмнө ярилцсан санагдаж байна. Ямар чиг байсан Цэдэнбал, Брежнев хөёрыг уулзак ярилцах үед бид саналаа хэлсэн. Тэр байр суурь өөрчлөгдөөгүй, хэвээрээ байгаа шүү. АНУ-тай харилцаа тогтооно гэдэг чинь тун төвөөгтэй асуудал. ...Тэдний санаархал тун өөр. Тэд танайд тагнуулын цэгтэй болох гэж чармайж байгаа юм. Тиймээс л харилцаа тогтоох гэж яарсны хэрэггүй...”

БНМАУ, ЗХУ-ын ГЯЯ-ны сайд нарын ярианы тэмдэглэлээс. (1976).

Гадаад худалдааны хувьд, Монголын экспортод мал аж ахуй, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зонхицлаж байжээ. Экспортын барааны 42 хувийг малын ноос, ноолуур, 33 орчим хувийг мал, мах эзэлж байв. Зарим жил манай улс гадаадад 70 мянган тонн үр тария, 4-5 мянган тонн цөцгийн тос, загас экспортолжээ. Харин импортын 55,5 хувийг өргөн хэрэгцээний бараа, 45,5 хувийг машин тоног төхөөрөмж, бусад зүйл эзэлж байв. Экспорт, импортын бүтэц, хувь хэмжээ 1970-аад оны сүүлчээс эхлэн нэлээд өөрчлөгдсөн нь Эрдэнэт комбинат, жоншины үйлдвэр, ноос ноолуур, арьс шир боловсруулах, нэхмэл сүлжмэл, савхи, нэхий эдлэлийн зэрэг олон шинэ үйлдвэр ашиглалтад орсонтой холбоотой байв.



1. Хүйтэн дайн Монголд хэрхэн нөлөөлснийг зэрэгцүүлэн тайлбарлаарай.
2. БНМАУ-ын гадаад харилцаа хязгаарлагдмал шинжтэй байсны учир шалтгаан юу байв?
3. Социалист орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааны мөн чанарын талаар үзэл бодлоо илэрхийлнэ үү.
4. АНУ-тай дипломат харилцаа тогтоох гэсэн БНМАУ-ын саналыг Зөвлөлтийн тал яагаад зөвшөөрөхгүй байсныг хэрхэн тодорхойлох вэ?
5. БНМАУ-ын гадаад бодлогын гол ололт юу байсан бэ? Социалист байгуулалтын жилүүд дэх манай гадаад бодлого ямар сургамжийг бидэнд үлдээсэн бэ?

## IV бүлэг. МОНГОЛ УЛС АРДЧИЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН ЗАМААР (1990 оноос хойш)

1989 он	1990 он	1991 он	1992 он	2006 он
МОАХ байгуулагдав.	Монголд анх удаа чөлөөт, ардчилсан сонгууль явагдав.	Өмч хувьчлал эхлэв.	Шинэ Үндсэн хууль батлагдав.	Их Монгол Улсын 800 жилийн ойг тэмдэглэв.



- Социалист байгуулалт яагаад мухардалд ороход хүрэв?
- 1990 оны хувьсгал нийгмийн хэрэгцээ шаардлага байв уу? Тохиолдлын хэрэг байв уу?
- 1990 оны хувьсгалын дараа Монголын нийгэмд ямар, ямар өөрчлөлт гарав?

### 1. 1990 оны ардчилсан хувьсгал: өрнөл, ялалт, ач холбогдол

1990 оны Ардчилсан хувьсгалаар Монгол Улсын түүхэн хөгжлийн нэгэн шинэ үе эхэлсэн билээ. Тэрхүү хувьсгалын үндэс, шалтгаан чухамдаа социалист байгуулалтын явцад хуралдан боловсorchээ. БНМАУ дахь социалист байгуулалт 1980-аад оны дунд үе гэхэд **мухардмал байдалд** оров. Бусад социалист орнуудын хувьд ч нөхцөл байдал мөн адил байлаа.

1956 онд Унгаркт, 1968 онд Чехословакт, 1970-аад онд Польшид коммунист дэглэмийг эсэргүүцсэн тэмцэл хөдөлгөөн гарч байв. Түүнийг ЗХУ-ын шууд оролцоотойгоор, хүчирхийллийн аргаар нүхчин дарсан юм.

Үүнд олон шалтгаан, хүчин зүйл нөлөөлжээ. Нэг намын дарангуйлал, захиран тушаах дэглэм ноёрхож, ардчилал, хүний эрх, эрх чөлөө тунхаглал төдий оршиж байлаа. Марксизм-Ленинизмийг цорын ганц зөв онол хэмээн тулгаж, сэтгэлгээний эрх чөлөө, олон ургалч үзлийг хаан боогдуулж байв. Иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрхийг хавчин хяхаж, үндэсний өв уламжлалаа өнгөрсөн нийгмийн үлдэгдэл хэмээн хялайж байв. Зөвхөн улсын буюу **НИЙГМИЙН ӨМЧИЙГ** хүлээн зөвшөөрч, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо ноёлж, эдийн засгийн бүхий л харилцааг дээрээс удирдан жолоодож байв. Нийгмийн баялгийг тэгшигтэн хуваарилах зарчим үйлчилж байв.

МАХН 1986 оноос төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгох зорилт дэвшүүлсэн боловч ЗХУ-ыг харж хүлээсэн идэвхгүй байр суурь баримталж байлаа. Тиймээс сэхээтэн zaluuучуудын дунд 1989 оноос "**Шинэ үе**", "**Орчлон**", "**Ертөнц**" зэрэг нууц бүлгэмүүд байгуулагдаж, үйл ажиллагаа явуулах болов.

**Сурвалж-1:** "...бид нийт zaluuучуудад хандан нийгэмд ээлэх байр сууриа эргэцүүлэн бодож улс орон, ард түүний маань цээдүүн хувь заяаг шийдвэрлэх өөрчлөн байгуулалтад бодитой хувь нэмэрээ оруулан хүнд суртлын эсрэг шийдвэртэй тэмцэхийг уриалж байна. Өөрчлөн байгуулалтын хувь заяг ардчилал, ил тод байдал, ард олны оюун санааны эрх чөлөө-чөлөөт сэтгэлгээнээс онцгой хамаарах билээ.

... Үзэл бодлын плорализм (олон чиглэл)-ыг албан ёсоор тунхаглаж ардчилал, ил тод байдлыг баталгаатай болгосон хуулийн ойрын хугацаанд боловсруулан бух ард түүнээр хэлэлцүүлэн батлах; НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс 1948 оны 12-р сарын 10-нд баталж гаргасан "Хүний эрхийн бүх нийтийн тунхаглал"-ыг ард олонд таниулсан сурталчилж, амьдралд бүрэн дүүрэн хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхийг zaluuus бид нам засгийн удирдлагаас шаардаж байна".

"Шинэ үе" нууц бүлгэмээс Улаанбаатар хотын гудамж, албан байгууллагуудын үүдэнэ тохиолдлын наасан хуулах бичгээс. (1989.1.2-3-нд шилжих шенэ).

1989 оны 11-р сарын сүүлээр болсон Залуу уран бүтээлчдийн Улсын II зөвлөлгөөний индэр дээрээс zaluuучууд хурц шүүмжлэл өрнүүлэв. 1989 оны 12-р сарын 7-нд Ховд дахь Багшийн Дээд сургуулийн хэсэг zaluuу багш, оюутнууд Монголд анх удаа олон нийтийг хамарсан **УЛС ТӨРИЙН ЖАГСААЛ** цуглаан зохион байгууллаа.



Зураг 1. Улс төрийн анхны цуглаан. УБ хот, Залуучуудын соёлын төв. (1989.12.10.)

Тохиromжтой цагийг товлон хүлээж байсан Улаанбаатарын тэмцэгчид 1989 оны 12-р сарын 10-нд буюу Олон улсын Хүний эрхийн өдрөөр Залуучуудын соёлын төвийн үүдэнд мөн анхны цуглаанаа зохион байгуулав. Энэхүү цуглаан дээр “Хонхны дуу”-г дуулсан нь цаашид ардчилсан хувьсгалын сүлд дуу болсон юм.

Цуглаан дээр **Монголын ардчилсан холбоо** (MoAX) байгуулагдсаныг албан ёсоор зарлажээ. Цуглаанд оролцогчид МАХН-ын ТХ, БНМАУ-ын АИХ-д шаардах бичиг өргөн барив. Энэ бол

MoAX-оос албан ёсоор тавьсан анхны шаардлага байлаа.

■ **Сурвалж-2:** А. БНМАУ-ын Үндсэн хуулинд дараах өөрчлөлтүүдийг оруулах:  
1. Намаас төр, засгийн газрын үйл ажиллагааг шууд удирдан чиглүүлэх... явдлыг зогсоож, ... олон намын систем... зарчмыг хууль эрхийн баталгаатай болгож, АИХ-аас намын тухай хууль боловсруулан гаргах. 2. Хүний эрхийн түгээмэл тунхаглалт тодорхойлсон хүн, ард цргэдийн дархан эрхийг ... дээдлэн хүндлэх зарчмыг... хатуу мөрдүүлэх. 3. ... АИХ-ыг байнгын ажиллагаатай парламентийн хэлбэрт оруулж, түүний дэргэд хүний эрхийг хамгаалах ардын сонгуульт зөвлөл байгуулах. 4. Үндэсний эрх ашигийг хөндсөн... асуудлуудыг бүх ард түүнээр ил тод хэлэлцүүлэх...

Б. Өөрчлен байгуулалт, шиночлэлийг хэрэгжүүлэх үйлсэд дараах арга хэмжээ даруй авах: 1. ... сонгуулийн системийг үндсэнд нь шинэчлэн АИХ-ын... сонгуулийг хуяцаанаас нь өмнө 1990 оны эхний хагас жилд багтаан зохион явуулах. 2. ... социалист зах зээлийн концепцийг боловсруулан бүх нийтээр хэлэлцүүлэх. 3. Банкны сүлжээг өргөтгөн, түүнийг... СНЗ-ийн мэдлээс гаргаж, АИХ-д ажлаа тайлagnадаг эрх бүхий байгууллага... болгох. 4. Хэвлэлийн эрх чөлөөг хуулийн баталгаатай болгох. 5. Тусгай хангамжийг устгах.

В. БНМАУ-ын социалист хөгжлийн замналыг дүгнэн цэгнэхэд: 1. Х. Чойбалсан, Ю. Цэдэнбал нарын үйл ажиллагаа, ... алдаа дутагдлыг нь дэвэргэн гааруулсан тодорхой нэр бүхий эздийг илрүүлж, ард түүнээр шүүн хэлэлцүүлэх... комисс байгуулах. 2. ... газарын дурсгалыг нь мэнжүүлэн хэлмэгдэгсдийн өмнө МАХН алдаагаа хүлээж, ... ар гэрт зохих хохирлыг нөхөн олгох. 3. БНМАУ-ын болон МАХН-ын түүхийг үнэн бодитойгоор шинэчлэн боловсруулах... .

MoAX-ноос МАХН-ын ТХ-ны VII бүгд хурал, БНМАУ-ын АИХ-ын чуулганд өргөн барьсан шаардах бичгээс. (1989.12.10.)

MoAX-ны шаардлагад эрх баригч МАХН тодорхой хариу өгөөгүй тул улс төрийн тэмцэл хөдөлгөөн улам хүчтэй өрнөжээ. Цуглаан жагсаал удаа дараалан болж, ард иргэд улс төрийн тэмцэлд татагдан оров. Ардчилсан Социалист Хөдөлгөөн (АСХ), Шинэ Дэвшилт Холбоо (ШДХ) зэрэг шинэ шинэ холбоод байгуулагдаж, өдрөөс өдөрт эгнээгээ тэлсээр байлаа. Өөрчлөлт шинэчлэлтийг хүссэн олон түмний хувьсгалт давалгаа улам бүр эрч хүчээ авч, оргилон бадарч байлаа. 1990 оны 1-р сарын 21-нд Сүхбаатарын талбайд болсон цуглаанд олон арван мянган хүн оролцсон нь үүний илэрхийлэл юм.

1990 оны 2-р сарын 18-нд анхдугаар их хурал болов. Их хурал **Монголын ардчилсан намыг** (MoAH) эмхлэн байгуулснаа зарлаж, MoAH-ын Мөрийн хөтөлбөр, дүрмийг баталлаа. Мөрийн хөтөлбөрт улс орноо хөгжүүлэх, эдийн засаг, улс төрийн тогтолцоо, оюун санааны салбарт оршиж буй дутагдлыг арилгах, ардчилсан дэг жаягийг тогтоох зэргээр гол зорилтуудаа тодорхойлсон байна. Их хурал Үндсэн хууль, Улс төрийн намын тухай болон Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулах зэрэг олон асуудлыг хөндөн тавьжээ.

Тийнхүү Монголд улс төрийн хоёр дахь нам мэндлэв. МоАХ-ны их хурлаас БНМАУ-ын АИХ, МАХН-ын ТХ-нд өргөн барих бичиг гаргав.

- Сурвалж-3:** 1.Эрх баригч НТХ-ноос шууд томилогдсон, ард түмний итгэл найдварыг биелүүлж чадахгүйгээ нэгэнт харуулсан Сн3-ийг огцруулж, АИХ-ыг тараах.
   
2.Засаг төрийн бүх эрхийг гартаа авч ард түмний эрх ашигт харш бодлогоо муйхраар үргэлжлүүлэн, хувьсгалт өөрчлөн байгуулалтыг хазаарлан барьж байгаа өнөөгийн НТХ-г огцруулж хэмжээгүй эрх мэдлийг нь халах.
   
3.Засгийн бүх эрхийг гартаа авч, улмаар улс орны хувь заяагаар тоглон, хөдөлмөрчдийг ядуу зүдүү амьдралд байлган, нийгмийн өмчийг бүрэлгэн сүйтгэж, эдийн засгаа их өрөнд унаган доройтуулж, өөрсдийн эрх ямбаар ард олноо золисолсон этгээдүүдийн хэргийг нийт ард түмний онц зөвлөлөөр шалган шууж яллах.
   
4.Ард түмнээсээ нүүж, тэдний дархан өмч болсон Монгол орны эд хөрөнгө, үнэт баялагийг хойч үеийнхэндээ үлдээхгүй тонон дээрмэдэх бодлого, үйл ажиллагааг таслан зогсоож, Мардайн ураны, Эрдэнэтийн зэсийн, Заамарын алтны, Асгатын мөнгөнний үүрхайнуудыг нэн даруй хааж, цаашид газрын баялагийг ашиглах асуудлыг бүрэн эрхт цорын ганц эзэн-нийт ард түмнээр хэлэлцүүлж шийддэг журам тогтоохыг тус тус шаардаж байна”.

МоАХ-ны I их хурлаас БНМАУ-ын АИХ, МАХН-ын ТХ-нд өргөн барих бичгээс.



Зураг 2. “Ялалт” кино төатрын өмнөх талбайд Ардчилсан 4 хүчиний хамтран зохион байгуулсан өргөн олны цуглааны нэгээхэн хэсэг. (1990.3.4. УБ хот.)

Цуглаанаас МоАХ, АСХ, ШДХ, Монголын Оюутны Холбоо (МОХ) хамтарсан мэдэгдэл гаргав. Түүнд, МАХН-ын Онц их хурлыг хуралдуулж, МАХН-ын ТХ-ны бүрэлдэхүүнийг өөрчилж, намын үйл ажиллагааг төрөөс тусгаарлах, улс төрийн бүх хүчнийг тэгш эрхтэйгээр оролцуулсан Ардын түр хурлыг 3-р сард багтаан байгуулах зэрэг шаардлага тавьжээ. Гэвч эрх баригчдаас хангалттай хариу авч чадсангүй. Тиймээс 1990 оны 3-р сарын 7-ны өдрийн 14 цагт МоАХ-ны арван

гишүүн (Э.Бат-Үүл, Д.Батбилэг, Б.Галсандорж, И.Жавхлант, З.Эрдэнэбат, Б.Батцэнгэл, Г.Бошигт, Д.Дорлигжав, Д.Нинж, Д.Энхбаатар) Сүхбаатарын талбайд улс төрийн тэмцлийн хурц хэлбэр болох **өлсгөлөн зарлан** тэмцжээ. Өлслгөлөн гурван өдөр, хоёр шөнө үргэлжлэв. Тэмцлийн энэ хэлбэр олон нийтийг цочирдуулсан хэдий ч ардчилсан хүчиний тэмцлийг ард иргэд бүхэлдээ талархан дэмжиж байлаа. Ардчилсан хувьсгалын үйл хэрэгт тухайн үеийн Монголын нийгмийн бүх давхаргынхан идэвхтэй оролцож, тус тусын хувь нэмрийг оруулсан юм.

Улс төрийн нөхцөл байдал ихээхэн эзгэгтэй болж ирсэн энэ үед Сүхбаатарын талбайд өлсгөлөн зарлагчдаас 3-р сарын 8-ны орой мэдэгдэл гаргав.

“...Намын Төв Хорооны Улс төрийн товчоо (УТТ)-ны гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээрээ нэн даруй огцрохыг шаардаж, УТТ-ны огцрох асуудалтай амь насаараа дэнчин тавьж байгаагаа албан ёсоор мэдэгдэж байна”.

МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүдэд хандан гаргасан мэдэгдлээс.

Эрх баригчдын болон ардчилсан хүчиний төлөөллийн хооронд болсон уулзалт ярилцлагын үр дүнд 3-р сарын 9-ний өдрийн 17 цагт зарчмын тохиролцоонд хүрч, Монголын ард түмний сонорт хүргэх улс төрийн тунхаглал гаргав.



Зураг 3. Өлсгөлөн зарлагчид ба тэднийг дэмжигч олон түмэн. (1990.3.9. УБ, Сүхбаатарын талбай.).

шинэ хүчинүүдтэй хамтран ажиллах, Ардын Түр Хурлыг байгуулахгүй, харин АИХ-ын депутатуудад итгэл хүлээлгэх эсэх талаар бүх ард түмний санал хураалт явуулахаар болсныг дурдаад, жагсаал цуглаан, ялангуяа өлсгөлөнгөө зогсоохыг уриалжээ.



Жамбын Батмёнх  
(1926-1997)

Энэ тухай нам, төрийн тэргүүн Ж.Батмёнх мөн өдрийн орой нийт ард түмэндээ хандан радио, телевизээр мэдээлэл хийв. Энэхүү ухаалаг шийдвэрийн дунд 3-р сарын 9-ний шөнө өлсгөлөн зогссон юм. Сөргөлдөөнөөр биш, **улс төрийн зөвшилцлийн замаар** ямар ч хурц асуудлыг шийдвэрлэх боломжтойг тухайн үйл явдал харуулж, хурцад мал байдал намжив. Энэ бол улс төрийн чухал ач холбогдолтой түүхэн шийдвэр байлаа.

1990 оны 3-р сарын 12-14-нд болсон МАХН-ын бүгд хурлаар УТТ, нарийн бичгийн дарга нарыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулав. Мөн МАХН-ын удирдан чиглүүлэх үүргийн тухай БНМАУ-ын Үндсэн Үндсэн хуулийн заалтаас татгалзах саналыг АИХ-д уламжлахаар шийдвэрлэв.

1990 оны 3-р сарын 22-24-нд хуралсан АИХ-ын чуулган, МАХН бол “төр, нийгмийг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин мөн” гэсэн 1960 оны Үндсэн хуулийн онцгой заалтыг хүчингүй болгов. Тийнхүү БНМАУ-д **нэг намын ноёрхол эцэс болж**, 1990 оны ардчилсан хувьсгалын үндсэн асуудал шийдэгдэв.

1990 оны Ардчилсан хувьсгалын ялалтын үр дүнд Монгол Улс социализмаас ардчилал, чөлөөтзах зээлийн нийгэмд шилжих боломж нээгдэв. Энэхүү шилжилтийг монголчууд хүчирхийллийн бус, **тайван замаар** хийж чадлаа. Хувьсгалын үр дүнд Монголын нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан өөрчлөлт, шинэчлэлт өрнөж, өнөөгийн нийгмийн үндэс суурь тавигджээ. Монголчууд хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ утгаар нь эдлэх болов.

Түүнд, МАХН-ын ТХ-ны УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох саналыг удахгүй болох Бүгд хуралд оруулж хэлэлцүүлэх, МАХН-ын Онц их хурал зарлан хуралдуулах, АИХ-ын ээлжит чуулганы хугацааг нааш нь татахыг хуулийн дагуу шийдэх, МАХН Үндсэн хуулиар баталгаажуулсан эрх дархаасаа татгалзах саналыг АИХ-ын чуулганд оруулах, Үндсэн хуулийг шинэчлэн боловсруулахад улс төрийн



1. 1990 онд Монголд өрнөсөн түүхэн үйл явдлыг “өөрчлөлт шинэчлэлт”, “ардчилсан хөдөлгөөн”, “ардчилсан хувьсгал” гэх зэрэээр харилцан адилгүй ярьж, бичиж байна. Эдээрийн аль нь илүү оновчтой гэж үзэж байна? Үндэслэл гарган тайлбарлаж өөрийн байр суурийг илэрхийлнэ үү.
2. Сурвалж-1-ийг ашиглан “Шинэ үе” бүлгэмийн ухуулах хуудасны агуулга, ач холбогдлыг тодорхойлоорой.
3. Сурвалж-2-т тулгуурлан МоАХ-ны анх тавьсан шаардлагуудыг өнөө үетэй харьцуулж, биөлсэн болон биелээгүй зорилтыг ялган тодорхойлно уу.
4. Сурвалж-3-ыг судлан шинжлээд өөрийн үнэлэлт дүгнэлт өгнө үү.
5. 1990 оны хувьсгалын ач холбогдлыг тунгаан бодож, жагсаан бичээрэй.

## 2. Улс төрийн тогтолцоонд гарсан өөрчлөлт

МАХН дангаар ноёрхох эрх дарх үгүй болсноор улс төрийн нөхцөл байдал улам бүр чөлөөтэй болов. Монголын Үндэсний Дэвшлийн Нам (МУДН), Чөлөөт хөдөлмөрийн нам (ЧХН), Монголын Социал Демократ Нам (МСДН) зэрэг шинэ шинэ намууд байгуулгадав. 1990 оны 4-р сард эрх баригч МАХН-ын Онц их хурал хуралдаж, МАХН-ын мөрийн хөтөлбөр, дүрмийг шинэчлэн, Ю.Цэдэнбал, түүнийг тойрон хүрээлгчдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх комисс байгуулжээ.

4-р сарын 27-нд Ялалтын талбайд өргөн олны цуглаан болов. Цуглаанд оролцогчид Сүхбаатарын талбайд ирж, Засгийн газрын ордныг горооолон жагсаж, Ардын Түр Хурал байгуулах, ард түмний Онц зөвлөлийг улс төрийн хүчинүүдийн эрх тэгш оролцоотой байгуулах, НТХ-г Засгийн газрын ордоос гаргах зэрэг шаардлагад хариу нэхсэн юм.

Намуудын дунд уулзалт хэлцэл явагдаж, **АИХ, Улсын Бага Хурлыг** (УБХ) сонгох тохиролцоонд хүрчээ. АИХ-ын 1990 оны 5-р сарын чуулганаар Үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулав. Төрийн эрх барих байгууллагын бүтцийг өөрчлөн шинэчилж, хоёр танхим бүхий парламенттай байхаар хуульчилжээ. Төрийн эрх барих дээд байгууллага нь АИХ байх, хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах байнгын байгууллага нь Улсын Бага Хурал (УБХ) байх, БНМАУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаал бий болгох, Сн3-ийг Засгийн газар болгохоор тогтоов.

Улс төрийн намуудын тухай хууль батлагдаж, Улсын Дээд шүүх МАХН, МоАН, МУДН, ЧХН, МСДН, Монголын Ногоон Нам (МНН)-ыг албан ёсоор бүртгэнсээр Монголд олон намын тогтолцоо баталгаажив. Эдгээр нь улс төрийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх анхны алхмууд байв.

**Сурвалж-1:** “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаага явуулах зарилтын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.

...Нам үйл ажиллагаандaa дараах нийтлэг зарчмыг баримтална: ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тээг байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх; үйл ажиллагаагаа ил тод явуулах; гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдохойд үндэс, угсаас, арьсны өнөө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох; дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэх; бусад намын үйл ажиллагаанд хүндэтэглэтий хандах, дотоод хэрэгтэй нь хөндлөнгөөс үл оролцох, өөрийн үзэл баримтлалыг тулган шаардахгүй байх; үйл ажиллагаагаа нутаг дээвсэрийн зарчмаар явуулах; Монгол Улсаас гадаад улстай тогтоосон найрамдалт харилцаа, хамтын ажиллагаагаа эрхэмлэн хүндэтгэх”.

Улс төрийн намын тухай хуулийн 4, 5-р зүйлээс.

Монголын түүхэнд анхны олон намын оролцоотой, **чөлөөт, ардчилсан сонгууль** 1990 оны 7-р сарын 22-29-нд явагдав. Шинээр сонгогдсон АИХ-ын 422 депутатын 357 нь МАХН, 16 нь МоАН, 6 нь МУДН, 4 нь МСДН-ын гишүүн, 39 нь нам бус байлаа.

**Ардчилал.** Ард түмний засаг гэх утга агуулжтай. Гол зарчмын буюу үнэт зүйл нь шударга ёс, ил тод байдал, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, олонхийн саналыг хүлээн зөвшөөрөх зэрэг болно.

Шинээр сонгогдсон АИХ БНМАУ-ын Ерөнхийлөгчийг сонгох асуудал хэлэлцэхэд П.Очирбат, Ц.Лоохууз нар нэр дэвшиж, П.Очирбат БНМАУ-ын анхны Ерөнхийлөгчөөр сонгогдов. Дэд ерөнхийлөгч, УБХ-ын даргаар Р.Гончигдоржийг сонгов.

УБХ-ыг дарга, орлогч, нарийн бичгийн дарга болон 50 гишүүнтэй байгуулж, МАХН-32, МоАН-10, МҮДН-3, МСДН-3, гишүүн бусчууд-4 суудал авчээ. УБХ Ерөнхий сайдаар Д.Бямбасүрэн (МАХН), тэргүүн шадар сайдаар Д.Ганболд (МҮДН), шадар сайдаар Д.Пүрэвдорж (МАХН), Д.Дорлигжав (МоАН) нарыг томилов. Энэ нь хамтын хариуцлага хүлээн кабинетийн зарчмаар ажиллах, олон намын оролцоотой эвслийн Засгийн газар байлаа.

УБХ Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулж, ард нийтээр хэлэлцүүлсэн нь цоо шинэ үйл явдал байсан юм. Үүний үр дунд 1992 оны 1-р сарын 13-нд Монгол Улсын **шинэ Үндсэн хуулийг** баталсан нь өнөөгийн ардчилсан тогтолцоо бүрэлдэн төлөвших үндэс болсон юм.

**Сурвалж-1:** “Монголын ард түмэн бид: улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж; хүний эрх, эрх чөлөө, шудрага ёс, үндэснийхээ зэв нээдлийг эрхэмлэн дээдэлж; төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж; хун төрөлхтний соёл иргэншилийн ололтыг хүндэтгэн үзэж; эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”.

Монгол Улсын Үндсэн хуулиас. (1992)

Үндсэн хуулиар Монгол Улс парламентын засаглалын тогтолцоонд шилжив. Үүнд хууль тогтоох (УИХ), гүйцэтгэх (Засгийн газар), шүүх засаглалын эрх мэдлийг салган тогтоов. Ардчилал, хууль ёсыг хамгаалах дээд байгууллага - **Үндсэн хуулийн Цэц хэмээх** цоо шинэ байгууллагыг бий болгов.

Шинэ Үндсэн хуулийн нэг онцлог тал бол хүний эрх, эрх чөлөөг хамгийн өргөн утгаар хуульчлан бататгасан явдал юм.

**Сурвалж-2:** Үндсэн хуулинд, Монгол Улсын иргэд: “амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөрөнгө шүдараар олж авах, эзэмшин, өмчлөх, өв замгамжлуулах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, шууд буюу төлөвлөгчдөөр уламжлан төрийн үедирадах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох, сайн дураараа эзлэлдэн нэгдэх, нас хүйсээр үл ялгарварлах, халдашгүй чөлөөтэй байх, эрхээ хамгаалахаар шүүхэд гомдол гаргах, шашин шутэх, эс шутэх, үзл бодлоо чөлөөтэй шлэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх, мэдээлэл хайх, чөлөөтэй зорчих, гадаадад явах, эргэж ирэх эрхтэй” гэж заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулиас. (1992).

Шинэ Үндсэн хуулийн дагуу 1992 оны 6-р сард бүх нийтийн, чөлөөт ардчилсан сонгууль хоёр дахь удаагаа явагдав. Сонгуульд МАХН үнэмлэхүй ялалт байгуулж, 70 суудал авчээ. УИХ-ын даргаар Н.Багабандийг, Ерөнхий сайдаар П.Жасрайг сонгож, МАХН дангаараа Засгийн газраа бүрдүүлэв.

Шинэ Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхны сонгууль 1993 онд явагдав. Л.Түдэв, П.Очирбат нар өрсөлдөж, МҮДН, МСДН-ын эвслээс нэр дэвшсэн П.Очирбат Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогджээ. Тэр үеэс Монгол Улсын Ерөнхийлөгчийг бүх ард түмний сонгуулиар тодруулах болсон билээ.

Харин 1996 оны 6-р сарын 30-нд явагдсан УИХ-ын сонгуульд **Ардчилсан холбоо эвсэл** ялалт байгуулж, 50 суудал, МҮНН 1 суудал тус тус авчээ. Тийнхүү олон жил эрх барьсан туршлагатай, нэр хүндтэй, боловсон хүчний их нөөцтэй, улс төрийн томоохон хүчин МАХН-ыг Ардчилсан хүчин анх удаа ялж, эрх баригч хүчин болсон юм. Р.Гончигдорж УИХ-ын дарга, Ц.Элбэгдорж дэд даргаар сонгогдов. Монгол Улсын Ерөнхий сайдын тамгыг М.Энхсайхан гарджээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль 1997 онд явагдаж, МАХН-

аас нэр дэвшигч Н.Багабанди ялалт байгуулав. Ардчилсан холбоо эвслийн засгийн газар тогтвортой ажиллаж чадаагүй учир М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, Ж.Наранцацралт, Р.Амаржаргал нарын 4 Ерөнхий сайдын нүүр үзсэн юм.

2000 оны 7-р сарын 3-нд явагдсан УИХ-ын ээлжит сонгуулиар МАХН 76 суудлын 72-ыг авчээ. Л.Энэбиш УИХ-ын дарга болж, Н.Энхбаяр Ерөнхий сайдаар томилогдов.

Ялагдалдаа дүгнэлт хийсэн МУАН, МСДН, МАН, МШАН, МАСМН нэгдэж, 2000 оны 12-р сарын 6-нд **Ардчилсан намыг** байгуулсан байна.

Шинэ зуун, шинэ мянганы эхний жилүүдэд Монгол Улсад парламентын сонгууль 4 удаа болж, 2004 онд МАХН-Эх орон-Ардчилал эвсэл, 2008 онд МАХН-Ардчилсан Нам хамтарч Засгийн газраа байгуулсан бол 2012 онд илуу олон суудал авсан Ардчилсан Нам, МАХН-МУАН-ын Шударга ёс эвсэл, Иргэний Зориг-Ногоон намтай хамтарсан Засгийн газар байгуулан ажиллаж, 2016 оноос МАН дангаараа эрх барьж байна.

Монгол Улс ардчилсан шинэ Үндсэн хуулиа батлан мөрдөж ирсэн өнгөрсөн 25 жилийн хугацаанд манай орны улс төрийн амьдралд зарчмын шинжтэй олон өөрчлөлт, шинэчлэлт гарав. Парламентийн засаглал, улс төрийн ардчилалд бид суралцаж, эрх зүйн шинэчлэл үргэлжилсээр байна. Өнгөрсөн хугацаанд иргэний нийгмийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох олон нийтийн байгууллага (ТББ), иргэний эвсэл, хөдөлгөөнүүд олноор байгуулагдаж, ардчилал, шинэчлэлд хувь нэмрээ оруулсаар ирэв.

1. Өгсөн мэдээллийг шинжлэн судалж, 1990 оны 5-р сард Үндсэн хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтийн ач холбогдлыг тодорхойлоно уу.
2. 1990 оны сонгуулийн үр дүнд тулгуурлан АИХ, УБХ-д нам, хүчинүүдийн эзлэх суудлын хувийг тооцож, график, диаграмм байгуулаарай.
3. Сурвалж-1-д тунхагласан эрхэм зорилгоо бид хэр биелүүлж байгааг задлан шинжилж, өөрийн үнэлэлт дүгнэлт өгч, үндэслэлээ тайлбарлана уу.
4. Сурвалж-2-т заасан эрхүүдээс Таны эдэлж байгаа болон эдлээгүй эрх юу байгааг үндэслэл, нотолгоо гарган тайлбарлана уу.
5. Монгол Улсын өнөөгийн улс төрийн амьдралд ямар олопт амжилт, ямар согог дутагдал байгааг тодорхойлж, үнэлж дүгнээрэй.

### 3. Нийгэм-эдийн засгийн тогтолцооны шинэчлэл

1990 оны хувьсгалын үр дүнд Монгол Улсад зах зээлийн нийгэмд шилжих үйл явц эхэлж, **төвлөрсөн төлөвлөгөөт** эдийн засгийн тогтолцоог халах, нийгэм-эдийн засгийн шинэ харилцааг бий болгоход чиглэгдсэн олон арга хэмжээ авч, хэрэгжүүлж эхлэв.

1991 онд Монгол Улсын Иргэний хуулийг шинэчилж, иргэд **хувийн өмчтэй байх**, төрөөс бүх хэлбэрийн өмчийг хуулиар адил тэгш хамгаалах явдлыг хуульчлан баталгаажуулав. УБХ-аас Албан татварын, Гаалийн, Өмч хувьчлалын, Аж ахуйн нэгжийн, Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай зэрэг олон хуулийг батлан гаргажээ. Эдгээр хуулиуд улс орны эдийн засгийг **зах зээлийн** харилцаанд шилжүүлэх эрх зүйн үндэс болсон юм. Олон улсын валютын сан (ОУВС), Олон улсын банк, Олон улсын санхүүгийн корпорац, Олон улсын хөгжлийн ассоциац зэрэгтэй албан ёсоор харилцах болсноор эдийн засгийн нээлттэй гадаад бодлого явуулах, хөнгөлөлттэй зээл тусламж, мэдээлэл зөвлөгөө авах боломж нэмэгдэв.

Зах зээлийн эдийн засагт шилжих алхмуудыг Д.Бямбасүрэнгийн тэргүүлсэн Засгийн газар анхлан хэрэгжүүлсэн юм. Шилжилтийн мөрийн хөтөлбөрийг ОУВС-тай хамтран боловсруулсан байна.

Засгийн газар өмч хувьчлалын асуудалд гол анхаарал хандуулж, хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр **өмч хувьчлах** арга хэмжээг зохион байгуулав. Өмч хувьчлалыг төв, орон нутагт байгуулагдсан үнэт цаасны бирж, брокерийн пүүсүүдээр дамжуулан зохион байгуулж, хөрөнгө оруулалтын их, бага эрхийн бичгээр хувьчилжээ.



Зураг 4. Их хувьчлалын 7000 төгрөгтэй дүйх  
"Цэнхэр" тасалбар

шилжүүлжээ. Малын 90 гаруй хувь нь малчдад очив. Их хувьчлалаар Хөдөө аж ахуйн нэгдлүүдийг оролцуулан 14 тэрбум төгрөгийн хөрөнгө бүхий 1200 орчим том үйлдвэр, аж ахуйн газрыг хувьчилжээ.



Зураг 5. Картын барааны  
үеийн талхны талон

Үнэ чөлөөлөх, чөлөөт үнийн тогтолцоо бий болгох алхмуудыг хийв. 1991 оны 1-р сард гаргасан **Засгийн газрын 20-р тогтоол** эхний дуулиант алхам байлаа. 1990-ээд оны эхээр үнийн 90 гаруй хувийг чөлөөлж, зах зээлийн зүй тогтоор үнэ бүрдэх тогтолцоог нэвтрүүлэв. Нөгөөтэйгүүр, хүн амын амьдралын доод түвшинг баталгаажуулах үүднээс өдөр тутмын зайлшгүй хэрэгцээт 16 үндсэн нэрийн хүнсийг картаар олгох болсон юм.

Мөн өргөн хэрэглээний бараа, цахилгаан эрчим хүч, ус, дулаан, орон сууцны болон хотын тээврийн үйлчилгээний үнэ, тарифыг төрөөс хянан тогтоож байлаа. Тийнхүү чөлөөт үнийн тогтолцоонд үндсэндээ шилжсэн нь зах зээлийн эдийн засагт шилжих, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн чухал арга хэмжээ байв.

Аж ахуйн нэгжийн тухай хууль баталж, Засгийн газар хувийн хэвшлийг дэмжих бодлого явуулснаар олон мянган Хувиараа Эрхлэх Аж Ахуй (ХЭАА), бүрэн ба бүрэн бус хариуцлагатай хоршоод, олон зуун хувьцаат болон бүрэн бус хариуцлагатай компаниуд байгуулагджээ. Монгол Улсад **өмчийн олон хэлбэр** бодитойгоор оршин тогтонох болов.



**Зах зээлийн эдийн засаг.**  
Хувийн өмч, чөлөөт өрсөлдөөнд тулгуурласан, зах зээлийн хууль болох эрэлт, нийлүүлэлтээр зохицуулагддаг эдийн засаг.

Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар зах зээлийн эдийн засгийн харилцааг хуульчлан баталгаажуулсан юм.

**Сурвалж-1:** "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлоогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалана. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна". Монгол Улсын Үндсэн хуулиас. (1992).

Монгол Улс зах зээлийн эдийн засгийг үр нөлөөтэй болгох, чөлөөт тогтолцоонд шилжүүлэх, өмчлөгчийн эрхийг баталгаажуулах, эд хөрөнгөтэй холбоотой бусад харилцааг зохицуулахад чиглэсэн олон хууль тогтоомж батлан мөрдөж иржээ.

Зах зээлийн тогтолцооны амин чухал асуудал болох газрын харилцааг шинэчлэв. 1994 онд УИХ "Газрын тухай хууль" баталж, газар нь улс гурний тусгаар тогтнол, бүрэн эрхийн баталгаа, ард түмний үе уламжлагдах өв хөрөнгө мөн гэсэн зарчмыг тусгасан юм. Газар эзэмших, ашиглах, хамгаалах зэрэг харилцааг хуулиар зохицуулах болов. Газрыг эхний ээлжинд 60 хүртэл жилээр эзэмших, нэг удаад 40 хүртэл жилээр сунгах, газар эзэмших эрхээ үе залгамжуулан шилжүүлэх, өөрийн эзэмшлийн газраа бусдад гэрээгээр ашиглуулах эрх нээгджээ.

Өмч хувьчлалын салбарт ахиц гарав. 1996 оны сонгуулиар байгуулагдсан УИХ орон сууцны тухай багц хуулиуд батлан гаргасан нь орон сууцны салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх, орон сууцыг иргэдийн хувийн өмчид шилжүүлэх эрх зүйн үндэс болов. Орон сууцыг Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүй хувьчлав. 1998 оны байдлаар 40000 орон сууц буюу нийт орон сууцны 50 хувь нь хувьчлагдсан байна.

Ардчилсан холбоо эвслийн Засгийн газар суурь үнийг чөлөөлөх сүүлчийн арга хэмжээг авч цахилгаан, эрчим хүч, шатахуун, нүүрсний үнийг чөлөөлөв. Үүгээр манай улс чөлөөт үнийн тогтолцоонд бүрэн шилжив.

Хот хөдөөд бизнес идэвхжиж, мал сүрэг өсч, газар тариаланд ахиц гарав. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсч, Монголд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэх болжээ. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр бараа таваар, үйлчилгээний хангамж эрс өөрчлөгдөв.

Сүүлийн 10 гаруй жилд мал сүргийн тоо өсөж, 2016 онд 60 саяыг давлаа.  
**Атрын III аян** өрнөн газар тариалангийн салбар сэргэн хөгжиж байна.

Уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, "Оюу Толгой", "Таван толгой" зэрэг томоохон төсөл хэрэгжиж эхлэв. Амжилт ололтын зэрэгцээ шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээл ч бидэнд тулгарсан юм. Ажилгүйдэл, ядуурал, нийгмийн зохисгүй үзэгдлүүд, ёс зүйн доройтол биднийг тойрсонгүй.

Монгол Улс өнгөрсөн хугацаанд зах зээлийн эдийн засгийн харилцаанд бүрэн шилжиж, аж ахуйн олон хэвшилтэй, чөлөөт үнийн тогтолцоотой, чөлөөт хөдөлмөр, хувийн өмчтэй болцгоож, улс орны өнгө төрх бүрэн өөрчлөгдөн хөгжиж байна.

1. Өмнөх мэдлэг, өгсөн мэдээлэлд тулгуурлан төлөвлөгөөт болон зах зээлийн эдийн засгийн зааг ялагас харьцуулан гаргаж, түүний учир шалтгааныг тайлбарлана уу.
2. "Картын барааны үеийн Монгол улс" сэдвээр ярилцлага зохиож, дүр зургийг гаргаарай.
3. Өмч хувьчлалд танай гэр бүл хэрхэн хамрагдсан талаар судалж, үнэлэлт дүгнэлт өгнө үү.
4. Сурвалж-1-д өгсөн Үндсэн хуулийн заалт амьдрал дээр хэрэгжиж байгааг шинжлэн дүгнэж, жишээ баримт гарган нотлон тайлбарлаарай.

#### 4. Оюун санааны хүрээн дэх хувьсал өөрчлөлт

1990 оны ардчилсан хувьсгалын бас нэг гол үр дүн бол монголчууд оюуны эрх чөлөө эдлэх, асуудалд ганц үзэл онолоор бус олон ургалч үзлийн үүднээс хандах бололцоо нээгдсэн явдал байлаа. МАХН нийгмийг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин байхаа больсноор марксизм-ленинизм дангаар ноёрхох боломжгүй болов. Монголчууд оюуны хүлээнээс ангижирч, чөлөөт сэтгэлгээ, үндэсний үзэл, өв уламжлал, шашин, соёлоо эрхэмлэн хөгжүүлэх боломжтой болсон юм.

Монголчууд үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөгөө жинхэнэ утгаар нь эдлэх болов. Үүний нэг илэрхийлэл нь том, жижиг олон зуун чөлөөт хэвлэл (сонин, сэтгүүл, радио, зурагт, төлөө суvgууд) бий болсон явдал юм. УИХ-аас 1998 онд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль” батлав. Энэ нь чөлөөт хэвлэлийн тогтолцоог хуульчилж, ардчилсан ёсны нэг чухал бүрэлдэхүүн, салшгүй хэсэг бодит зүйл болгосон хэрэг байлаа.

**Сурвалж-1:** “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглох, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт үл тогтоох, төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгслэлтэй байхыг хориглох...”

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас. (1998.8.28).

Олон мянган жилийн түүхээрээ, алдар цуут өвөг дээдсээрээ, өв соёлоороо бахархах, сэргээн хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх талаар багагүй амжилт олов. “Монголын нууц товчоо” зохиогдсоны 750 жилийн ойг 1990 оны 8-р сард бүх монголчуудын их баяр наадам болгон тэмдэглэсэн явдал үндэсний үзэл, ухамсар сэргэсний тод илрэл байв.

Эзэн богд Чингис хаанаа дээдлэн сүслэх болж, эртнээс уламжлалт 9 хөлт цагаан тугаа хүндэтгэн залав. Чингис, Өгэдэй, Хубилай 3 их хааныгаа төрийн ордны өмнө мөнхөлж, Их эзэн хааны мэндэлсэн өдрийг “Монгол бахархлын өдөр” болгон тэмдэглэх боллоо.

Монголын түүх судлалын шинэчлэл эрчимтэй өрнөж, олон арван судалгааны бүтээл хэвлэгдэн гарсны нэг нь тухайн үеийн судалгааны түвшинд бичигдэж, 2003 онд нийтийн хүртээл болсон “Монгол Улсын түүх” хэмээх 5 боть суурь бүтээл юм. Алдар нэрээ мөнхлөн үлдээсэн эх орончид, улс төрийн нэрт зүтгэлтнүүд, соён гэгээрүүлэгчдийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг бодитойгоор үнэлж цэgnэх болов.

Үндэсний монгол бичиг үсгээ сэргээх, зааж сургах ажил өрнөв. 1992 онд Засгийн газар “Албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай” тогтоол гаргажээ.

Монгол туургатны эв нэгдэл, хэл, соёлын хэлхээ холбоог хөгжүүлэхэд анхаарах болов. Монгол соёл, урлагийн нандин өв санг дэлхий дахинд хүргэх, таниулан сурталчлах өргөн боломж нээгдэв.

**Сурвалж-2:** “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншилаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн”.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.6 дахь заалтаас. (2010.7.15).

Ардчилал, шинэчлэлийн үеийн нэг томоохон ололт бол ард иргэдийн шүтэн бишрэх эрх чөлөө баталгаатай болж, энэ эрхээ эдлэх бодит боломж нээгдсэн явдал юм. Аймаг, хотууд, томоохон сум, суурин газрууд Буддын шашны сүм хийдтэй болжээ. 1993 онд Бурхан багшийн чандрыг Монголд залж, Буддын шашны

тэргүүн Далай лам Монголд хэдэнтээ айлчилсан нь шашин номын үйл сэргэсний илэрхийлэл юм.

Хэлмэгдлийн шуурганд өртөн сүйдсэн **Мэгжид Жанрайсиг** шүтээнийг бүтээн залах ажлыг Ерөнхийлөгчийн зарлигаар гүйцэтгэж, 1996 оны намар Гандантэгчинлэн хийдэд шашин, төрийн их ёслол үйлдэн нээжээ. Энэ нь Монголын бурхны шашны сэргэлт, оюун санаа, соёлын амьдралд болсон нэгэн том үйл явдал байлаа. Уул овооны тахилга сэргэж, бөө мөргөл дэлгэрэх болов. Шүтэн бишрэх эрх чөлөөг дагалдан бусад шашин ч Монголын нийгэмд дэлгэрэх болсон байна.

Хэлмэгдүүлэлтийн хор уршгийг арилгах талаар Монгол улсад өргөн цар хүрээтэй ажил өрнүүлж, улс төрийн хэргээр хэлмэгдсэн 36000 гаруй хүнээс 30000 гаруйг нь цагаатгаад байна. Монголын төр 1996 онд ард түмнээсээ училат гүйж, жил бүрийн **9-р сарын 10-ыг** улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон тэмдэглэх болсон юм.

1990-ээд оноос Монгол Улс мэдээлэл, технологийн "далай"-д хөл тавин оров. Харилцаа холбоо, цахим өртөнцийн хөгжлөөс бид хоцорсонгүй. Монголчууд электрон технологи бүтээж, цахим сүлжээ чөлөөтэй ашиглаж, дэлхий дахини мэдээллийг цаг алдалгүй авдаг боллоо. Өндөр хурдаар мэдээлэл дамжуулах интернэт сүлжээ нэвтрэв.

Спортын өртөнцөд тив, дэлхийн аваргууд олноор төрж, жудо, боксын тамирчид Олимпийн алтан медалийг эх орондоо анх удаа авчирсан нь монгол түмний баходхлыг өндөрт өргөв. Энэ үйл явдал үндэсний үзэл сэтгэлгээг хөгжөөсөн, эв нэгдлийг сэргээсэн хөөр баярыг монголчуудад бэлэглэсэн юм.

Даяаршлын энэ эрин үед үндэсний ухамсар, оюуны дархлаагаа алдаж гээлгүй өвлөн хадгалж үлдэх нь монгол хүн бүрийн журамт үүрэг болно.

1. Нэг үзэл сурталд баригдах, олон ургалч үзлээр асуудалд хандах хоёрны ялгаа, давуу болон суп талуудыг жагсаан бичнэ үү.
2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө яагаад чухал болох тухай дүн шинжилгээ хийнэ үү.
3. Түүх, соёл, өв уламжлалаа судлах, түүнээс суралцахын ач холбогдлыг тодорхойлно уу.
4. Үндэсний үзэл, үндэсний ухамсар гэх ухаадахууны утга агуулгыг тайлбарлаарай.

## 5. Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжсөн нь



Монгол Улсын гадаад бодлогын үндэснүүдэд үзэл баримтлал, гол зарчим юу вэ?

Монгол Улс Үндэсний аюулгүй байдлаа хангахын тулд ямар бодлого баримтлах учиртай вэ?

Улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын асуудал өнөөгийн ардчилсан Монгол Улсын төрийн бодлогын анхаарлын төвд үргэлж байсаар ирсэн юм.

Монгол Улс ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэнээр гадаад бодлогын үзэл баримтлал өөрчлөгдөж, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулах болов. Тэрчлэн улс орныхо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах шинэ үзэл баримтлал боловсруулах шаардлага тулгарсан юм. Тиймээс 1994 онд "Гадаад бодлогын үзэл баримтлал", "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" (2007, 2010 онд шинэчилсэн) батлан гаргав. Тэдгээрт улс төр, дипломатын аргаар тусгаар тогтнол, аюулгүй байдлаа баталгаажуулахад чиглэсэн Монгол төрийн бодлого тусгалаа олсон юм.

**Сурвалж-1:** "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтоно, Монгол Улсын тусгаар тогтолцол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсээр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцээрт хөгжлийн багтана.

Монгол Улсын тусгаар тогтолцол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн.

Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд сууринласан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн. Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангаждсанаа Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна.

Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншилаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтоноын үндэс, амин чухал дархлаа мөн".

"Монгол Улсын иргэн бүрийн үндэсний унэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх, эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ црээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно".

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаас. (2010.7.15).

Ардчилллын эхний жилүүдэд Монгол Улс газар нутгаа цөмийн зэвсэггүй орны өвөрмөц статустай болгосон нь олон улсын хэмжээнд аюулгүй байдлаа бэхжүүлэхэд чиглэсэн алхам байв. Энхийг эрхэмлэсэн гадаад бодлогоо тууштай баримталж, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжин ажиллаж байна. Үүний тодорхой илрэл нь Монголын Улс **энхийг сахиулах** болон терроризмтай тэмцэх олон улсын ажиллагаанд цэргийн бие бүрэлдэхүүнээ оролцуулах болсон явдал юм. Энэ нь манай улсын нэр хүндийг олон улсын тавцанд зүй ёсоор өргөж байна. Тэрчлэн олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлж ирлээ.



Зураг 6. Монголын энхийг сахиулагчид

орны хөгжилд ихээхэн тус дэм болж байна. Олон улсын тавцанд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, бус нутгийн интеграцид оновчтой оролцох, нөлөө бүхий улс орнуудын ашиг сонирхлыг тэнцвэржүүлсэн бодлого хэрэгжүүлэх, хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн идэвхтэй гадаад бодлого нь улс орны тусгаар тогтол, аюулгүй байдлыг ханган бататгах гол хүчин зүйлийн нэг мөн.

Төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх нь манай улсын гадаад бодлогын нэг чухал зарчим билээ.

Монгол Улс	180	эдүээ
дэлхийн	гаруй	
уплатай дипломат харилцаатай,		
30 гаруй оронтой 2 талын		
худалдаа-эдийн засгийн хамтын		
ажиллагааны гэрээтэй, НҮБ,		
Дэлхийн худалдааны байгууллага,		
АСЕМ зэрэг 20 гаруй олон улсын		
байгууллагын гишүүн юм.		

**Сурвалж-2:** Монгол Улсын “оршин тогтохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал”, “хүний аюулгүй байдал”, “хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал” харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаас. (2010.7.15.)

Монгол Улсын тусгаар тогтолц, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтохуйн аюулгүй байдлын үндэс билээ.

Тэрчлэн хүн ам, удмын сангийн болон соёл иргэншлийн аюулгүй байдлаа хангахад Монголын түүх, хэл, соёл, шашин, ёс заншлаа уламжлан хадгалах, хамгаалах, хөгжүүлэх, судлах явдал чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

**Эдийн засгийн аюулгүй байдлаа** хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл билээ. Эдийн засгийн хараат байдлаас ангижрах нь үндэсний аюулгүй байдлын нэгэн баталгаа юм.

Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуулт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрөө бэхжүүлж, улс төрийн тогтвортой байдлыг хангах нь **дотоод аюулгүй байдлын** үндэс мөн.

Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь **хүний аюулгүй байдлыг** хангах үндэс билээ.

Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөвлөрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшигийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, **хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах** үндэс билээ.

**Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад** үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах явдал чухал юм.

Хурдтай хувиран өөрчлөгдж байгаа өнөө үед улс орныхоо эрх ашиг, тусгаар тогтолц, бүрэн эрхт байдлыг бататгахын тулд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа бүрэн хэрэгжүүлэх, уян хатан, ухаалаг гадаад бодлого явуулах шаардлага тулгарч байна. Үүнд ард иргэдийн үүрэг оролцоо ч чухал юм. Монгол Улс нэр нөлөөгөө олон улсын тавцанд улам бэхжүүлэх өөдрөг ирээдүй бий.

1. Монгол Улс хоёр хөрштэйгээ сайн харилцаатай байхын утга учир, ач холбогдол юунд орших вэ?
2. Их өрийг тэглэсний ач холбогдлыг тодорхойлоорой.
3. Гадаад харилцаа хамтын ажиллагааны үр өгөөж болон эерэг ба сөрөг талыг харьцуулж оюун дүгнэлт хийгээрэй.
4. Сурвалж-1-ийг судлан шинжлээд гол утга санааг жагсаан бичиж, холбоо хамаарлыг нь зураглан гаргаарай.
5. Сурвалж-2 болон бусад мэдээлэлд тулгуурлан Үндэсний аюулгүй байдлаа баталгаажуулахад иргэд, та өөрөө ямар хувь нэмэр оруулж болох талаар санал бодлоо илэрхийлээрэй.

## НЭМЭЛТ БОЛГОН АШИГЛАХ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

**Нэг. Сурвалж, баримтын эмхэтгэл:**

1. Монголын түүхийн дээж бичиг. III боть. Эмх. Г.Сүхбаатар, Л.Жамсран. УБ., 1995
2. ХХ зууны Монголын түүхийн эх сурвалж: Автономит Монгол улсын үеийн онцлог баримт бичгүүд (1911-1921). Эмх. Л.Дэндэв. УБ., 2003
3. Коминтерн ба Монгол (Баримтын эмхэтгэл). Эмх. Ч.Дашдаваа ба бусад. УБ., 1996
4. Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1920-1952). 1-3-р боть. Эмх. С.Дамдинсүрэн ба бусад. УБ., 2002, 2005, 2009
5. Монгол Улсын Үндсэн хууль. Эмх.Ж.Амарсанаа, О.Батсайхан. УБ.,2011
6. 1990 оны ардчилсан хөдөлгөөний түүхэнд холбогдох баримт бичгүүд. Тэргүүн дэвтэр. Эмх. Ж.Заанхүү. УБ., 2004

**Хоёр. Ном бүтээлүүд:**

1. БНМАУ-ын түүх. II, III боть. УБ., 1969
2. Монгол Улсын түүх. IV, V боть. УБ., 2003
3. Монгол Улсын түүх. Ер.ред. П.Дэлгэржаргал нар. УБ., 2017
4. Монголын соёлын түүх. II-III дэвтэр. Ер. ред. Б. Сумьяа. УБ.,1999
5. Амарсанаа С. Ардчилалд хөл тавьсан 10 жил. УБ.,2016
6. Баабар Б. Монголчууд: нүүдэл суудал. Нэмж засварласан 3 дахь хэвлэл. УБ., 2009.
7. Батбаяр Ц. Монгол ба их гүрнүүд ХХ зууны эхний хагаст. (Хиагтаас Ялта хүртэл: Сталин, Чан Кайши, Монголын тусгаар тогтол). УБ., 2006
8. Батсайхан О. Монголын тусгаар тогтол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (1911-1916). УБ., 2002
9. Болд Р. Зарлаагүй дайн. Халхын голын байлдааны цэрэг-дипломатын түүх. Хянан тохиолдуулсан: Ж.Болдбаатар, М.Ганболд. УБ., 2014
10. Болдбаатар Ж, Ч.Дашдаваа, Г.Дашням бусад. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал: хувьсал, өөрчлөлт. (ХХ зуун). УБ., 2008
11. Болдбаатар Ж, Дашдаваа Ч. Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн, түүний хувь заяа (1952-1966). УБ.,2005
12. Дашдаваа Ч.Улаан түүх (Коминтерн ба Монгол). УБ.,2003
13. Дэндэв Л. Монголын товч түүх. - Монголын эх түүх. Цуврал. VI боть. УБ., 2015
14. Жамсран Л. Монголын сэргэн мандалтын эхэн (1911-1913). УБ.,1992
15. Магсаржав Н. Монгол Улсын шинэ түүх. - Монголын эх түүх. Цуврал. V боть. УБ., 2015
16. Нацагдорж Ш. Халхын хураангуй түүх (1691-1911). УБ., 1963
17. Оюунжаргал О. Манж Чин улсаас монголчуудыг захирсан бодлого (Ойрадуудын жишээн дээр). УБ., 2009
18. Өлзийбаатар Д. 1937 он. Яагаад?. УБ., 2001
19. Санждорж М. Монгол төрийн түүхээс (XIII-XIX зуун). УБ., 1998
20. Сономдагва Ц. Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт (1691-1997). УБ., 1998
21. Урангуга Ж. ХХ зууны эхэн үеийн Монгол Улс (1911-1919). УБ., 2006
22. Хишиг Н. Монголын хувьсгал: 1921. УБ., 2011
23. Цолмон С. Галдан бошгот хаан (1644-1697). УБ., 2003
24. Чойбалсан Ч, Лосол Д, Дэмид Г. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. УБ., 1979
25. Ширэндэв Б.Монгол ардын хувьсгалын түүх. (2 дахь хэвлэл). УБ., 1999

**Гурав. Зурагт ном, толь бичиг, цахим мэдээллийн сан:**

1. Монголчууд (XVII-XX зууны эхэн үе). Зурагт ном. Ер. Ред. С.Чулуун. УБ.,2014
2. Монголчууд нийгэм журамд давшин орсон нь: 1924-1959. Зурагт ном. Ред. О.Батсайхан. УБ.: Монсдар, 2016.
3. Британика Монгол. Хураангуй толь. 2 боть. УБ.,2012
4. <https://mongoltoli.mn/history/>
5. <http://mongol.undesten.mn>
6. <https://mn.wikipedia.org/>